МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ



Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ахлах ажилтан, Монгол Улсын гавъяат хуульч, доктор, профессор, хурандаа А.Лхагваа

Монгол улсын төр аливаа гэм буруутай этгээдийн хэргийг шүүн хэлэлцэхдээ төрт ёсоо дээдлэн ялд унагаж, түүний ялыг эдлүүлж ирсэн өнө эртний түүхтэй ч энэ удаад байдлыг Ардын хувьсгал ялан мандсан 1921 оны дараа үеэс эхлэн авч үзэв.

Ардын Намын төв хороо, түр Засгийн газрын хамтарсан хурал 1921 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Нийслэл хүрээнд болж Засгийн газрын яамдыг шинээр байгуулахад дотоод, гадаад, ерөнхий гурван хэлтэстэйгээр Шүүх яамыг байгуулсан байна. Энэ яамны ерөнхий хэлтсийн харъяанд "Гяндан салаа"-г байгуулснаар одоогийн хорих ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагааны эх үүсвэр тавигджээ. Иймд хувьсгалын дараах гяндан салаа, хожмын Засан сайжруулах газар буюу Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага, эдүгээгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага анх 1921 оны 7 дугаар сарын 10-нд үүсэн байгуулагдсан гэж үзэх түүхэн болон эрх зүйн бүрэн үндэслэлтэй.

Ардын түр Засгийн газраас гяндан хорооны газрын талаар авч хэрэгжүүлсэн хувьсгалт арга хэмжээний эхнийх нь хаант Монгол Улсын үеийн хуучин гянданг устгаж шинэчлэхэд чиглэгдэж байв.

Ардын Засгийн газраас 1921 онд Цээжидийн Гүрсэдээр удирдуулсан комисс томилж "Нийслэл хүрээний их гяндан", "Их шавийн гяндан", "Баруун хүрээний гяндан" зэргийг нягтлан шалгаж, тэдгээрт хоригдож байсан иргэдийг суллан тавьсан байна. 1921 оноос шинэчлэн байгуулагдаж эхэлсэн анхны гяндангийн даргаар Цэцэн хан аймгийн харцага чин ван Намжилдэндэв Вандандоржийн хошууны /одоогийн Хэнтий аймгийн Норовлин сум/ харъяат Санжмятав гэдэг хүн ажиллаж байсан тухай хуульч агсан Л.Чүлтэмсүрэн өөрийн бүтээлдээ дурдсан байдаг .

Монгол улсын тулгар төрөөс ял эдлүүлэх байгууллагаа шинэчлэн хөгжүүлэхэд ихээхэн анхаарч, дэс дараатай олон чухал арга хэмжээ авч хэрэгжүүлж ирсний баримт олон бий.

1924 оны 11-р сард хуралдсан Улсын Анхдугаар Их Хурал, мөн онд хуралдсан Монгол Ардын Намын III их хурлаас хувьсгалт Монгол Улсын Хорих ял эдлүүлэх байгууллагын практик үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын үндсэн чиглэл зарчмыг тодорхойлж өгсөн байна. Тухайлбал:

МАН-ын III их хурлын тогтоолд: "Гянданаа хоригдож буй хэрэгтэн ардыг үйлдвэрт сургах, сургаж гэгээрүүлэх, аливаа шүүхийн тогтоолгүйгээр хэнийг ч хорихгүй байх, гяндан хорооны байдал нэн муу байгааг даруй сайжруулах, насанд хүрээгүй хөвгүүд, охид хэрэгт холбогдох аваас гянданаа хорихгүйгээр гэгээрүүлэх, аливаа хэрэгтэн ардын дотроос хүн төлөв, засрах байдалтайг нь гянданаа хорихгүйгээр үйлдвэр хийлгэвэл зохих" зэргийг онцлон заажээ.

Мөн Улсын Анхдугаар Их хурлын тогтоолын Шүүх яамны тухай хэсэгт: "Их гяндан ба улсын доторхи олон албан газруудын байдлыг цөм Европын байдалд нийцүүлэх, аливаа ялтан, хэрэгтний бие мах бодид харшгүй, зохих гяндангуудыг шинэчлэн байгуулах,

ялтнуудыг үйлдвэрт зүтгүүлэх, сурган гэгээрүүлэх ажлыг харьяа Шүүх яамнаас даруй эрхлэн явуулахын чухал"-ыг заан тэмдэглэсэн явдал бол энэ байгууллагын цаашдын хөгжилд чухлаар нөлөөлсөн юм.

Засгийн газрын 1925 оны 4-р сарын 11-ний өдрийн 12 дугаар хурлаас "Их гянданг сайжруулах тухай" дүрэм боловсруулсныг хэлэлцээд дахин хянах шийдвэр өгчээ. Комиссын дахин боловсруулсан "Их гянданг сайжруулах тухай" 16 зүйлт дүрмийг Засгийн газрын 1925 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталж, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг Шүүх яаманд өгөгдсөн байна.

Хорих ял эдлүүлэх байгууллагыг шинэчлэн зохион байгуулах, тэнд хоригдогсдыг ажил үйлдвэрлэлд хамруулах, сургаж гэгээрүүлэх, хүмүүжүүлэх болон ахуйн нөхцлийг сайжруулахад ихээхэн анхаарч байсны тод жишээ бол Ардын Нам, Засгийн газраас хувьсгалын эхний 5 жилд 10-аад тогтоол гаргаж тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээнүүдийг зохион байгуулж, түүндээ зохих байгууллага төдийгүй ард иргэдийн хүч туслалцааг авч ажиллаж байсан явдал юм. Зөвхөн нэг баримт дурдахад, Засгийн газрын 1924 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 13 дугаар хурлаар улсын төв гяндангийн шинэ барилга бариулах тухай хэлэлцээд энэ зардалд зориулан Сангийн яамнаас 7500 лан мөнгө гаргах, барилгын ажлыг Шүүх яаманд хариуцуулахаар шийдвэрлэж байжээ. Хувьсгалт шүүхийн байгууллага үүсч хөгжсөний 10 жилийн ойтой холбогдуулан гарсан нэгэн илтгэх хуудсанд "Улсын 6 дугаар Их хурлын тогтоол ёсоор улсын доторхи гяндангуудыг Засан сайжруулах газар, Улаанбаатар хотын гянданг улсын төв засан сайжруулах газар хэмээн тус тус нэрлэж байх болсон" тухай тэмдэглэжээ. Энэ байдлыг судлан үзвээс анх 1921 онд байгуулагдсан гяндан салааг 1930 оноос эхлэн Засан сайжруулах газар гэж нэрлэх болсон байна. Мөн энэ үеэс эхлэн ялтныг харж хамгаалах албаны хүмүүсийг хуяг гэж нэрлэж байснаа өөрчилж харгалзагч хэмээн нэрлэхээр болжээ.

Засан сайжруулах газрыг 1936 онд Дотоод явдлын яаманд шилжүүлэн өгсөн Засгийн газрын комиссын илтгэх хуудсанд тэмдэглэснээр шинэ гяндангийн барилга нь ихээхэн гэрэл гэгээ бүхий цонхтой, 18 тасалгаатай, чулуун суурь, төмөр дээвэртэй, туйпуугаар үйлдэгдсэн их байшин ба мөн албан хэрэг явуулах контор хийгээд харуул манааны байр, гал тогоо, больництой байжээ.

Засан сайжруулах газар Дотоод явдлын яаманд шилжиж ирэхдээ 1930-1936 онд байгуулагдсан зөөлөн үйлдвэр, барилга, газар тариалангийн зэрэг 13 салбар үйлдвэртэй, 265184 төгрөгийн ашигтай, 1936 оны эхний хагас жилийн төлөвлөгөөг 108 хувиар биелүүлсэн дүнтэй, зөвхөн төвдөө 700-аад ялтантай байсан тухай Засгийн газрын комиссын актанд дурдсан байдаг. Улаанбаатар хотод 1936 онд ажиллаж байсан Цэргийн яамны болон Дотоод явдлын яамны Засан сайжруулах газруудыг нэгэн адил Дотоод явдлын яаманд харъяалуулах зохион байгуулалт хийгдсэнээр хорих ял эдлүүлэх ажиллагаа нэгэн удирдлагад төвлөрчээ. 1936-1940 онд ял эдлэгсдийн жилийн дундаж тоо 7000-д хүрч өссөн нь улсын Засан сайжруулах газрын бүтэц зохион байгуулалт, ажил үйлдвэрлэл эрхлэх чиглэл, байршил болон бусад үйл ажиллагаанд зүй ёсоор нөлөөлжээ. Ингээд Дотоод явдлын яамны Засан сайжруулах газрыг 1940 оноос Засан хүмүүжүүлэх үйлдвэрийн лагериуд ба хорих ангиудыг удирдах газар /ЗХҮЛ ба ХАУГ/ болгож өргөтгөн зохион байгуулсан байна. ЗХҮЛ ба ХАУГ нь дотроо гүйцэтгэх алба, улс төр-хүмүүжил, үйлдвэр-төлөвлөгөө, санхүүгийн хэлтсүүд болон төвийн, Барилгын, Хараагийн, Ононгийн зэрэг томоохон лагериудтай байв. Мөн Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дорнод, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Өмнөговь аймгууд дахь хорих ангиуд харъяалагддаг байжээ.

Дөчөөд оны үеийн ЗХҮЛ ба ХАУГ-ын үйлдвэрлэлийн үндсэн чиглэл нь барилга, барилгын материалын болон зөөлөн оёдлын үйлдвэрлэл, мал аж ахуй, газар тариалан

байв. Ял эдлэгсдийг хөдөлмөрөөр хангах, тэдэнд мэргэжил эзэмшүүлэх, хөдөлмөрийн дадлага олгох ажил эрчимтэй зохиогдож байсан тухай "ДЯЯ-ны Засан хүмүүжүүлэх лагерийг удирдах газрын 1940 оны байдал" гэсэн илтгэлд тодорхой дурджээ.

Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газрын /хуучин нэрээр/ архивт хадгалагдаж байгаа дээрх илтгэл бол анх 1921 онд байгуулагдсан "Гяндан салаа" 1940 он гэхэд ямар хэмжээнд хүрсэн байсныг олон талаас нь нухацтай харуулсан түүхэн чухал баримт бичиг гэдгийг тэмдэглэвэл зохино.

Улс орны хөгжлийн тухайн цаг үеийн онцлог, нийгэм эдийн засгийн байдлаас шалтгаалан ЗХҮЛ ба ХАУГ-ын үйл ажиллагаанд уг байгууллагыг багасган цомхотгохтой холбогдсон өөрчлөлт хийгдсэний дүнд 1956 оноос Цэрэг ба НАХЯ-ны Засан хүмүүжүүлэх ерөнхий хэлтэс болж зохион байгуулагдсан байна. Мөн энэ үед хорих ял эдлэгсдийг тоо өмнөх оныхоос буурч жилд дунджаар 3500-д хүрснийг тэмдэглэх хэрэгтэй.

Ер нь 50-аад оны сүүлчээр улс орон даяар төрийн зарим яамдыг нэгтгэх, газруудыг хэлтэс болгох зэрэг цомхотгол, хэмнэлтийн бодлого явагдаж байсан баримтууд олон байдаг. Харин 1960-аад оноос ял эдлэгсдийг хөдөлмөрийн үр нөлөөгөөр хүмүүжүүлэх ажлыг хүмүүжил-сургалтын бусад ажилтай зөв хослуулан эрчимжүүлэхтэй холбогдсон шинэ шаардлага тавигдах болжээ.

Мөн энэ үеэс ял эдлүүлэх байгууллагын үйлдвэрлэлийн чиглэл өргөжөөд зогсоогүй улсаас тодорхой хэмжээний төлөвлөгөө өгөгддөг болсон байна. Өөрөөр хэлбэл БНМАУ-ын Улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэхтэй холбогдсон төлөвлөгөө бол хууль байсан. Тэр үеийн өндөр шаардлага хорих ял эдлүүлэх байгууллагад нэгэн адил тавигдах болсон юм. Энэ байдлууд нь Засан хүмүүжүүлэх ерөнхий хэлтсийг 1963 оноос эхлэн Засан хүмүүжүүлэх байгууллагуудыг удирдах газар болгон өргөтгөхөд хүргэсэн байна.

Жараад оны үеийн Засан хүмүүжүүлэх ерөнхий хэлтэс болон Засан хүмүүжүүлэх байгууллагуудыг удирдах газар, түүний системийн байгууллагуудын үйл ажиллагаа нь бүхэлдээ МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1957 оны 11-р сарын 14-ны "Засан хүмүүжүүлэх байгууллагын ажлын тухай" 376 дугаар тогтоол, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл, НАХЯ-аас гаргасан тогтоол, тушаалуудын заалтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байжээ.

30,60-аад оны үеийн улс орныг хамарсан хардан сэрдэж хэлмэгдүүлэх, Зөвлөлтийн мэргэжилтнийг урьж олноор ажиллуулах, нэгдэлжих хөдөлгөөн, соёлын довтолгоон, үйлдвэржилтийг өрнүүлэх, арьс өнгө, сүрьеэ зэрэг нийгмийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, устгах болон урлаг, спортын тэмцээн зохиох, социалист уралдаан өрнүүлэх тариа ногоо тарих, хураах, бас агнуурын бригад зохион байгуулах зэрэг томоохон ажлууд ЗХБУГ-ын системд нэгэн адил зохиогдож байсны жишээ олон бий.

Улсаас Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагад өгөх үйлдвэрлэлийн төлөвлөгөө жилээс жилд өсөхийн хирээр түүний хэрэгжилтийн амжилт ч өндөр байсны зарим жишээг дурьдвал, улсын төлөвлөгөө 1964 онд 30 сая төгрөг байсан бол 1974 онд 98,5 сая, 1984 онд 130 сая төгрөг гэх мэтээр өсчээ. 4-р таван жилийн 188,2 сая төгрөгийн төлөвлөгөөг 124,7 хувиар, 5-р таван жилд /1970-1975/ ЗХБУГ-т улсаас өгсөн 383,6 сая төгрөгийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 126,6 хувиар биелүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг 35,9 хувиар нэмэгдүүлж бүтээгдэхүүний өөрийн өртгийг 7 хувиар хямдруулж, 76,4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна .

Засан хүмүүжүүлэх байгууллагуудыг удирдах газрыг 1981 оноос НАХЯ-ны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагуудыг удирдах газар хэмээн нэрлэх болжээ. Энэ нь өнгөц харахад зөвхөн "Хөдөлмөр" гэдэг үг нэмсэн хэдий боловч өргөн утгаар нь авч үзвэл ялтныг хорих ял эдлэх явцад хөдөлмөрийг гол болгох, ингэхдээ түүнийг хүмүүжлийн бусад арга ажиллагаатай нягт холбон явуулахын чухлыг заасан ойлголт байв. Бас 1966,

1981 онд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулиудын нэрэнд "Хөдөлмөр" гэдэг үг нэмж хэрэглэх болсоныг өөрийн байгууллагын нэрэнд оруулан тусгах нь зүйн хэрэг байсан гэж үзэж болно.

80-аад оны сүүлч, 90-ээд оны эхэн үеэс Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын харъяалал, бүтэц зохион байгуулалт, нэр хаягийг өөрчлөн шинэчлэх талаар нилээд яригдаж, зарим бодит алхам хийгдсэн байна. МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчоо 1980 онд "Засан хүмүүжүүлэх байгууллагын ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай" 206 дугаар тогтоол гаргаснаар энэ байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, офицер, ажилтнуудын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, боловсон хүчний хангалтыг сайжруулах, түүнчлэн ялтны хөдөлмөр, хүмүүжлийн ажлыг зөв зохион байгуулах ажил өрнөж, зарим амжилтанд хүрчээ. Тогтоолын заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагуудыг удирдах газарт намын хороо, ялтны дунд зохиох улс төр-хүмүүжлийн ажлын, хөдөлмөр-цалин хөлсний болон харуул хамгаалалтын хэлтсүүд, хоригдлыг хүмүүжүүлэхэд туслах зорилго бүхий арга зүйн зөвлөл шинээр байгуулсны зэрэгцээ офицер ажилтны албаны мэдлэгийг дээшлүүлэхэд зориулж "Засан хүмүүжүүлэх албаны мэдээлэл" сэтгүүл гаргах, хоригдлын дунд хөдөлмөрийн уралдаан өрнүүлж, үе шаттайгаар дүгнэх, тэднийг ерөнхий боловсролын оройн сургалтанд хамруулах зэрэг шинэ хэлбэрийн ажлууд амжилттай өрнөх болов.

1990-ээд оны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын удирдлага, зарим хуульч мэргэжилтэн, практикийн ажилтнууд байгууллагынхаа нэрээс "Хөдөлмөр" гэдэг үгийг хасах, хоригдлыг сурган хүмүүжүүлэх ажлаас татгалзах нь зүйтэй талаар ярьж, бичиж байсан төдийгүй түүнийгээ хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим ажил зохиож байв.

Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын харъяалал 1985 онд Улсын цагдан сэргийлэх ерөнхий газарт шилжсэн тэр тогтолцоог 1991 онд өөрчлөн Хууль зүйн яаманд шилжүүлсэн, 1992 оноос Хорих байгууллагуудыг удирдах газар гэж нэрлэх болсон зэргийг олон түмэн янз янзаар хүлээн авсан бөгөөд энэ талаар яригдаж, бичигдсэн зүйлүүд нэгэнт түүх болон үлджээ.

Монгол Улсын Их Хурал 1993 оны 12 дугаар сард "Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай" Монгол Улсын хууль, 1994 онд "Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай", 1996 онд "Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай" хуулийг батлан гаргаснаар одоогийн хорих болон шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын тогтолцоо, эрх, үүрэг нилээд өөрчлөгдөж хуульчлагдсан байна.

Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар 1996 оны 12 дугар сарын 5-ны өдөр 299 дүгээр тогтоол гаргаж, Улсын Дээд Шүүхийн тамгын газрын шийдвэр гүйцэтгэлийн хянан байцаах хэлтсийг Хорих байгууллагуудыг удирдах газарт нэгтгэн, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар /ШШБЕГ/ болгож өргөтгөн зохион байгуулав.

ШШБЕГ-т Шийдвэр гүйцэтгэлийн газар, Хорих ял эдлүүлэх газрыг тус тус харъяалуулан байгуулсан байна. Харин Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд 2000 оны 9-р сарын 25-ны өдөр "Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын бүтэц, орон тоог батлах тухай" 44 дүгээр тушаал гаргаж, хоёр хэлтсийг өргөтгөн Захиргааны удирдлагын газар, Үйлдвэр, санхүү хангалтын газар болгохоор шийдвэрлэв.

Монгол Улсын Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар нь 2001 оны байдлаар төвдөө зуу орчим орон тоотой, төвлөрсөн болон орон нутгийн нийт 27 хорих анги, нэгдсэн эмнэлгийг харъяалан ажиллаж байв. Энэ үеийн нэг онцлог бол харъяа байгууллагын үйлдвэрлэл сэргэж, хоригдлын хөдөлмөр эрхлэлт дээшилсний дээр ерөнхий газар, гяндан, хугацаагүй хорих тусгай салбар, насанд хүрээгүйчүүдийн хорих анги, дамжин

өнгөрүүлэх анги, төвлөрсөн хорих ангиуд, түүнчлэн хоригдлын эмчилгээний зардлыг бүхэлд нь улсын төсвөөс санхүүжүүлэх болсон явдал юм.

Ийнхүү 1968 оноос эхлэн системээрээ аж ахуйн бүрэн тооцооны зарчим дээр тулгуурлан ажиллаж, орлогоороо зарлагаа бүрэн нөхөөд, жил тутам олон сая төгрөгийг ашгийн хэлбэрээр улсын төсөвт тушаадаг байсан явдал түүх болон үлдэж, гагцхүү төсвөөс санхүүжигдэх болсон байна.

Одоогийн байдлаар ШШГЕГ нь бүтцийн хувьд Тогтоол гүйцэтгэх газар, Шийдвэр гүйцэтгэх газар, Захиргааны удирдлагын газар, Санхүү, үйлдвэр, бодлого, төлөвлөлт зохицуулалтын гэсэн дөрвөн газар, мөн 4 хэлтэстэй, 120 гаруй орон тоотой ажиллаж байна. Түүнчлэн төв, хөдөөд төвлөрсөн хорих ангиуд, албад ажиллаж байгаа юм.

Монгол Улсын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд боловсрогдон, 2002 онд батлагдсан "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай" Монгол Улсын хуулиар дээр дурьдсан бүтэц, зохион байгуулалт, санхүүжилтийн зарчим дахин баталгаажин хэрэгжиж байна.

Харин ШШГБ-ын үйл ажиллагааны шинэчлэлд хамаарал бүхий нийтлэг цөөн зүйлийг авч үзье. Үүнд:

1. Хүний эрхийг дээдлэх үүднээс сэжигтэн, яллагдагчдыг цагдан хорих төв хөдөөгийн нийт байруудыг засч тохижуулах, шинээр барих ажлуудыг амжилттай хийж дуусгасан байна. Эдгээрийн зөвхөн нэг жишээ бол Нийслэл хотод 1000 хүний багтаамжтай, иж бүрэн тоноглогдсон 120 ортой эмнэлэг бүхий цагдан хорих байрыг /461-р анги/ барихад 5,5 тэрбум төгрөг зарцуулж, энэ 2011 оны 4-р сард бүрэн хүчин чадлаар нь ашиглалтанд оруулсан явдал юм.

2. Нийт төвлөрсөн хорих ангиудад ял эдлэж байгаа 6000 гаруй ялтны амьдрах орон байрыг сүүлийн 2-3 жилд багтаан олон улсын түвшинд ойртуулсан загвараар барьж байгуулжээ. Түүнчлэн хорих ял эдлэгсдийн ахуй нөхцөл, хоол хүнсний хангамж, эмнэлгийн үйлчилгээг сайжруулахад чиглэгдсэн олон ажил зохиогдсон байна. Одоо нэг ялтны хоногийн хоолны элчлэг 3900-4100 ккал-д хүрчээ. Тогтоол гүйцэтгэх газрын 120 гаруй ортой нэгдсэн эмнэлэг, сүрьеэгийн болон согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх 350 ортой эмнэлэг болон нийт төвлөрсөн хорих ангиудад 10-12 ортой эмнэлэг тус тус үйл ажиллагаа явуулж байна.

3. Ажиллагсдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарч, үр дүнд хүрсний жишээнд холбогдуулан гурван зүйлийг дурдах нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

Нэгдүгээрт: 1998 онд Засгийн газрын 98 дугаар тогтоол гаргуулснаар, төвөөс алслагдсан хорих ангид ажиллагсад өдөр тутмын мах, гурил, цөцгийн тос, элсэн чихрийн хангалттай болж, амжилттай хэрэгжиж байна.

Хоёрдугаарт: ШШГБ-ын "орон сууц" хөтөлбөр амжилттай хэрэгжиж байгаагийн үр дүнд сүүлийн 5 жилд төв, хөдөөд 350 гаруй айлын орон сууц барьж ашиглалтанд оруулав. 2011 оны 3-р сарын 2-нд Засгийн газрын "Орон сууц хувьчлах тухай" 64 дүгээр тогтоол гарч хэрэгжсэний үр дүнд БЗД-ийн 16-р хороолын нутагт байрлах 198 айлын орон сууцыг эзэмшигчдэд нь үнэгүй хувьчилж өгөх ажил зохион байгуулагдав. Өөрөөр хэлбэл 200-аад өрх айл өөрсдөө захиран зарцуулах эрх бүхий 7,2 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгөтэй болсон юм.

Гуравдугаарт: Засгийн газраас 2011 оны 6-р сарын 22-нд "Журам батлах тухай" 189 дүгээр тогтоол гаргав. Энэ тогтоолын заалт 2012 оны 1-р сарын 1-ээс хэрэгжиж эхлэх бөгөөд, ингэснээр гяндан, төрөл дэглэмийн хорих ангиуд, баривчлах байр, согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх газарт ажиллагсдын онцгой нөхцлийн нэмэгдэл 15-20 хувиар бодогдон цалин нь тэр хэмжээгээр нэмэгдэх гэж байна.

ШШГЕГ-ын системийн хэмжээний сүүлийн 10 жилийн /2001-2011/ үйл ажиллагаа, шинэ бүтээн байгуулалтын үр дүн гэвэл, 97,5 тэрбум төгрөгийн урсгал төсөв, 12,5 тэрбум

төгрөгийн хөрөнгө оруулалтын мөнгийг захиран зарцуулж, 15,3 тэрбум төгрөгийн үйлдвэрлэл явуулж, олон арван барилга байгууламжийг цогцлоон босгосон ядвал юм.

Хоёр. Иргэний хэргийн талаар гарсан шүүхийн
шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжийн
уламжлал, шинэчлэл

Монгол Улсын төр өөрийн орны ял эдлүүлэх байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн боловсронгуй болгоход ихээхэн анхаарч ирсний тод илрэл бол 1931-2002 онуудад арван удаа хууль гаргаж, хэрэгжилтийг зохион байгуулсан явдал юм.

Энэ удаад зөвхөн Шүүхийн тогтоол гүйцэтгэлийн ажиллагааны эрх зүйн зохицуулалтын түүхэн зарим эх сурвалжийн /1926-1994/ тухай авч үзье.

Шүүхийн тогтоол гүйцэтгэлийн ажиллагаа 1994 оноос өмнө хэд хэдэн хуулийн зохих заалтуудаар зохицуулагдаж байжээ. Тухайлбал:

• 1926 оны Монгол ард улсын шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хууль;

• 1949 оны Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль;

• 1952 оны Иргэний байцаан шийтгэх тухай хууль;

• 1957 оны Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль;

• 1967 оны Иргэний байцаан шийтгэх тухай хууль;

• 1978 оны Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль;

• 1994 он Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль;

• Мөн 1994 оны 5-р сараас Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай хуулиудын зохих зүйлд иргэний хэргийн талаарх шийдвэрийг хэрхэн биелүүлэх / гүйцэтгэх/ тухай заагдсан байдаг. Эдгээрийг дэлгэрүүлэн авч үзэх нь нэг талаар, түүхэн, нөгөө талаар, судалгааны ач холбогдолтой гэж үзэв.

Монгол Улсын 16 дугаар он буюу 1926 оны 7 дугаар сарын 2-ны өдөр БНМАУ-ын Засгийн газрын хурлын олон гишүүд хуралдан зөвшилдөн тогтоосон хорьдугаар хурлын 26 дугаар тогтоолын 6 дугаар зүйлд:

"Шүүх таслах газруудад хэрэг шийтгэх тухай хуулийг Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн газар шилжүүлэн явуулж батлуулах зэрэг явдлыг Засгийн газраас эрхлэн гүйцэтгэхээр тогтов" гэжээ.

Улсын Бага Хурлаас батлан гаргасан "Монгол Ард Улсын шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хууль -ийн IX бүлгийг Шүүх таслах газруудын тогтоолыг гүйцэтгэх тухай гэж нэрлээд, 11 зүйлийг тусгаж, гүйцэтгэх хуудасны загварыг баталсан байна."

Монгол Улсын 19 дүгээр он буюу 1929 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн БНМАУ-ын Засгийн газрын XXI хурлын тогтоол, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн мөн оны 64 дүгээр хурлын тогтоолын нэгдүгээр зүйлийг үндэслэн "БНМАУ-ын Шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хууль"-д нэмэлт оруулжээ. Энэ хуулийн XI бүлгийг "Шүүн таслах газруудад өр ширийн зэрэг иргэний хэргийг таслан шийтгэсэн тогтоолыг гүйцэтгэх тухай" гэж нэрлээд 123-201 дүгээр зүйлүүдийг тусгасны дээр тогтоол гүйцэтгэгчээс үйлдэх дансны тэмдэглэл, маягтын загварыг баталжээ .

Нэгэн зүйл

Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1949 оны 8 дугаар сарын 6-ны 9 дүгээр зарлигаар батлагдсан "Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль"-ийн 6 дугаар бүлгийг "Шүүхийн гүйцэтгэгч нар" гэж нэрлээд уг хуулийн 42-44 дүгээр зүйлүүдэд дараах

заалтууд тусгагдсан байна. Үүнд:

- Иргэний хэргийн талаар гаргасан шийдвэр, магадлалууд ба эд хөрөнгийг гаргуулах тухай асуудалтай холбогдсон эрүүгийн хэргийг шийтгэсэн тогтоолуудыг биелүүлэх ажлыг шүүхийн гүйцэтгэгч нараас гүйцэтгэнэ.

- Шүүхийн гүйцэтгэгч нар бол аймаг, хотын шүүхүүд ба Дээд шүүхийн дэргэд байх бөгөөд шүүх яамнаас эрхлэн томилно. Өөрсдийн ажлын талаар Ардын шүүгч буюу Дээд шүүхийн даргад захирагдана.

- Ардын хэсгийн шүүхүүдээс гаргасан эд хөрөнгийг төлүүлэх асуудалтай холбогдсон шүүхийн шийдвэр магадлал ба шийтгэсэн тогтоолуудыг биелүүлэх ажлыг сумдын захиргаанаас гүйцэтгэнэ.

- Шүүхийн гүйцэтгэгч нар ба мөн шүүхийн даалгавраар шүүхийн гүйцэтгэгч нарын үүргийг биелүүлж байгаа сумдын захиргааны ажилтан нараас шүүхийн шийтгэсэн тогтоол, шийдвэр ба магадлалуудыг биелүүлэхээр шаардсан шаардлагыг бүх албан тушаалын хүмүүс ба ард иргэдээс заавал гүйцэтгэвэл зохино гэжээ.

Нэгэн зүйл

БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуульд /1952 он/ шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий байдлыг заахдаа /119 дүгээр зүйлд/:

Шүүхийн гүйцэтгэгч буюу сумын хөдөлмөрчдийн депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны газруудаас гүйцэтгэх зүйлүүд гэвэл:

а/ Иргэний хэргийн талаар гаргасан шүүхийн шийдвэр ба нотариатын конторын гүйцэтгэх хуудсууд

б/Торгууль хүлээлгэх ба нэхэмжлэлийг хангах тухай иргэний ба эрүүгийн хэргийн талаар шүүхээс гаргасан магадлалууд, түүнчлэн хулгайлсан ба үрэгдүүлсэн зүйлийг төлүүлэх тухай шийтгэсэн тогтоолууд

в/Улсын арбитрын шийдвэрүүд гэжээ.

Нэгэн зүйл

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1957 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн "БНМАУ-ын Шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн 43, 44 дүгээр зүйлд өөрчлөлт оруулах тухай" 123 дугаар зарлиг

БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдээс тогтоох нь:

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн 43, 44 дүгээр зүйлийн дор дурдсанаар найруулж өөрчилсүгэй. Үүнд:

43 дугаар зүйл. Ардын хэсгийн шүүхээс эд хөрөнгө төлүүлэх талаар гаргасан шийдвэр магадлал ба шийтгэсэн тогтоолыг биелүүлэх ажлыг ардын хэсгийн шүүхийн нарийн бичгийн дарга нар гүйцэтгэнэ.

44 дүгээр зүйл. Шүүхийн шийтгэсэн тогтоол шийдвэр ба магадлалыг биелүүлэхээр шүүхийн гүйцэтгэгч, ардын хэсгийн шүүхийн нарийн бичгийн дарга нарын шаардсан шаардлагыг бүх албан тушаалын хүмүүс ба ард иргэд заавал гүйцэтгэвэл зохино гэжээ.

Нэгэн зүйл

БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийн /1967 он/ "Тогтоол гүйцэтгэлийн ажиллагаа" гэсэн Y хэсэгт буюу 251-304 дүгээр зүйлээр шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаа зохицуулагдаж байв. Энэ хуулийн 252 дугаар зүйлд дор дурдсан шийдвэр, тогтоолуудыг тогтоол гүйцэтгэлийн журмаар гүйцэтгэж байхаар заажээ.

1. Иргэний хэргийн талаар гаргасан шүүхийн шийдвэр, магадлал, тогтоол;

2. Эрүүгийн хэргийн талаар шүүхээс гаргасан таслан шийдвэрлэх тогтоол, магадлал болон тогтоолын эд хөрөнгө гаргуулах хэсэг;

3. Захиргааны зөрчил гаргасан этгээдээс эд хөрөнгийн төлбөр гаргуулах талаар шүүгч буюу шүүх, олон нийтийн шүүхээс гаргасан тогтоол;

4. Шүүхээс баталсан эвлэрсэн хэлэлцээ;

5. Нотариатын мэдэгдэх хуудас;

6. Арбитрийн байгууллагын шийдвэр;

7. БНМАУ-ын Худалдааны танхимийн дэргэдэх гадаад худалдааны арбитрийн комиссын шийдвэр;

8. Олон нийтийн шүүхийн тогтоол;

9. Иргэдээс маргаангүй төлбөр гаргуулан авах эрх хуулиар олгогдсон захиргааны байгууллагын шийдвэр:

10. Гадаад улсын шүүхээс хуульд заасан тохиолдлын дагуу гаргасан шийдвэр. Энэ зүйлд дурдсан шүүхийн шийдвэр ба бусад байгууллагын тогтоолыг аймаг, хотын шүүхийн тогтоолд гүйцэтгэгчид гүйцэтгэнэ.

Харин тогтоол гүйцэтгэлийн ажилд хяналт тавих, тогтоолыг цаг тухайд нь зөв гүйцэтгүүлэх хариуцлагыг шүүгч хүлээнэ гэдгийг хуульчилсан байна.

Нэгэн зүйл

БНМАУ-ын Шүүхийн байгууламжийн хуулийн /1978 он/ 61-63 дугаар зүйлээр: Шүүхийн тогтоол гүйцэтгэгчийг томилох, чөлөөлөх журам, шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүгчийн тогтоолыг гүйцэтгэх, шүүхийн тогтоол гүйцэтгэгчийн шаардлагыг заавал биелүүлэх асуудлууд зохицуулагдаж байв. Тухайлбал:

- Шүүхийн тогтоол гүйцэтгэгчийг томилох, ажлаас чөлөөлөх асуудлыг аймаг, хотын болон тусгай шүүхийн даргын тушаалаар шийдвэрлэх;

- Шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлал, шүүгчийн тогтоолын эд хөрөнгө гаргуулах тухай заалтыг тогтоол гүйцэтгэгч биелүүлэх;

- Хууль тогтоомжид заасан нөхцөлд шүүхийн тогтоол гүйцэтгэгч нь эд хөрөнгийн хохирол барагдуулах, торгууль, төлбөр ноогдуулсан тухай эрх бүхий байгууллагын шийдвэрийг биелүүлэх;

- Шүүгчийн тогтоолыг биелүүлэхээр шүүхийн тогтоол гүйцэтгэгчээс тавьсан шаардлагыг бүх албан тушаалтан, иргэд заавал биелүүлэх үүрэгтэйг тус тус заан тодорхойлжээ.

Нэгэн зүйл

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1985 оны 237 дугар тогтоолоор "Шүүхийн тогтоол гүйцэтгэх журмын тухай заавар"-ыг батлан гаргажээ .

Энэ зааврын нийтлэг үндэслэлийн "Тогтоол гүйцэтгэх ажиллагааны үндсэн нөхцөл" гэдэгт:

1. Аймаг, хотын болон тусгай шүүх, хэсэг, район, орон нутгийн хотын ардын шүүхийн тогтоол гүйцэтгэгчид БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийн 252 дугаар зүйлд заасан шүүхийн болон бусад байгууллагын шийдвэрийг шүүхийн тогтоол гүйцэтгэлийн журмаар эхлэн гүйцэтгэнэ.

2. БНМАУ-ын Шүүхийн байгууламжийн хуулийн 63 дугаар зүйл, БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийн 260 дугаар зүйлд зааснаар шүүхийн тогтоол, шийдвэр, магадлалыг биелүүлэхээр шүүхийн тогтоол гүйцэтгэгчээс тавьсан шаардлагыг бүх албан тушаалтан, иргэд заавал биелүүлэх үүрэгтэй.

Нэгэн зүйл

УИХ-ын 1994 онд батлан гаргасан "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай" хуулийн 191-234 дүгээр зүйлд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны журмыг заажээ. Энэ хуульд зааснаар шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар гүйцэтгэх шийдвэрүүдэд:

1. Иргэний хэргийн талаар шүүхийн шийдвэр;

2. Эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийн торгох, эд хөрөнгө хураах ял болон хөрөнгө гаргуулах заалт;

3. Захиргааны зөрчил гаргасан этгээдээс торгууль, төлбөр гаргуулах талаар гарсан шийтгэвэр;

4. Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаар биелүүлбэл зохих гадаад улсын шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэр, холбогдох баримт бичиг;

5. Арбитрийн шийдвэр хамаарагдахаар заасан байна.

Нэгэн зүйл

Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд холбогдох хуулийн заалтыг нэг мөр ойлгож асуудалд хандах талаар УДШ-ээс, ялангуяа 80-аад онд ихээхэн анхаарч байсны илрэл бол дараах тогтоолууд юм. Эдгээрийг жагсаавал:

- БНМАУ-ын Дээд Шүүхийн бүгд хурлын 1978 оны 12-р сарын 29-ний өдрийн "Шүүхийн шийдвэр, тогтоолын биелэлтэд тавих шүүгчийн хяналтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай" 35 дугаар тогтоол;

- БНМАУ-ын Дээд Шүүхийн Тэргүүлэгчдийн 1982 оны 11-р сарын 3-ны өдрийн "Тогтоол гүйцэтгэлийн ажлыг сайжруулах зрим арга хэмжээний тухай" 9/30 дугаар тогтоол;

- Дээд шүүхийн тэргүүлэгчдийн 1982 оны 11-р сарын 3-ны өдрийн "Тогтоол гүйцэтгэлийн ажиллагааг зохион байгуулах, бүртгэх, тооцох, тайлагнах хянах журмын тухай" 9/30 дугаар тогтоол;

- Улсын Дээд Шүүхийн Тэргүүлэгчдийн 1983 оны 7-р сарын 28-ны өдрийн "Шүүхийн тогтоол гүйцэтгэгчийг ажилд авах, халах журам"-ын тухай 30 дугаар тогтоол;

- Улсын Дээд Шүүхийн бүгд хурлын 1983 оны 12-р сарын 27-ны өдрийн "Төгтоол гүйцэтгэлийн ажиллагааг хойшлуулах, хэрэгсэхгүй болгох, албадан биелүүлсний зардал төлүүлэх тухай" 57 дугаар тогтоол.;

- Улсын Дээд Шүүхийн бүгд хурлын 1983 оны 12-р сарын 27-ны өдрийн "Хүүхдийн тэтгэврийг тогтоон гаргуулж байгаа шүүхийн практикийн тухай" 59 дүгээр тогтоол;

- БНМАУ-ын Дээд Шүүхийн дарга, ХБЯ-ны сайдын 1986 оны "Төлбөрт хураагдсан эд хөрөнгийг комиссын хуралдааны журмаар худалдан борлуулах заавар батлах тухай" 262/58 тоот тушаал.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай хуулийн агуулга

Улсын Их Хурлаас 1994 оны тавдугаар сарын 10-ны өдөр "Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай хууль" батлан гаргав.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны эрх зүйн зохицуулалт урьд нь Шүүхийн зохион байгуулалтын тухай хууль /1949/, Иргэний байцаан шийтгэх хууль /1967/, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /1994/-д хамаарагдаж ирсэн талаах өмнө дурдсан билээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай хуулийн талаар хуульч С.Дамдинсүрэн өгүүлэл бичин нийтлүүлж, энэ чиглэлийн эрх зүйн зохицуулалтын анхны хууль байсныг онцлон тэмдэглэсэн байдаг.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛ



ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн захирал, доктор, дэд профессор, хурандаа Н.Гантулга

Улсын Их Хурлын 2009 оны 38-р тогтоолоор батлагдсан "Монгол улсын хууль тогтоомжийг 2012 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл", Засгийн газрын 2008-2012 оны мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хийх, Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар тусгасан.

Энэ цаг мөчөөс тухайн салбарын нарийвчилсан судалгааны ажил бүх шатанд идэвхижин ШШГЕГ-ын зүгээс хуулийн үзэл баримтлал, төслийн талаархи нээлттэй хэлэлцүүлгийг шүүх эрх мэдэл, хууль сахиулах болон эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага, мэргэшсэн алба хаагч, судлаачдын түвшинд хэд хэдэн удаа зохион байгуулж, санал зөвлөмжийг олон хэлбэрээр авч байна.

Хэдийгээр манай улс эрх зүйн шинэтгэлийг хууль тогтоомжийн хүрээнд харьцангуй хурдацтай хийж буй боловч түүний салшгүй хэсэг болсон хуулийн гүйцэтгэлийг хангах, хууль хэрэглэх тогтолцоо, арга ажиллагаа, хууль зүйн шинжилгээ-судалгааны ажлын зохион байгуулалт, арга зүйг шинэтгэх, нийгмийн эрх зүйн шинэ ухамсрыг төлөвшүүлэх чиглэлд удаашралтай явагдаж байгааг эрдэмтэн судлаачид тэмдэглэсэн байдаг.

Иймд туулж ирсэн эрх зүйн хөгжлийн амжилт-бүтээл, алдаа оноогоо дэнслэн үзэж шинэтгэлийг дээрхи 5 чиглэлээр жигд явуулахад анхаарал хандуулахын сацуу эрх зүйн нэг бүлд хамрагдаж байсан бусад улс орнуудад эрх зүйн шинэтгэл хэрхэн явагдаж, холбогдох асуудлууд яаж шийдвэрлэж байгааг судлах явдал ихээхэн ач холбогдолтой юм.

Энэ хүрээнд манай улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, хэлэлцэх явцад зайлшгүй авч хэлэлцэн шийдвэр гаргах хорих ял эдлүүлэх ажиллагаатай холбогдсон зарим зохицуулалтын талаар эхний удаад ОХУ-ын Эрүүгийн ялын гүйцэтгэлийн тухай хуулийн зарим зүйл, хэсгийн жишээн дээр судлаачийн тайлбар, байр суурийг илэрхийлэлгүйгээр албан бус орчуулгын хэлбэрээр та бүхэнд хүргэж байна.

• 15 дугаар зүйл. Ялтны гомдол, хүсэлтийг авч үзэх, шийдвэрлэх журам.

15.4 дэхь хэсэг. Ялын гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаанд шалгалт, хяналт хийх чиг үүрэг бүхий байгуулага, нийгмийн хяналтын комисст хандсан баривчлах, цэргийн сахилгын хэсэгт байгаа, хорих болон цаазаар авах ялаар шийтгэгдсэн ялтны санал, хүсэлт, гомдлыг хянаж шалгахгүй бөгөөд нэг хоногоос хэтрүүлэлгүй (амралт, бүх нийтийн баярын өдрөөс бусад тохиолдолд) холбогдох газарт нь илгээнэ.

• 74 дүгээр зүйл. Хорих ялаар шийтгэгдсэн ялтныг ял эдлүүлэхээр илгээх.

74.2 дахь хэсэг. Хорих ялаар шийтгэгдсэн насанд хүрсэн ялтнууд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонуудад ял эдэлнэ. Тэдгээр нь колони-суурин (тосгон), жирийн дэглэмтэй, чанга дэглэмтэй, онцгой дэглэмтэй засан хүмүүжүүлэх колони гэж хуваагддаг. Нэг засан хүмүүжүүлэх колонид янз бүрийн дэглэм бүхий тусгаарлагдсан хэсгүүд байгуулагдаж болно. Ийм хэсгүүдийг байгуулах журмыг эрүүгийн ялыг гүйцэтгэх салбарын төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, эрх зүйн нийтлэг зохицуулалтыг нь хариуцсан чиг үүрэг бүхий Холбооны гүйцэтгэх засаглалын байгууллага тодорхойлно.

• 85 дугаар зүйл. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагууд дахь онцгой нөхцлийн дэглэм

85.1 дэхь хэсэг. Байгалийн гамшигт үзэгдэл бий болсон, Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага байрлаж буй районд онц эсвэл дайны байдлын журам үйлчилсэн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, тэрчлэн ялтнууд бүлэглэн эсэргүүцэж, захирагдахгүй байгаа тохиолдолд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагад онцгой нөхцлийн дэглэм тогтоож болно.

85.2 дахь хэсэг. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагад онцгой нөхцлийн дэглэм үйлчлэх хугацаанд Эрүүгийн ялын гүйцэтгэлийн тухай хуулийн 88-97-р зүйлд тусгагдсан зарим эрх эдлэх явдлыг ялтнуудын хувьд зогсоож болох ба хамгаалалт, хяналтыг хүч нэмэгдүүлж, обьектод нэвтрэх онцгой журам тогтоон өдрийн цагийн хуваарийг өөрчлөн эмнэлэг, ариун цэврийхээс бусад үйлдвэрлэл, аж ахуй-олон нийт, соёл хүмүүжлийн албаны үйл ажиллагааг хязгаарлана.

85.3 дахь хэсэг. Эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх, шалгалт, хяналтыг ял эдлүүлэх үйл ажиллагаанд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Холбооны гүйцэтгэх засаглалын байгууллагын удирдагчийн, эсвэл ОХУ-ын субьектын Эрүүгийн ял эдлүүлэх системийн нутаг дэвсгэрийн байгууллагын даргаас ОХУ-ын ерөнхий прокурор эсвэл холбогдох прокуроргой зөвшилцсөн шийдвэрээр онцгой нөхцлийн дэглэмийг 30 хүртэл хоногийн хугацаар тогтоож болно. Онцгой тохиолдолд энэ зүйлийн нэгдүгээр хэсэгт тодорхойлсон үндэслэлээр нэр заагдсан албан тушаалтан онцгой нөхцлийн дэглэм үйлчлэх хугацааг 30 хоногоор сунгаж болно.

85.4 дэхь хэсэг. Ялтан, ажилтан болон бусад хүний амь бие, эрүүл мэндэд шууд заналхийлэл үүссэн үед Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын дарга энэ зүйлийн хоёр дахь хэсэгт тусгагдсан арга хэмжээг ийм шийдвэр гаргах эрх мэдэл бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэн хэрэгжүүлж болно. Холбогдох мэдээлэл авсан тухайн албан тушаалтан энэ тохиолдолд 3 хоногийн дотор онцгой нөхцлийн дэглэмийг тогтоох эсвэл хүчингүй болгох шийдвэр гаргана.

•89 дүгээр зүйл. Хорих ял эдэлж буй ялтны уулзалт.

89.1 дэхь хэсэг. Хорих ял эдлэж буй ялтанд 4 цагийн хугацаатай түр уулзалт, 3 хоногийн хугацаатай удаан уулзалтыг Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын нутаг дэвсгэрт олгоно. Энэ хуульд тусгагдсан тохиолдлуудад ялтанд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын гадна 5 хоног үргэлжлэх удаан хугацааны уулзалтыг олгож болно. Энэ тохиолдолд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын даргаас уулзалт явагдах журам, газрыг тогтооно.

89.3 дахь хэсэг. Ялтны хүсэлтээр удаан хугацааны уулзалтыг түр хугацааны, түр эсвэл удаан хугацааны уулзалтыг телефон утсаар ярих, харин хүмүүжлийн колонид Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын гадна явагдах удаан хугацааны уулзалтыг хүмүүжлийн колоний нутаг дэвсгэрийн гадна гарах түр уулзалтаар солихыг зөвшөөрдөг.

Нэг төрлийн уулзалтыг нөгөөгөөр солих журмыг Эрүүгийн ялыг гүйцэтгэх салбарын төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, эрх зүйн нийтлэг зохицуулалтыг нь хариуцсан чиг үүрэг бүхий Холбооны гүйцэтгэх засаглалын байгууллага тогтооно.

89.4 дахь хэсэг. Хууль зүйн туслалцаа авах ялтанд өмгөөлөгч болон хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх бүхий бусад этгээдтэй уулзахад нь зориулан хүний тоог нь хязгаарлахгүйгээр 4 хүртэл цагийн уулзалт хийлгэж болно. Ялтны хүсэлтээр өмгөөлөгчтэй хийх уулзалт нь ганцаарчилсан байдлаар, гуравдагч этгээдээс сонсох боломжгүй, чагнах техник хэрэгсэлгүй орчинд явагдана.

• 91 дүгээр зүйл. Хорих ял эдэлж буй ялтан захидлаар харилцах, мөнгөн гуйвуулга авах, илгээх

91.1 дэхь хэсэг. Хорих ял эдэлж буй ялтанд өөрийн зардлаар захидал, цахилгаан мэдээг тооны хязгаарлалтгүйгээр авч, илгээхийг зөвшөөрнө.

91.2 дахь хэсэг. Ялтныг хүлээн авч, илгээж буй бичиг-захидал нь Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын захиргааны хяналт шалгалтад хамрагдана. Шүүх, прокурор, Эрүүгийн ялыг гүйцэтгэх системийн дээд шатны байгууллага, тэрчлэн ОХУ-ын гишүүн субьектүүдийн Хүний эрхийн бүрэн эрхт төлөөлөгчидтэй, ОХУ-ын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан Нийгмийн хяналтын комисс, Хүний эрхийн Европын шүүхтэй харилцах ялтны бичиг-захидал нь хяналт шалгалтад өртөх ёсгүй.

Бичиг-захидалд гэмт хэргийг санаачлах, төлөвлөх эсвэл зохион байгуулах болон бусад хүнийг гэмт хэрэгт татан оруулахад чиглэсэн мэдээлэл байна гэсэн бодит баримттайгаас бусад тохиолдолд ялтнаас өмгөөлөгч эсвэл хууль зүйн туслалцаа үзүүлэх бусад этгээдтэй хууль ёсны үндсэн дээр харьцах бичиг-захидал Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын захиргааны хяналт шалгалтад өртөхгүй.

Дурьдсан тохиолдлуудад шуудангийн илгээмж, цахилгаан болон бусад мэдээлэлд тавих шалгалтыг Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын удирдагч эсвэл түүний орлогчийн үндэслэл бүхий тогтоолоор хийнэ.

91.3 дахь хэсэг. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагад ял эдэлж байгаа төрөл садангийн бус хүмүүс хоорондын захидал харилцаа нь Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын захиргааны зөвшөөрлөөр явагдаж болно.

• 97 дугаар зүйл. Хорих ял эдэлж буй ялтнаас Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагаас гадагшаа явах

97.1 дэхь хэсэг. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колони, хүмүүжлийн колонид хорих ял эдэлж буй ялтан, тэрчлэн цагдан хорих байр, гянданд аж ахуйн үйлчилгээний ажил эрхлэхээр зохих журмын дагуу үлдсэн ялтнууд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагаас гадагшаа гарах явдлыг зөвшөөрдөг. Энэ нь:

а/ Хувийн онцгой нөхцөл байдал (ойр дотны төрөл садан нь нас барсан эсвэл амь насанд нь аюултай байдлаар хүндээр өвчилсөн, ялтан эсвэл түүний гэр бүлд их хэмжээний материаллаг хохирол учруулсан байгалийн гамшгийн үед), түүнчлэн суллагдсны дараа хөдөлмөр, ахуйн хувьд суурьших асуудлаа урьдчилан шийдвэрлэхтэй нь холбогдуулан очих, буцах замын хугацааг нь оролцуулалгүй 7 хоног хүртэлх богино хугацааны

б/ Жил тутмын цалинтай (удаан хугацааны) амралтыг мөн хугацаагаар нь, харин энэ хуулийн 103-р зүйлийн 103.2 дахь хэсэгт заасан ялтнууд, өөрсдөөс нь хамааралгүй шалтгаанаар ажлаар хангагдаагүй ялтнуудад жил тутмын цалинтай амралтыг холбогдох хугацаагаар нь олгоно.

97.2 дахь хэсэг. Эмэгтэй ялтнуудад Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колоний цэцэрлэгт байгаа хүүхдээ Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын гадна байрлах төрөл садангийндаа болон цэцэрлэгт байрлуулж төвхнүүлэхэд нь очих, ирэхдээ зарцуулах зайлшгүй хугацааг оруулан тооцолгүйгээр 15 хүртэл хоногоор гадагш богино хугацаагаар явахыг зөвшөөрч болно. Харин Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колоний гадна байгаа хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрээгүй хүүхэдтэй эмэгтэй ялтанд жилд 1 удаа тэдэнтэйгээ уулзахад нь мөн дээрх хугацаагаар богино хугацаагаар явахыг зөвшөөрнө.

97.3 дахь хэсэг. Онц аюултай рецидив гэмт хэрэгтнээр тооцогдсон, цаазаар авах ял нь уучлалын журмаар хорих ялаар солигдсон, бүх насаараа хорих ялтай, сүрьеэгийн нээлттэй хэлбэрээр өвчилсөн, халдварт өвчний, согтуурал, мансуурах донгоос гаргах бүрэн курс эмчилгээ нь дуусаагүй, ДОХ-ын өвчтэй болон халдваргүйжүүлэх арга хэмжээнд хамрагдаж буй ялтнуудыг энэ зүйлийн 1, 2 дахь заасан үндэслэлээр гадагш явахыг зөвшөөрөхгүй.

97.4 дэхь хэсэг. Гэр бүлийн эсвэл бусад хүнийг нь дагалдуулан Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагаас гадагш явахыг ял эдлэх явдалд нь харшлахгүй сэтгэцийн өвчтэй, тахир дутуугийн 1, 2-р зэрэгтэй, эрүүл мэндийн байнгын халамж, сувилгаа шаардлагатай болон мөн насанд хүрээгүй ялтанд тус тус зөвшөөрнө.

97.5 дахь хэсэг. Хувийн онцгой нөхцөл шалтгааны улмаас Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагаас богино хугацаагаар гадагш явах тухай ялтны хүсэлтийг 1 хоногийн дотор авч хэлэлцэх ёстой.

97.6 дахь хэсэг. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын дарга ялтны үйлдсэн гэмт хэргийн шинж чанар, нийгмийн хор аюул, ял эдэлсэн хугацаа, хувийн байдал, зан төлөвийг нь харгалзан Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагаас гадагш явах зөвшөөрлийг олгоно.

97.7 дахь хэсэг. Зөвшөөрлийн үндсэн Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагаас гадагш явсан хугацаа нь ял эдэлсэн хугацаанд тооцогдоно.

97.8 дахь хэсэг. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагаас гадагш явахтай холбогдсон зардлаа ялтан өөрөө болон бусад хүмүүсээр төлүүлнэ. Ялтны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын гадна богино хугацаагаар явсан хугацаанд түүнд ажлын хөлс бодогдохгүй.

97.9 дэхь хэсэг. Тогтоосон хугацаанд буцаж ирэх явдлыг нь хүндрүүлсэн, урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэн үед ялтны байрлаж байгаа газрын Дотоод хэргийн байгууллагын даргын тогтоолоор Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагад буцах хугацааг 5 хүртэл хоногоор сунгаж энэ талаар даруй Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын захиргаанд зайлшгүй мэдэгдэнэ.

97.10 дахь хэсэг. Ялтанд хорих байгууллагаас гадагш явах зөвшөөрлийн журмыг Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулсан дүрмээр тодорхойлно.

97.11 дэхь хэсэг. Тогтоосон хугацаанд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагад буцаж ирэх явдлаасаа зайлсхийсэн ялтныг Дотоод хэргийн байгууллага прокурорын зөвшөөрлөөр ял эдлүүлэх газар хамгаалалтын дор хүргүүлэх эсвэл эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэхээр 30-аас илүүгүй хоногоор саатуулна.

97.12 дахь хэсэг. Ялтнаас бусад улсын нутаг дэвсгэрт явах асуудлыг холбогдох улстай байгуулсан хэлэлцээрт тусгасан журам, тохиолдлуудад зөвшөөрдөг.

• 98 дугаар зүйл. Хорих ял эдэлж буй ялтны улсын нийгмийн зайлшгүй даатгал ба тэтгэврийн хангамж

98.1 дэхь хэсэг. Хорих ял эдэлж буй хөдөлмөрлөх үйл ажиллагаанд оролцсон ялтнууд улсын нийгмийн зайлшгүй даатгалд хамрагдана. Харин эмэгтэй ялтнууд ОХУ-ын Засгийн газраас тогтоосон журмын дагуу жирэмсний болон төрсөний тэтгэмжээр хангагдана. Жирэмсний ба төрсөний тэтгэмжийг эмэгтэй ялтнуудад тэдгээрийг хөдөлмөрлөх үүргээ биелүүлсэн болон бусад нөхцлөөс үл хамааран олгоно.

98.2 дахь хэсэг. Нийтлэг журмын үндсэн дээр ялтнууд өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны болон ОХУ-ын хууль тогтоомжид тусгагдсан бусад тохиолдолд улсын тэтгэвэрийн хангамжийг эдлэх эрхтэй.

98.3 дахь хэсэг. Ялтны тэтгэврийг Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын байрлах нутаг дэвсгэрийн хүн амын нийгмийн хамгаалалын байгууллагаас тэдний хувийн харилцах дансанд шилжүүлэх замаар олгоно.

98.4 дахь хэсэг. Хорих ял эдлэх явцдаа хөдөлмөрийн чадвараа алдсан ялтан ОХУ-ын хууль тогтоомжид тусгагдсан тохиолдлуудад зохих журмын дагуу хохирлоо нөхөн төлүүлэх эрх эдлэнэ.

98.5 дахь хэсэг. Ялтны тэтгэвэрээс суутгал хийгдэнэ. Тэтгэвэрээс суутгал

хийх үндэслэл, төрөл, журам энэ хуулийн 107 дугаар зүйлээр тодорхойлогдоно.

• 99 дугаар зүйл. Хорих ял эдэлж буй ялтны материал-ахуйн хангалт

99.1 дэхь хэсэг. Хорих ял эдэлж буй нэг ялтанд оногдох амьдралын талбайн хэмжээ нь Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонуудад 2 м/кв, гянданд 2,5 м/кв, эмэгтэйчүүдийн ял эдэлж буй колонид 3 м/кв, хүмүүжлийн колонид 3,5 м/кв, эмчилгээний засан хүмүүжүүлэх байгууллагуудад 3 м/кв, Эрүүгийн ялын гүйцэтгэлийн системийн эмчилгээ-урьдчилан сэргийлэх байгууллагуудад 5 м/кв байна.

99.2 дахь хэсэг. Ялтнуудад хувийн унтах ор, цагаан хэрэгсэл олгодог. Тэд мөн хүйс, цаг уурын нөхцөл байдлыг харгалзсан улирлын хувцас, ариун цэврийн хувийн хэрэгсэл (хамгийн наад зах нь саван, шүдний сойз, шүдний оо, нойлын цаас, эрэгтэйчүүдийн хувьд нэг удаагийн сахлын хутга, эмэгтэйчүүд ариун цэврийн хэрэгсэл)-ээр хангагдана.

99.3 дахь хэсэг. Ялтны хоолны болон материаллаг ахуйн хангалтын доод нормыг ОХУ-ын Засгийн газар тогтооно. Ялтныг хөдөлмөрөөр хангаж буй байгууллагын хөрөнгөөр тэдэнд тогтоосон нормоос гадна нэмэлт хоол хүнсийг олгож болно. Ялтны эд зүйлсийн хангалтын нормыг Эрүүгийн ялыг гүйцэтгэх салбарын төрийн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх эрх зүйн нийтлэг зохицуулалтыг хариуцсан чиг үүргийг хэрэгжүүлэгч Холбооны гүйцэтгэх засаглалын байгууллага батлана. Өөрөөс нь шалтгаалахгүйгээр хөдөлмөрлөөгүй болон тэтгэвэр авдаггүй ялтнууд улсын төсвийн хөрөнгөөр хоол болон нэн тэргүүний эд зүйлсээр хангагдана.

99.4 дахь хэсэг. Ажлын хөлс, мөн тэтгэвэр авч буй ялтнууд тусгай хоол, тусгай хувцаснаас бусад хоол хүнс, хувцас, нийтийн ахуйн үйлчилгээ, хувийн ариун цэврийн хэрэгсэлийн үнийг төлнө. Ажлаас зайлсхийсэн ялтнуудаас холбогдох зардлыг тэдгээрийн хувийн харилцах дахь байгаа мөнгөнөөс суутгана. Хоол, хувцас нийтийн ахуйн үйлчилгээний зардлын нөхөн суутгал нь сар бүр зарцуулагдсан бодит зардлаар тооцогдон хийгдэнэ.

99.5 дахь хэсэг. Өвчний учир ажлаас чөлөөлөгдсөн, жирэмсэн, мөн хөхүүл хүүхэдтэйн улмаас ажлаас чөлөөлөгдсөн эмэгтэй ялтнуудыг үнэ төлбөргүй хооллоно. Хүмүүжлийн колонид хоригдож буй ялтнууд, тахир дутуугийн 1, 2-р зэрэгтэй ялтнуудад хоол, хувцас нийтийн ахуйн үйлчилгээ, хувийн ариун цэврийн хэрэгслүүд үнэ төлбөргүй олгогдоно.

• 103 дугаар зүйл. Хорих ял эдэлж буй ялтныг хөдөлмөрт татан оролцуулах

103.1 дэхь хэсэг. Хорих ял эдэлж буй ялтан бүр Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын захиргаанаас тодорхойлсон газарт хөдөлмөрлөх үүрэгтэй. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын захиргаа ялтныг тэдгээрийн хүйс, нас, хөдөлмөрийн чадвар, эрүүл мэндийн байдал болон боломж, мэргэшил тэрчлэн ажлын орон тоог харгалзан хөдөлмөрт татан оролцуулах үүрэгтэй. Ялтнуудыг Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагуудын ялтныг хөдөлмөрт дасан зохицох төв, үйлдвэрлэл засварын, эрүүгийн ял эдлүүлэх системийн холбооны улсын төвлөрсөн үйлдвэрийн газрууд болон Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын нутаг дэвсгэр ба тэдгээрийн гадна байрлах зохих хамгаалалт, ялтныг тусгаарласан хангамж бүхий нөхцөлтэй зохион байгуулалт, эрх зүйн бусад хэлбэр бүхий байгууллагад хөдөлмөрт татан оролцуулж болно.

103.2 дахь хэсэг. 60-аас дээш настай эрэгтэй, 55-аас дээш настай эмэгтэй, түүнчлэн тахир дутуугийн 1, 2-р зэрэгтэй ялтнуудыг ОХУ-ын Хөдөлмөрийн тухай болон Тахир дутуу хүмүүсийн нийгмийн хамгаалалын тухай хуульд нийцүүлэн хүсэлтээр нь хөдөлмөрт татан оролцуулж болно. Насанд хүрээгүй ялтнуудыг ОХУ-ын Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрт татан оролцуулна.

103.3 дахь хэсэг. Гянданд хорих ял эдэлж буй ялтны хөдөлмөр нь энэ хуулийн 74 дүгээр зүйлийн 74.7 дахь хэсгийн хүрээнд зөвхөн гяндангийн нутаг дэвсгэр дээр зохион байгуулагдана.

103.4 дахь хэсэг. Ялтны хөдөлмөрийг ашиглахыг хориглосон ажлын жагсаалтыг Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулсан дүрмээр тодорхойлогдоно.

103.5 дахь хэсэг. Ялтны үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын үндсэн зорилт болон ялтныг хүмүүжүүлэх явдалд саад болох ёсгүй.

103.6 дахь хэсэг. Ялтнуудад хөдөлмөрийн маргааныг зохицуулахаар ажлаа хийхгүй байхыг хориглоно. Ажлаасаа татгалзах, ажлаа зогсоох явдал нь ял эдлүүлэх тогтоосон дэглэмийг санаатайгаар зөрчсөнд тооцогдон, шийтгэлийн арга хэмжээ хэрэглэх, эд хөрөнгийн хариуцлагад татагдаж болно.

• 104 дугаар зүйл. Хорих ял эдэлж буй ялтны хөдөлмөрийн нөхцөл

104.1 дэхь хэсэг. Ялтны ажлын цагийн үргэлжлэх хугацаа хөдөлмөр, техникийн аюулгүй байдал үйлдвэрлэлийн эрүүл ахуйн дүрмүүд нь ОХУ-н Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид нийцэн тогтоогдоно. Ажлын цагийн эхлэл ба дуусах хугацаа нь Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын захиргаанаас ялтны ажиллаж буй үйлдвэрийн газрын захиргаатай зөвшилцсөний үндсэн дээр тогтоосон эелжийн хуваариар тодорхойлогдоно.

104.2 дахь хэсэг. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага, гянданд ял эдэлж буй ялтны гүйцэтгэсэн ажлын шинж чанарыг харгалзан ажлын цагийг нэмж нэгтгэсэн байдлаар тооцохыг зөвшөөрнө.

104.3 дахь хэсэг. Ялтныг төлбөртэй хөдөлмөрт татан оролцуулсан хугацааг тэдний хөдөлмөрийн нийт ажилласан хугацаанд оруулан тооцно. Ажилласан хугацаг тооцох явдал нь Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын захиргаанд ноогдох ба хуанлийн жилийн үр дүнгээр хийгдэнэ. Ажил биелүүлэхээс системтэйгээр зайлсхийсэн ялтны зохих хугацааг Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын захиргааны шийдвэрээр ажилласан нийт хугацаанаас хасна. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагын захиргааны шийдвэртэй холбогдуулан ялтан шүүхэд гомдол мэдүүлж болно.

104.4 дахь хэсэг. Ажиллаж буй ялтнууд жил тутмын цалинтай амралт авах эрхтэй. Үүнд: Хүмүүжлийн колонид ял эдлэгсдийн хувьд 18 ажлын өдөр, Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн бусад байгууллагад хорих ял эдлэгсдийн хувьд 12 ажлын өдөр болно. Эдгээр амралтыг энэ хуулийн 97 дугаар зүйлд нийцүүлэн Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллагаас гадагш явах болон тийм эрхгүйгээр олгоно. Камертай адилтгах болон нэгдсэн, ганцаарчлан хорих камерт байсан хугацаа нь ялтны жил тутмын төлбөртэй амралтыг бодоход ажилласан хугацаанаас хасч тооцогдоно.

104.5 дахь хэсэг. Ажлын нормыг давуулан биелүүлсэн, хүнд ажил дээрх тогтоосон даалгаврыг үлгэр жишээ биелүүлсэн, тэрчлэн хөдөлмөрийн хортой, аюултай нөхцөлд, Хойд хязгаарын район ба түүнтэй адилтгах газруудад мөн тахир дутуугийн I, 2-р зэрэгтэй 60-аас дээш, 55-аас дээш насны эмэгтэй ялтнууд өөрийн хүсэлтээр ажилласан бол жил тутмын төлбөртэй амралтын үргэлжлэх хугацааг 18 ажлын өдөр хүртэл, насанд хүрээгүй ялтны хувьд 24 ажлын өдөр хүртэл уртасгаж болно.

Сэтгүүлийн нийтлэлийн хэмжээнд тавигдах шаардлага, ОХУ-ын Эрүүгийн ялын гүйцэтгэлийн тухай хуулийн зохицуулах зүйлийн хүрээ-хамрах асуудлын багтаамжаас шалтгаалан сэтгүүлийн дараагийн дугаарт "хорих ял эдлэгсдийн хөдөлмөр эрхлэлттэй холбогдсон бусад асуудал (хөдөлмөрийн хөлс, түүнээс болон ялтны бусад орлогоос

суутгал хийх)", "хүмүүжлийн нөлөөлөл (хүмүүжлийн ажлын үндсэн хэлбэр, арга, ялтны сайн дурын байгууллага, ялтанд хэрэглэх урамшуулал, сахилгын арга хэмжээ)" болон хорих дэглэмийн онцлог, анхаарал татсан хуулийн зүйл, хэсгийн талаархи албан бус орчуулгыг хүргэнэ.

Миний сонгосон судалгааны ажлын энэхүү арга зүй нь та бүгдээс тодорхой асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх боломжийг олгож буйн зэрэгцээ эцсийн зорилго маань судлаач-мэргэшсэн албан хаагчдын байр суурийг хэлэлцсэн асуудлаар нэгтгэн зөвшилцөлд хүрч хууль санаачлагчид дүгнэлт-саналаа уламжлах явдал мөн.

Иймд ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулиас ШШГЕГ-ын холбогдох асуудлыг хариуцсан нэгжтэй хамтран энэхүү хэлэлцүүлгийг ШШГ тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хийж буй багийн ажлын хүрээнд зохимжтой хэлбэрээр хийх саналыг тавих болно.

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХӨГЖЛИЙН ҮЕЧЛЭЛ



Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн ахлах багш, хошууч, докторант Б.Алтангэрэл

Хорих ял эдлүүлэх нь гэмт хэрэг үйлдэн гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийг шүүхийн шийтгэх тогтоолд заасан хугацаа, төрөл дэглэм, нөхцөл журамд хорьж буй төрийн албадлагын онцгой арга хэмжээ ба энэ нь ялтанд үзүүлэх цээрлэл, хүмүүжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэрэгсэл, хуулиар тогтоосон хязгаарлагдмал эрх, үүргийн нэгдлийг бий болгож буй ажиллагаа юм.

Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлалын үечлэлийг тухайн үеийн төр, нийгмийн тогтолцоо, эрх зүйн зохицуулалтын онцлог байдлаас хэд хэдэн байдлаар ангилан авч үзсэн байдгийг ерөнхий байдлаар нь хууль зүйн ухааны доктор Д.Лүндээжанцан, түүхийн ухааны доктор Д.Болдбаатар нарын "Монгол Улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал" бүтээлдээ тусгасан эрх зүйн хөгжлийг хүн төрөлхтөний болон Монголын түүхийн ерөнхий зарчим, онцлогийг нь харгалзан үечилсэнтэй хамааруулж гэмтнийг хорих, хорих ял эдлүүлэх ажиллагааны онцлогийг доорхи байдлаар үечилж болох юм. Үүнд:

1. Монголын эртний улсуудын үеийн хорих ажиллагаа /МЭӨ III-МЭ XIII зуун/

Энэ үед Төв азийн түүхэнд анхны төрт улс Хүннү /МЭӨ 209-МЭӨ 93 он/ бүрэлдэн тогтсоноор эхэлж XIII зууны эхээр Их Монгол Улс байгуулагдах хүртэлх цаг хугацааг хамрана. Дурьдан буй үед манай нутагт эртний нийгэм бүхий Монгол болон бусад угсааны улсууд оршин тогтнож, төр ёс ихэд хэлбэржин, хэв хуулиас бичмэл хууль руу шилжиж эхэлж байсан юм.

Хүннүгийн үед Монголд төр ёсны үзэл бүрэлдэн тогтжээ. Хүннүгийн хуульд ирт үзүүртнийг гаргавал цаазаар аваачина. Хулгайн ялтай хүний гэр бүлийг хураана. Хөнгөн хэрэгтнийг бэрээднэ. Хүндийг цаазаар авна. Арван хоногоос илүү хугацаагаар үл хорино хэмээн заасан байдаг байна. Хүннү улсын тогтоосон хууль цааз, заншилд тулгуурлан гарч ирсэн Сүмбэ / МЭӨ 2-4 зуун/, Их Нирун улс /МЭӨ 3-4 зуун/, Түрэгийн хаант улс /552-745 он/, Уйгарын хаант улс /745- 840 он/, Кидан / 907-1125 он/ зэрэг Монгол газар нутаг дээр төр улсаа байгуулж оршин тогтнож байсан хэдий ч энэ үед хорих ял эдлүүлж байсан баримт материал тодорхой бус байна.

2. Монголын дундад зууны үеийн хорих ажиллагаа /XIII-XX зууны эх/

Цаг хугацааны хувьд 700 гаруй жилийг хамаарсан төр ёсны тухайд мандан буурч явсан нарийн ээдрээтэй үе юм. XIII-XIY зууны үед Их Монгол улс байгуулагдаж, дэлхийн талыг эзэгнэн төр ёсоо тогтоож, "Их засаг" хэмээх гол хуулийн сүр хүч дор олон янзын ястан угсаатан аж төрж байлаа. Судлаачид "Их засаг" хууль дахь ял шийтгэлийн төрлүүд нь андгайлах / тангаргийн эрүү/, золиослох, дөнгөлөх, торгох, ташуурдах буюу шийдэмдэх, гянданд хорих, цөлөх, цаазаар авах ялын төрөлтэй байсан гэж үздэг. Их засаг хуулинд ч гянданд хорих тухай заасан байгаа нь гэмт хэрэгтнийг хорих үйл ажиллагаа түүхийн тухайн үед байсныг харж болох юм.

Гэмт хэрэг хийсэн алтан ургийхныг хорьж, их хуралдайд оруулахгүйгээр шийтгэж байсан түүхэн эх сурвалж байдаг байна.

"Их засаг" хуулийн дараах түүний агуулга, зарчмыг хадгалсан хууль, цаазын чухал эх сурвалж нь 1271 онд батлагдсан "Их Юан улсын хууль цаазын бичиг"-т "Хятад хүн шоронд орвол хоол хүнсээ өөрөө хариуцна", "Монгол хүн шоронд орвол улсаас

хоолломой" гэж заасан нь хорих ял эдлүүлж байсныг харуулж байгаа юм.

Юан гүрний дараа үйлчилж байсан дараахь хуулиуд болох "Алтан хааны цаазын бичиг", "Арван буянт номын цааз", "Хутугтай Сэцэн хун тайжийн шашны бичиг", "Халх цаазын эрхэмийн бичиг" /1507-1640 он/ зэрэг хууль цаазын бичигт хорих шийтгэлийн талаар тэмдэглэгдэн үлдээгүй байна.

1640 оны "Монгол-Ойрадын цааз бичиг"-т заасан ялын төрлүүд дотор "Газар нүхэнд хорих", "Баривчлах" зэрэг ялын төрөл байсан байна.

1709-1795 оны "Халх журам"- хуулиар үйлдэгдсэн хэргийн байдал, учруулсан хор хохиролын их бага, хүнд хөнгөнийг харгалзан ногдуулах шийтгэлийн олон шинэ төрөл хэлбэр анх удаа тогтоосон ба алах, жанчих, хадах, гавлах мэтийн шийтгэл олширсоноос гадна "газар ухаж гяндан болгож хэрэглэх" /нүхэнд хорих, гавлаж хорих, бүх насаар нь хорих төрөлтэй байсан байна/, ялыг хэрэглэдэг байжээ.

XYIII- зууны үед зохиогдсон Монгол цаазын бичигт "Гяндан" гэдэг ойлголтыг алах ялаар шийтгэгдсэн этгээдийг хорих ба Хорчины арван хошуу, Түмдийн хоёр хошуу, Шаруудын арван хошуу, Харчины гурван хошууны хүн бол Ба-Гогийн газар байрлах Монгол иргэний зарга шүүх Түн-жингийн яаманд, Онигуудын хоёр хошуу, Үзэмчиний хошуу, Сөнөдийн хоёр хошуу, Халхын хан аймгийн арван есөн хошуу, Халхын цэцэн ханы хорин нэгэн хошууны хүн бол долоон нуурт байрлах Монгол иргэний зарга шүүх Гүн-Жингийн яаманд, Ордос долоон хошуу, Түмдийн хоёр хошуу, Халхын засагт ханы арван таван хошууны хүн бол Хөх хотод байрлах зарга шүүх яаманд тус тус хүргүүлж гянданд хорьж байхаар заажээ.

1860 оны Монгол-Ойрадын цааз бичигт "газар нүхэнд хорих" ялыг хэрэглэж байсан, харин "Халх журам"-ын 204 дүгээр зүйлд: Архи захалгүй дахин уувал хулгайчийн ёсоор жил дуустал хадья", 212 дугаар зүйлд: хэн хүн хулгай хийвээс хааш хаашаа дөрөв дөрвөн алд, өргөн, гүн газар ухаж нэг жил дуустал хадъя" гэжээ. /"Хадъя" гэдэг шоронд хийхийг хэлнэ/. Үүнээс үзвэл манайд эрт үеэс хорих ялыг ямар нэг хэмжээгээр хэрэглэж байсан бөгөөд ихэнхдээ тусгайлган бэлтгэсэн "хар гэр", газар нүхэнд хорьж шийтгэж байсан байна.

Харин XY зуунаас Монголын төр ёс алдарч эхлэн улмаар XVI зуунаас XX зууны эх хүртэл Манж чин улсын ноёрхолд орсон билээ. Түүхийн ээдрээтэй ийм нөхцөлд Монголчууд төр ёсныхоо уламжлалыг өвлөн хадгалахыг эрмэлзэж, үндэсний өнгө аястай олон хууль цаазыг боловсруулан мөрдөж байсан. Жишээ нь: 1911-1921 он хүртэл "Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг"-т ялын төрөл дотор 60 хоног хүртэл дөнгөлж хорих, гяндлах зэрэг ял шийтгэлийн төрлийг тогтоож өгсөн байна.

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь эртнээс үүссэн хэдий ч нүүдэлчин ард түмний дунд хорих ялыг төдийлэн хэрэглэх боломжгүй, үүнтэй холбоотойгоор зориулалтын хорих байргүй, гэмт хэрэг үйлдэгчдийг гав гинж зүүлгэн айлаар хэсүүлж хорих, газар нүхэнд хорих, малын нойтон арьс шир, эсгийд ороох зэрэг аргуудыг хэрэглэж байсан байна.

3. Шинэ үеийн хорих ял эдлүүлэх ажиллагаа /XX зууны 20-иод оноос 90 он хүртэл/

1921 оны долдугаар сард Ардын Намын Төв Хороо, Түр Засгийн газрын хамтарсан хуралдаанаар төрийн яамдыг шинэчлэн байгуулахад Шүүх Яамны ерөнхий хэлтсийн харьяанд "Гяндан салаа" нэртэйгээр байгууллага болсноор эдүгээгийн Хорих байгууллагын эх суурь тавигдсан бөгөөд тухайн үед 1926 оны "Гяндангийн дэргэд түр мөрдөх дүрэм", 1929 оны "Хэрэгтэн ялтнаар ажил үйлдвэр хийлгэх тухай дүрэм" батлагдсан гарч, 1929 оны "Аливаа гяндан, хорионы газарт эрдэм боловсролын хэргийг явуулах тухай" зааврууддаар зохицуулж байсан байна

Энэ үед хорих ял эдлүүлэх ажиллагаанд олон дэвшилт гарсан юм. Үүнд:

1.Хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулах эрх зүйн зохицуулалт бий болсон.

Энэ үе дэх Хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж ирсэн хууль тогтоомжууд нь 1931 оны Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн, ялтныг засан сайжруулах ажлын тухай хууль, 1966 оны БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль, 1981 оны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль зэрэг хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан олон эрхийн актууд хамаардаг байна.

2. Хорих ял эдлүүлэх байгууллагын төрөл, дэглэм бий болсон.

Анх 1931 оны "Монгол Ард Улсын дотор аливаа хэрэгтэн ялтныг засан сайжруулах ажлын тухай хууль"–д ял эдлүүлэх байгууллагын бүтцийг анхлан хуульчлан тогтоосон байна. Тухайлбал :

А/ Түр хорих байшин /аливаа хэргийн учир шүүх таслах газар буюу байцаагч нараас байцааж байгаа хүмүүс, хорих ял шийтгэгдсэн бөгөөд уг тогтоолыг хүчин төгөлдөр болохыг хүлээж байгаа хүмүүс/

Б/ Засан сайжруулах газар /хоригдохоор шийтгэгдсэн бүх хүмүүс, хэрэв тухай орон нутагт өөрөө хорих газрууд байхгүй бол бусад хэрэгтэн, ялтан/

В/ Хөдөөгийн аж үйлдвэрийн колони /3 жилээс дээшгүй хугацаанд хоригдох хүмүүс, урт хугацаагаар хоригдох этгээдүүдийн эдлэх ялын хугацаанаас үлдсэн 3 жил хэтрэхгүй үлдсэн жинхэнэ ажлын ардуудыг/-д тус тус хорихоор заасан байна.

Харин 1966 оны БНМАУ-ын Засан хүмүүжлэх хөдөлмөрийн хуулиар хорих ял эдлүүлэх байгууллагын төрлийг гяндан, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колони, хүмүүжил-хөдөлмөрийн колони гэж ангилаад жирийн, чанга, онцгой дэглэмтэй байхаар заасан төдийгүй тус бүрийн нөхцлийг хуульчилсан байна.

3. Хорих ял эдлүүлэх ажиллагааны зорилгыг анхлан тодорхойлж хэрэгжүүлэх болсон.

Монгол улс 1920-1940 он хүртэл хорих ял эддүүлэх ажиллагааны зорилгоо "Хэрэгтэн ялтныг засан хүмүүжүүлэхэд хоригдогсдын биеийг элдвээр зовоох, доромжлох, жанчих, гар хөлийг хүлэх, харанхуй газар хорих, хоол ундыг хасах, ганцаар хорьж хэрхэвч үл болно", 1940-1970 он хүртэл "Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулсан ялыг хууль ёсоор эдлүүлж, тэднийг хууль ёсыг хүндэтгэн сахиж, социалист нийгмийн амьдрал, хөдөлмөрт хэвшүүлэн дахин хүмүүжлэх, тэднээс шинээр гэмт хэрэг үйлдэх буюу нийгэмд хортойгоор нөлөөлөх явдлаас урьдчилан сэргийлэхэд оршино", 1970-1990 он хүртэл "ялтныг үйлдсэн гэмт хэрэгт нь цээрлүүлэх төдийгүй, хөдөлмөрт үнэнч шударга ханддаг, хуулийг нарийн чанд биелүүлдэг, хамтын аж байдлын социалист хэв журмыг хүндэтгэдэг үзэлтэй болгон засан хүмүүжүүлэх, ялтныг болон бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, эрүүгийн ял эдлэлтийн биелэлтийг хангах, түүнчлэн гэмт хэргийг арилгахад тус дөхөм үзүүлэх явдалд оршино" гэж тодорхойлжээ.

4. Хорих ял эдлүүлэх ажиллагаанд гэмт хэрэг үйлдсэн ялтныг социалист амьдралын хэв маяг, үзэл суртлаар сурган хүмүүжүүлэх, нийтийн хөдөлмөр эрхлэлтийн асуудалд түлхүү анхаарал хандуулах болсон байна.

4. Монголын нэн шинэ үеийн төр, эрх зүй /1990 оноос өнөөг хүртэл/

1990 онд Үндсэн хуульд нэг намын ноёрхлыг халсан өөрчлөлт хийж, улмаар 1992 онд ардчилал, хүний эрхийн дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг гүнзгий тусгасан Үндсэн хуулийн хүрээнд хорих ял эдлэгсдийн эрхийг дээдлэх, нөхцөл журмыг сайжруулах чиглэлээр олон хууль тогтоомж гарсан нь 1993 оны "Хорих байгууллагын болон хорих ял эдлүүлэх тухай Монгол Улсын хууль", 1996 оны "Шүүхийн шийдвэр биелүүлэх хууль", 2002 оны "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хууль" зэрэг хууль тогтоомжийн үйлчлэлийн үе хамаарч өнөөгийн байдлаар хорих ял эдлүүлэх ажиллагааг Монгол Улсын Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан Монгол Улсын Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын баталсан 40 гаруй тогтоол,

тушаалуудаар хэрэгжүүлж байна.

Өнөөдөр хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, ялтны эрх ашгийг хангах, тэдний хоригдох нөхцөл журмыг сайжруулах, ялтныг нийгэмшүүлэх, ажлын байраар хангах хүрээнд хөдөлмөр зохион байгуулалт, байгууллагын менежментийг боловсронгуй болгох, төлбөртэй ялтны төлберийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, ял эдлүүлэх ажиллагааны эцсийн дүнд эрүүгийн ялын зорилгыг бүрэн хангадаг байх зэрэг олон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шаардлага урган гарсаар байна.

Түүнчлэн хорих ял эдлүүлэх ажиллагааны үзэл баримтлал, чиглэл нь тодорхой бус тухайлбал ялтныг нийгэмшүүлэх эсвэл хүмүүжүүлэх, хөдөлмөрлүүлэх чиглэлийн алийг нь баримтлах, хорих байрны орчин нөхцлийн стандарт тодорхой бус байгааг хуульчлах хэрэгцээтэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хөгжлийн стратеги, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрхэм зорилго, стратеги зорилт зэрэгт тусгагдсан гол заалт нь хорих ял эдлүүлэх ажиллагааг олон улсын жишигт нийцсэн нөхцөлд хүргэнэ гэж заасан байдаг.

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь олон улсын жишигт нийцсэн нөхцөлд хүргэх нь зөвхөн ялтны байр, орчин бусад ахуй хангалтыг зарим нэг оронтой жишиж тухай асуудлаар хязгаарлахгүй бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас ял эдлүүлэх чиглэлээр батлан гаргасан олон улсын гэрээ, конвенцэд нэгдэн орж тухайн баримт бичгийн үзэл баримтлалыг дотоодын хууль тогтоомждоо тусган нийцүүлэх, хорих ял эдлүүлэх ажиллагаа нь хорих ялын зорилгыг хангахад чиглэсэн дэглэм, арга, хэрэгсэлтэй, ялтны эрх, ашиг, хэрэгцээг хангах орчин нөхцлийг дотоодын хууль тогтоомждоо хуульчлах, албан хаагч нь хорих байгууллагын чиглэлээр мэргэшсэн байхад оршиж байгаа ба дээрх зорилгыг шийдвэрлэх нэг арга зам нь хорих ял эдлүүлэх ажиллагааны чиглэлээр эрх зүйн шинэчлэл хийхэд чиглэж байна.

Дэлхийн улс гүрнүүдийн өнөөгийн хөгжлийн явц дахь глобалчлал, хөгжлийн түвшин, бусад байдалтай уялдан хорих ял эдлүүлэх ажиллагаандаа баримталж буй үзэл баримтлал нь аль болох хорих ял оногдуулахаас зайлсхийн ялын өөр төрлийг сонгон хорих газрын бөөгнөрлийг багасгах, ял эдлэгсдийг хоригдож байх хугацаанд нь нийгэмшүүлэн, ялтныг ажлын байраар бүрэн ханган, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрх ашгийг бүрэн хангах, хорих газраас суллагдаад дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх зан үйл, нийгмийн болон бусад орчин нөхцлийг нь бүрдүүлэхэд чиглэж байна.

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь эрүүгийн ялын бодлого, зорилгыг хангахад чиглэх ба эрүүгийн ялын бодлого нь тухайн улс орны хөгжлийн шат дахь нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүйн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журмыг хангах, хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэг хэрэгжүүлэхэд төрөөс баримталж буй чиглэл бөгөөд төрөөс эрүүгийн ялын бодлогод эрүүгийн ялын оновчтой төрөл, тогтолцоог бий болгох, оногдуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох, түүгээр дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зэрэг арга хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлэх нь чухал юм.

Дээрх асуудлыг шийдвэрлэх хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хорих ял эдлүүлэх ажиллагааны үр дүнд ялын зорилгыг хангах, хорих ял эдлүүлэх дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх, нийгэмшүүлэх ажлыг хуульчлан тогтоох чиглэлээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, тодорхой судалгааны ажлыг хийж байна.

ЦААЗААР АВАХ ЯЛААС МОНГОЛ УЛС ТАТГАЛЗСАНААР ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ҮҮСЧ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ ХАНДЛАГА



ДХИС-ийн ШШГС-ийн Аюулгүй байдал, харуул хамгаалалтын тэнхимийн эрхлэгч, докторант, хошууч Б.Нямгомбо

Ялын дээд хэлбэр болох цаазаар авах ял нь төр, хууль цааз анх үүссэн тэр цаг үеэс нийгэмд бий болж, одоог хүртэл агуулга, хэлбэрийн хувьд хэрэглэгдэн ирсэн бөгөөд "цаазаар авах ял" гэсэн нэрийг Монголын төр, хууль цаазны түүхэнд "амийг авах" буюу "амийг нь аваачих" гэсэн томъёоллоор хэрэглэж иржээ.

Мөн төрийн эртний хууль тогтоомжид "алах", 1926 оны "Хууль цаазны бичигт "буудан алах" гэж томьёолсон бол түүнээс хойшхи хууль тогтоомжид "цаазаар авах" хэмээн нэрлэх болсон байна. Гэвч судлаач миний зүгээс Монгол Улс түүхэн хөгжлийнхөө явцад цаазаар авах ялыг хэрэглэж байсан түүхэн уламжлал талаас бус энэ ялаас татгалзах талаар хууль тогтоох эрх бүхий байгууллагаас авч хэрэгжүүлж байсан бодлого шийдвэр, түүний хэрэгжилт, үр нөлөөний талаар та бүхэнтэй асуудал дэвшүүлэн санал солилцохоор зорьсон юм.

Монгол Улсын хууль тогтоох байгууллага түүхэн хугацааны явцад цаазаар авах ялыг халах асуудлыг нэг бус удаа авч хэлэлцэж байжээ.

АИХ-ын Тэргүүлэгчдийн 1953 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн 93 дугаар зарлигт "БНМАУ-д дагаж шийтгүүлэн байгаа хуулиудаар тогтоосон алах ялыг хэрэглэхгүй болгож" цаазаар авах ялыг бүрэн халж байсан түүхэн уламжлал байх бөгөөд 1991 онд Улсын Бага Хурлаар цаазаар авах ялыг халах тухай хуулийн төслийг хэлэлцэж байсан ажээ.

Нэгдсэн Үндэсний Байгууллагаас дэлхийн нийт улс орнуудыг цаазаар авах ялаас татгалзахыг уриалж, 2007 оны 12 дугаар сарын 18-ны өдөр 62/149 дугаар анхны тогтоолыг баталсан бөгөөд энэ асуудлаар 2008 оны 12 дугаар сарын 18-ны А63/430 дугаар хоёр дахь тогтоолоо баталсан байна.

НҮБ-аас баталсан "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт"-ыг Монгол Улс 1974 онд соёрхон баталсан. Энэ пактын 6 дугаар зүйлд "Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй. Энэ эрхийг хуулиар хамгаална, хэний ч амь насыг дур мэдэн бусниулж болохгүй" гэж зааснын хэрэгжүүлэх, НҮБ-ын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэн цаазаар авах ялыг эрс бууруушаан, энэ ялаас татгалзахыг гишүүн орнууддаа байнга сануулсаар байгаа уриалгыг Монгол Улс олон улсын жишгээр дэмжсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2010 оны 1 дүгээр сард Улсын Их Хурлын Нэгдсэн хуралдаанд "Хүний эрх, эрх чөлөөт байдлын эрхэм дээд шалгуур бол түүний хэрэгжилт бүрэн байхад оршино. Иймээс Монгол улсын төр, цаазаар авах ялын тухай бодлогоо хожимдсон ч гэсэн эргэж харах хэрэгтэй. Учир нь дэлхийн улс орнуудын бараг дийлэнх олонхи нь цаазаар авах ялаас татгалзах замыг сонгожээ. Бид ч энэ замд нэгдэх ёстой. Ардчилсан Монголын зам ариун, цусгүй байх ёстой" гэж цаазаар авах ялын талаарх өөрийн байр сууриа илэрхийлж, цаазаар авах ялыг хэрэглэхгүй түдгэлзэж байгаагаа мэдэгдсэн.

Өнөөдөр Европ тивийн 42 орноос 40 оронд цаазаар авах ялыг хэрэглэхийг зогсоож, цаазаар авах ялаас 1 улс албан ёсоор түтгэлзсэн, Африк тивийн 43 орноос 18 улс цаазаар авах ялыг бүрэн халж, 11 улс цаазаар авах ялыг хэрэглэхгүйгээ мэдэгдэж түдгэлзсэн, Латин Америкийн 18 орноос 14 улс цаазаар авах ялыг халж, хүний эрх, эрх

чөлөөг дээдэлсэн улс болохоо батлан харуулжээ

Монгол Улсын түүхэнд шүүх алдаа гаргаж гэм буруугүй хүнд цаазаар авах ял оногдуулж байсан баримт цөөнгүй байдаг. Тухайлбал: 1930-аад оны үед болсон улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж, шүүх, шүүхийг орлон ажилласан тусгай комисс, онцгой бүрэн эрхт комиссын шийдвэрээр цаазаар авах ялаар шийтгэгдсэн жирийн иргэн, лам хуврага олон мянган хүний хэргийг шүүх өнөө хэр нь хянан хэлэлцэж, цагаатгаж, хуулийн дагуу нөхөн олговор олгож байна.

Иргэн Ч.Эрдэнэ-Очирыг бусдыг санаатай алсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж үзэж Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Е"-д зааснаар анхан шатны шүүх түүнд 1996, 1997 онуудад цаазаар авах ял оногдуулж байсныг Улсын дээд шүүх тухай бүрд нь хянаж үзэж, нэмэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгэхээр буцааж байсан бөгөөд сүүлд нь Улсын дээд шүүх 1998 оны 06 дугаар тогтоолоор түүнд оногдуулсан цаазаар авах ялыг 25 жил хорих ял болгон өөрчилж байжээ. Улсын дээд шүүх Ч.Эрдэнэ-Очирт холбогдох хэргийг дахин хянан хэлэлцээд 2002 оны 218 дугаар тогтоолоор хэргийг хэрэгсэхгүй болгож, Ч.Эрдэнэ-Очирыг хорих газраас суллаж байсан байна.

Хэргийг шалгаж, шүүх хэрэгсэхгүй болгох хүртэл Ч.Эрдэнэ-Очирт 7 жил хоригдсон бөгөөд шүүх түүнд 18 сая төгрөгийн нөхөн төлбөр олгож байсан баримт байдаг.

Эрүүгийн хариуцлага нь иргэн, нийгмийн гэмт халдагаас хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилготой бөгөөд "цаазаар авах ял" нь энэ зорилгыг хэрэгжүүлэхэд бодитой нөлөө үзүүлж байгаа эсэхэд эрдэмтэн, судлаачид харилцан адилгүй байр суурьтай байдаг. Тухайлбал: Монгол Улсын өнөөгийн эрүүгийн нөхцөл байдал хүндэрч, онц жигшүүртэй гэмт хэргүүд гарах, түүнчлэн шинэ төрлийн гэмт хэрэг болох хүн худалдаалах, мансуурах, сэтгэцийн эм хэрэглэх, борлуулах, тээвэрлэх болон мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг ихсэх хандлагатай байгааг нуух учиргүй бөгөөд бага насны хүүхдийг хүчирхийлсэн, галдан шатаасан, хүний амь насыг хэрцгийгээр бүрэлгэсэн гэмт хэрэгтнүүдэд шүүх тохирсон ялыг оногдуулах "амийг амиар солих" гэсэн үзэл бодолтой хүмүүс байхад, зарим судлаачид онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд зохих хариуцлага хүлээх нь зүйн хэрэг гэвч хохирогчийн ар тал уй гашууд автан харамсахын адил ялтных ч бас л гашуудна.

Энэ байдалтай холбогдуулан Олон улсын "Эмнести Интернешнл" байгууллага "хүний эрх, энэрэнгүй байдлын төлөө тэмцэхдээ мунхаг иргэд нэгийгээ алах, түүн дээр нь нэмж төрөөс аллага явуулах нь үнэхээр мулгуу явдал" гэж тодорхойлсонтой судлаач миний зүгээс санал нийлж байдаг.

Эндээс үзэхэд МУУХ-ийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Хүн бүр амьд явах эрхтэй" гэж томъёолсныг тунгаан бодуушгай.

Монгол Улс олон улсын жишиг хандлагын хүрээнд цаазаар авах ялаас татгалзаж байгаа нь:

- Монгол Улсын Үндсэн хуульд заасан "Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэх эрхэм зорилго"-ыг хэрэгжүүлэх;

- Монгол Улсын гадаад, дотоод дахь нэр хүнд үлэмж өсөх таатай нөхцөл байдал бий болох боломжтой;

- Хүний хамгийн үнэт зүйл болох амь нас буюу хүний амьд явах эрх хангагдах;

- Хууль хяналтын байгууллагаас гэм буруутай нь нотлогдож, тогтоогдоогүй байхад шүүх алдаа гаргаж гэм буруугүй хүнд цаазаар авах ял оногдуулсан тохиолдолд эргээд засч, залруулах боломжтой зэрэг чухал ач холбогдолтой. Гэвч цаазаар авах ялыг 30 жилээр хорих ялаар солих тохиолдолд түүнийг хаана, ямар орчин, нөхцөлд эдлүүлэх

нь тодорхойгүйгээс хорих байгууллагад ялтны зүгээс үзүүлж болох сөрөг хандлага ямар байх талаар урьдчилан тооцоогүй байгаа нь өнөө үед анхаарах нэг асуудал болоод байна.

Тухайлбал: УДШ-ээс жилд дунджаар 18-23 ялтанд цаазаар авах ял оногдуулж Монгол Улсын Ерөнхийлөгч цаазаар авах ял оногдуулсан УДШ-ийн материалтай танилцаад жилд 3-5 ялтныг 30 жилийн хорих ялыг гянданд ял эдлэхээр солих тохиолдол практик бий бөгөөд Монгол Улс цаазаар авах ялаас татгалзаж эхэлсэн үеэс хойш жилд дунджаар 15-20 ялтан гянданд 30 жилийн хорих ялаар шийтгэгдэн ирэх болжээ.

Энэ нь гянданд ял эдлэгсдийн тоо эрс нэмэгдэн байрны хүрэлцээ хангалтгүйгээс, рецедив гэмт хэрэгтнүүд нэг газар төвлөрөх болж, тэдний зүгээс зохион байгуулалттай хорих байгууллагын үйл ажиллагааг эсэргүүцэх, эмх замбараагүй байдал бий болгох, бусдыг барьцаанд авах, албан хаагчдын амь бие, эрүүл мэндэд халдах, бүлэглэн, зэвсэглэн оргох боломжийг бүрдүүлж байгаад ихээхэн анхаарах шаардлагатай байна.

Хорих ангид ял эдлэгсдийн дотор урьд төдийлөн үйлдэгддэггүй байсан хар тамхи, хүний наймаа, мэдээллийн аюулгүй байдлын болон мөнгө угаах гэмт хэрэгт ял эдлэх ялтны эзлэх хувь өссөн, түүнчлэн хэд хэдэн төрлийн гэмт хэрэг үйлдээд аль хөнгөн гэмт хэрэгт ял шийтгүүлэн бусад гэмт хэргээ нуун далдлах объект болгон, хорих газрыг ашиглах байдал байсаар байна. Төвлөрсөн 22 хорих ангийн 6754 ялтны дунд явуулсан судалгааг авч үзвэл:

Урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс дахин хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн ялтан /2000-2010/





Дээрх судалгаанаас харахад улс орны нийгмийн эдийн засгийн хөгжлийн чиг

хандлагаа дагаад гэмт хэрэг үйлдэх этгээдүүд улам бүр бүлэг зохион байгуулалтын шинжид орж, үйлдлийн арга, сэдэл нарийсч эрүүгийн гэмт этгээдүүдийг бизнесийн нөлөө бүхий этгээдүүд хуулийн хэлтэст ажиллуулах нэрийдлээр өөрсдийн бизнесийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, бусдад нөлөөлүүлэхийг оролдох, захиалгаар гэмт хэрэг үйлдүүлэх тохиолдолд гарч эхлээд байна. Тухайлбал:

Бусдын нөлөөнд автаж гэмт хэрэг үйлдсэн шалтгаан нөхцөл



■ бусдын нөлөөнд автаж гэмт хэрэг үйлдсэн шалтгаан

Давтан гэмт хэрэг үйлдсэн шалтгаан



■ гэмт хэрэг үйлдсэн шалтгаан

Түүнчлэн онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, рецедив гэмт хэрэгтнээр тооцогдсон этгээдүүд хорих байгууллагын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаанд өөрөө болон бусдаар нөлөөлүүлэхийг оролдох, өөртөө ашигтай шийдвэр гаргуулахыг эрмэлзэх, албан хаагчийг янз бүрийн аргаар эрхшээлдээ оруулахыг хичээх, харуул хамгаалалтын албан хаагчдын амь бие, эрүүл мэндэд халдах, хэл амаар доромжлох, харуул хамгаалалтын сул байдлыг ашиглан оргох гэх мэт үйлдэл байнгын буюу тасралтгүй шинжтэйгээр үйлдэгдсээр байна.

Хорих болон баривчлах ялаар шийтгүүлсэн ялтны тоо/2006-2011/



Эндээс хорих байгууллагын харуул хамгаалалтын албан хаагчдын харьцаа, чанга, онцгой, гянданд ял эдлэгсдийн тоотой харьцуулж үзвэл: /Ойролцоогоор/

Өнөөдрийн байдлаар: Чанга, онцгой, гянданд 3800-4500 орчим ялтан 9 хорих ангид ял эдлэж байна. 1 хорих ангид 1 өдөр ойролцоогоор 9-12 албан хаагч 24-48 цагаар харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байна. 350-450 гаруй ялтантай хорих ангид 1 харуул хамгаалалтын албан хаагч ойролцоогоор 70-90 ялтанд харуул хамгаалалтыг хяналт тавьж байна. Эндээс үзэхэд Монгол Улсын хэмжээнд чанга, онцгой, гянданд хоригдож байгаа хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, рецедив гэмт хэрэгтнээр тооцогдсон 3800-4500 ялтанд 1 өдөрт 80-90 албан хаагч хяналт харуул хамгаалалтыг зохион байгуулж байна.

Энэ нь 3 буюу түүнээс дээш удаагийн ял шийтгэлтэй хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон этгээдүүдийн тоо нэмэгдэж, нэг газар төвлөрснөөр хорих байгууллага, албан хаагчдын амь бие, эрүүл мэндэд учирч болох аюул занал ямар түвшинд байгааг харуулж байна.

Эндээс дүгнэж үзэхэд:

Монгол улсын дотоодын дайсан болсон гэмт хэрэгтнийг нийгмээс тусгаарлан, болзошгүй гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага өнөөдөр хэвийн явуулж байгаа боловч цаашид шинэ төрлийн гэмт хэрэг болох хар тамхи, мансуурах бодис хэрэглэх, зөөвөрлөх, худалдан борлуулсан болон хүний наймаа, зохион байгуулалттай аллага, хүчирхийлэл, бэлгийн болон сэтгэцийн гаж зуршилтай этгээдүүдэд тавих хяналт, харуул хамгаалалт, тэдгээрийг ямар орчин нөхцөлд ял эдлүүлэх нь хорих байгууллагын үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээл болоод байна.

Иймд дараах саналыг дэвшүүлж та бүхэнтэй хамтран санал солилцохыг зорьлоо.

- Цаазаар авах ялаас татгалзсан тохиолдолд ялын дээд хэмжээний нэршил /Онцгой ял/ 30 жил хорих гэсэн асуудлыг дэлхийн нийтийн чиг хандлагын хүрээнд хэлэлцэн эцэслэн тодорхой болгох,

- Онцгой ялаар шийтгүүлэгчдийн эдлэх эрх, үүрэг, сайшаал урамшил, сахилгын шийтгэл, ямар орчин, нөхцөлд ял эдлэх /нийтийн эсвэл камерын/ байх талаар тусгайлан хууль гаргах аль эсвэл "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль"-д дэглэмийн нэг төрөл болгон оруулж, шинэ хорих ангийг дэлхийн жишигт нийцүүлэн барих,

- Эрх зүйн хувьд ялын дээд хэмжээ 30 жил болсон тохиолдолд хорих ялын дээд хэмжээнд өөрчлөлт оруулах. Тухайлбал: Онцгой, гянданд ЭХ-ийн 91.2. зааснаар 25 жилийн хорих ялаар шийтгүүлсэн этгээд хорих ангид хүмүүжих явцдаа орчин нөхцөлдөө дасан зохицож чадахгүй байдал, ялтнуудын дарамт шахалтаас болж сэтгэл зүйн хувьд

хорих ангид ямар ч гэмт хэрэг үйлдсэн 5 жил нэмүүлнэ гэсэн хандлага их болж хорих ангийн нөхцөл байдал хүндэрнэ. Иймд Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах замаар хорих ялын дээд хэмжээ, онцгой ялын дээд хэмжээний ялгаа заагийг тодорхой болгох,

- Шинэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг тусгайлан хорих, тэдгээр этгээдүүд, шинэ төрлийн гэмт хэргийн талаар албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх. Тухайлбал: хар тамхи, мансууруулах бодис, хортой химийн бодис /цианит натри, нитридийн давс, мөнгөн ус гэх мэт/ хэрэглэсэн хэргээр давтан ял шийтгүүлж эхэлсэн бөгөөд хар тамхины ургамлын төрөл, хорих ангийн хашаанд ургаж буй эсэх, хэрэглэсэн үед хүний оюун ухаанд гардаг өөрчлөлтийн талаар тус байгууллагын албан хаагч ямар ч төсөөлөлгүй байна.

- Хорих байгууллагын хяналт, харуул хамгаалалтанд ашиглаж байгаа техник хэрэгслийг шинэчлэх, харуул хамгаалалтын албан хаагчийг аль болох ялтанд зайнаас хяналт тавих механизмыг бүрдүүлэх

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь өмнөө тавьсан зорилтоо амжилттай хэрэгжүүлэн, алба нэгжийн үйл ажиллагаа хэвийн зохион байгуулагдаж байгаа боловч, энэхүү илтгэл нь судалгааны түвшинд асуудал дэвшүүлсэн материал учир холбогдох санал, шүүмж нь судалгааны ажлын үр дүнд тус дэм болох тул та бүхэн E-mail: nyamgombo_3@yahoo.com хаягаар өөрийн санал бодлоо хуваалцахыг хүсье.

БҮХ НАСААР ХОРИХ ЯЛ, ТҮҮНИЙГ ЭДЛҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ



ШШГЕГ-ын хэлтсийн дарга, докторант, дэд хурандаа Ц.Очгэрэл

Дэлхий нийтийн анхаарлын төвд байсаар байгаа цаазаар авах ялыг хэрэглэх эсэх талаар улс орон болгон харилцан адилгүй бодлого баримталж ирсэн бөгөөд өнөөдрийн байдлаар цаазаар авах ялыг практикт болон хуульчлан халсан 140 гаруй орон байгаа талаар судлаачид тэмдэглэжээ.

Өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн зарим заалтуудад ялын дээд хэмжээ буюу эрүүгийн онцгой төрлийн ял болох цаазаар авах ялыг оногдуулах тодорхой тохиолдлуудыг заан тодорхойлсон байгаа хэдий ч Монгол Улсын Ерөнхийлөгч 2010 онд цаазаар авах ялыг гүйцэтгэхгүй байх талаар албан ёсны мэдэгдэл хийсэн. Мөн "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколд нэгдэн орох тухай" хуулийг Улсын Их Хурлаас 2012 оны 1 дүгээр сарын 05-ны өдөр хэлэлцэн баталснаар Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн байгууллагын өмнө цаазаар авах ялыг халахтай холбоотой шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тодорхой үүрэг хүлээх эрх зүйн үндэс баталгаажсан гэж үзэж болно.

Ийнхүү Монгол Улс нь цаазаар авах ялыг халах бодлогыг хуулиар баталгаажуулсан энэ цаг үед Монгол Улсын Ерөнхийлөгчөөс "Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл" санаачилсан бөгөөд уг төсөлд тусгаснаар ялын шинэ хэлбэрийг "Бүх насаар хорих ял" хэмээн тодорхойлж, холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар төсөл боловсруулагдсан байна.

Эрдэмтэн, судлаачдын зүгээс ялын дээд хэмжээ буюу цаазаар авах ялыг онцгой ял хэмээн тодорхойлж ойлгодог ба нэгэнт цаазаар авах ялыг халах тохиолдолд сольж хэрэглэх ял нь эрүүгийн эрх зүйн зарчимд нийцсэн, улс орны эрүүгийн ялын бодлогод сөрөг нөлөө үзүүлэхгүй шинжийг агуулсан байх нь зүйн хэрэг юм. Өөрөөр хэлбэл тухайн гэмт үйлдлийн нийгмийн хор аюул, шинж чанарт тохирсон байхын зэрэгцээ эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахуйц байх ёстой болно.

Бүх насаар хорих ялыг хуульчлан тогтоохын өмнө зайлшгүй анхаарвал зохих нэг зүйл нь олон улсад хэрэглэгдэж байгаа "Бүх насаар хорих-Хугацаагүй хорих" гэсэн хоёр ойлголтын хооронд ялгаа бий эсэхийг нарийвчлан тогтоох нь зүйтэй болов уу. Үг зүйн утгаар нь шинжилж үзвэл "Бүх насаар нь хорих" гэдэг нь тухайн ялтанд ямар нэг өршөөл байхгүйгээр насан эцэслэтлээ хорих ял эдлэх агуулгыг илэрхийлж байгаа бол "Хугацаагүй хорих" нь хуулинд заасан хорих ялын хугацаанаас илүү хугацаагаар хорих буюу тодорхой хугацааны дараа ялаас чөлөөлөх боломж үүсч болох санааг агуулж байна гэж үзэж болох юм. Иймээс эрх зүйн зарчмын үүднээс ял шийтгэгдсэн этгээдэд хүмүүнлэгийн үүднээс хандаж боломж олгох, итгэл найдвар үлдээх эсэх нь энэхүү хоёр төрлийн нэршлээс хамаарах мэт ойлголт төрж байна.

Нөгөө талаас эрүүгийн ялын бодлогын үр нөлөөгөөр нь ял шийтгэлийн хамгийн хүнд төрөл болох хорих ялын дээд хязгаар хэмээн тооцож, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн, нийгмийн аливаа харилцаанд ноцтой хохирол учруулсан этгээдэд цээрлүүлэх шинж чанартайгаар зайлшгүй оногдуулж болох ял гэж үзвэл "Бүх насаар хорих ял" гэж тогтоох нь илүү тохиромжтой байх хувилбар гарч байна. Энэ нь хохирогчийн сэтгэл зүйд үйлдсэн гэмт хэрэгт тохирсон ял оногдуулах буюу ял шийтгэл гарцаагүй, оновчтой байх талаар зохих

нөлөөлөл үзүүлж болох талтай.

Эндээс "Бүх насаар хорих-Хугацаагүй хорих"-ын аль ч нэршлээр хэрэглэсэн тухайн ялтанд тодорхой ял эдлэх хугацааны дараа зан төлөв, хандлагын хувьд болон хууль журамд нийцүүлэн биеэ авч явах байдал зэргээрээ эерэгээр өөрчлөгдөх боломж олгох нь эрүүгийн хариуцлагын зорилгыг хангагдах нөхцлийг бүрдүүлэхээс гадна хүнлэг ёсыг сахих, хүний эрхийг дээдлэх зарчимд нийцсэн зохицуулалт болох юм. Иймд эрүүгийн ялын бодлого, хүмүүнлэгийн зарчмын аль алиныг хослуулах замаар ялын дээд хэмжээг "Бүх насаар хорих ял" хэмээн тодорхойлохын зэрэгцээ тодорхой хугацаа тогтоож тухайн ялтанд төрийн өршөөл, энэрлийг хүртэх боломж олгох асуудлыг хамтад нь хуульчлах нь зүйтэй юм.

Түүнчлэн хорих ялын шинэ төрөл, хэмжээг хуульчлан тогтоохын өмнө одоогийн боловсруулагдаж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, тус салбарт хийгдэж буй бодлогын өөрчлөлттэй уялдуулан авч үзэх шаардлага гарч ирж байна.

ХЗДХЯ, ШШГЕГ-аас хамтран боловсруулж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн агуулга нь шүүхийн бүхий л төрлийн шийдвэрийн биелэлтийг нэг мөр, бодит хэлбэрээр хангаснаар эрүүгийн ял эдлүүлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэгдэж байгаа юм.

Тухайлбал хорих ял эдлүүлэх чиглэлээр хоригдогчийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн буюу гэмт зан үйл, хандлагыг өөрчлөх, нийгмийн идэвхитэй гишүүн болгон чадавхижуулах, сургалт, нөлөөллийн ажлын зөв тогтолцоог бий болгох, хорих ял шийтгэгдсэн этгээдийг албадан хөдөлмөрлүүлэх, улмаар гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг үр дүнтэй барагдуулдаг нөхцлийг бүрдүүлэх зэрэг үндсэн үзэл баримтлалуудыг тусгаж өгсөн.

Хорих ял эдлүүлэх дэглэмийн хувьд ялын зорилгыг хангахад илүү тохиромжтой хэлбэр буюу нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэхээр тусгасан нь ял эдлүүлэх тогтолцоон дахь сөрөг үр дагавар болох хоригдогсод гэмт зан үйлд дадлагажих, шоронжих нөлөөллийг багасгахад чухал нөлөөтэй гэж үзсэн.

Энд нэг зүйлийг зориуд онцлон тэмдэглэхэд нээлттэй болон хаалттай дэглэмийн алинд ялтныг ял эдлүүлэх асуудал нь цэвэр ялтны хувийн байдлаас шалтгаалах ба тухайн ялтны хувийн зан үйл, ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй хууль, тогтоомжид нийцүүлэн биеэ авч яваа байдал нь хэдий чинээ зөв хандлагыг агуулж байна тэр хэмжээгээр илүү нээлттэй, хуулийн болон эрхийн урамшуулалтай хэлбэрээр ял эдлэх боломжийг олгох, эсрэгээрээ хорих байгууллагын дотоод дэг журмыг зөрчсөн, гэмт буюу сөрөг зан үйлээ өөрчлөхөд идэвхитэй ханддаггүй, ял эдлэх хугацаанд хөдөлмөрлөх, суралцах, төлөвших үүргээ биелүүлж чадахгүй байгаа, бусдад сөрөг нөлөөтэй ялтан хаалттай буюу эрхийн илүү хязгаарлалттай, хуульд заасан хөнгөлөлт боломж нь хаагдсан нөхцөлд ял эдлэх явдал нь энэхүү тогтолцооны гол онцлог юм.

Бүх насаар хорих ялын талаар хуулийн төсөл санаачлагчийн зүгээс тодорхойлохдоо тусгай гянданд буюу ганцаарчлан хорихоор урьдчилан тооцож байгаа энэ үед гяндан буюу ял эдлүүлэх чангаруулсан нөхцөл, түүний нэршлийн талаар саналаа хуваалцъя гэж бодлоо.

Гяндан буюу хорих ангийн төрөл, дэглэмийн алинд ч үл нийцэх хэлбэрийг арилгах нь шинээр боловсруулж буй шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн нэг шинэ зохицуулалт юм. Гяндан хэмээх ойлголт нь эртнээс улс орнуудын ял эдлүүлэх системд хорих ял эдлүүлэх, цагдан хорих чиг үүргийн аль алинийг гүйцэтгэж ирсэн, хатуу хяналт, нөхцөл бүхий хорих байр гэсэн ойлголтоор хэрэглэгдэж ирсэн байдаг.

Шинэ үеийн Монгол Улсын хорих ял эдлүүлэх тогтолцоонд гянданд ял эдлүүлэх чиглэл нь 1966 оны Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хуулинд анх тусгагдсан бөгөөд тухайн үеийн ЗСБНХУ-ын эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйгээс хуулбарлагдан орж ирсэн гэж судлаачид үздэг.

Өнөөдрийн байдлаар шүүхийн практикт онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн

хувийн байдал, гэмт үйлдлийн шинж чанар, учруулсан хохирлын хэр хэмжээ зэргийг харгалзан гянданд ял эдлүүлэхээр тогтоож байгаа ба ял эдлүүлэх хамгийн хатуу хяналт, цээрлэл, хязгаарлалттай нөхцөл хэмээн ойлгож хэрэглэж байна. Тэгвэл одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ШШГТХ, ЭХ, ЭБШХ-д зааснаар гяндан нь хорих анги биш, ял эдлүүлэх дэглэмийн нэг төрөл ч биш байхаар ойлгогдож, хэрэглэгдсээр өнөөдрийг хүрчээ.

Судлаачдын тодорхойлж буйгаар болон дэлхийн бусад орнуудын туршлагаас харвал хорих ял эдлүүлэх ажиллагааг цэгцтэй, үр дүнтэй зохион байгуулахад хорих ялыг эдлүүлж буй нэгж \хорих анги\-ийн бүтэц зохион байгуулалт, нөхцөл журам, үйл ажиллагааны зохион байгуулалт, хяналт, эрхийн хязгаарлалтын онцлог зэрэг нь ялын зорилготой уялдсан байх нь чухал ач холбогдолтой гэдгийг харуулж байна.

Иймд хорих ял эдлүүлэх төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай хэмээх томъёололд бүхэлд нь багтаах замаар гяндан хэмээх ойлгомжгүй төрлийг өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байна. Харин хувийн болон үйлдсэн гэмт хэргийн шинж чанараас шалтгаалан хяналт-хамгаалалт, эрхийн хязгаарлалтын хувьд чангаруулсан нөхцөл бүхийн хорих ангийг "Хаалттай" хэмээх томъёоллоор тодорхойлж ял эдлүүлэх нөхцөл журмаа тогтоох шаардлагатай юм.

Нээлттэй, хаалттай гэсэн дэглэмийн ялгаатайгаар хорих ял эдлүүлэх ажиллагааг зохион байгуулах тохиолдолд хаалттай дэглэм нь тухайн ялтны хувийн байдал, үйлдсэн гэмт хэргийн онцлогоос шалтгаалан ганцаарчлан болон 4 хүртэл тооны хоригдогчийг хамтад нь хорих өрөөний системд ял эдлүүлэхээр тооцох нь илүү үр дүнтэй байх боломжтой юм. Ингэвэл хорих ял эдлүүлэх ажиллагааг ялтны хувийн байдал болон үйлдсэн гэмт хэргийн байдлыг харгалзан зохион байгуулах нөхцөл бүрдэхийн зэрэгцээ хяналт-хамгаалалтын болон нийгэмшүүлэх, хөдөлмөрлүүлэх, бие даан ухамсарлуулах арга хэмжээ үр дүнтэй, ялгамжтай явагдах боломж нээгдэнэ.

Дэлхийн улс орнуудад цаазаар авах ялыг халах бодлого хэрэгжихийн зэрэгцээ ямар төрлийн ялаар сольж хэрэглэж байгааг судалж үзвэл бүх насаар буюу хугацаагүй хорих ялыг сонгон хэрэглэх явдал түгээмэл байгаа нь ажиглагдаж байна.

Тиймээс "Бүх насаар хорих ял"-ыг Монгол Улсын хувьд хуульлан хэрэгжүүлэхдээ бидний боловсруулж буй хаалттай дэглэмд ганцаарчлан эдлүүлэх ба тодорхой хугацааны дараа ял эдлүүлэх нөхцлийг ялтны хувийн байдлыг харгалзан хөнгөрүүлэх зарчмаар эдлүүлэх саналыг дэвшүүлж байна.

Бүх насаар хорих ялыг эдлүүлэхтэй холбоотой дараагийн нэг асуудал нь ял шийтгэгдсэн этгээд чухам хичнээн жилийн хорих ял эдэлсний дараа түүнд ял эдлэх дэглэмээ хөнгөрүүлэх, эрх чөлөөт амьдралд гарах боломж олгох вэ гэсэн зүйл юм.

Өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хүрээнд хорих ял шийтгэгдсэн этгээд оногдсон ялын 50 хувийг эдлэсэн тохиолдолд ял эдлэх дэглэмийг хөнгөрүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэж байгаа. Өөрөөр хэлбэл оногдуулсан ялын тал хувийг эдэлж байж тухайн ялтны зан төлөв, хандлага буюу хөдөлмөрлөх, суралцах, төлөвших явцын үр дүн харагдана гэж тооцож байна гэсэн үг.

Харин "Бүх насаар хорих ял" шийтгэгдсэн ялтны хувьд хуулиар тогтоосон хугацааны дараа тухайн ялтны нийгмийн хор аюул буюу гэмт зан үйл арилсан байх шаардлагатайн зэрэгцээ нийгэмд гарч тодорхой хугацаанд эрүүл, зөв амьдралаар амьдрах итгэл найдвар үлдсэн байх шаардлагатай юм.

Монгол эрэгтэй хүний дундаж нас 64.9 байгаа талаар Үндэсний статистикийн хорооны гаргасан 2010 оны Хүний хөгжлийн индекст дурджээ. Тэгвэл бүх насаар хорих ялаар шийтгэгдсэн дундаж насны буюу 35-40 насны эрэгтэй ялтныг "Бүх насаар хорих ял"-аар шийтгэгдсэн гэж үзвэл дээрхи хуулийн хөнгөлөлт буюу ял эдлэх нөхцлийг хөнгөрүүлэх хугацааг шийтгэгдсэнээс 15 жил, нийгэмд гарах хугацааг ял эдлэх нөхцөл хөнгөрснөөс 5-10 жилээс илүүгүй хугацаагаар тогтоох нь оновчтой болно гэж үзэж байна. Гэхдээ энэхүү хуулийн заалтыг зан үйл, хандлага, төлөвшлөөрөө өөрийгөө бүрэн харуулж чадсан, нийгмийн

хор аюул нь арилсан ялтанд хэрэглэхээр тодотгож өгөх нь зүйтэй.

Үүнээс гадна "Бүх насаар хорих ял"-ыг эмэгтэйчүүд, насанд хүрээгүйчүүдэд оногдуулахгүй байх нь ардчилсан төрийн үнэт зүйл болох хүний эрхийг дээдлэх, хүнлэг ёсыг сахих зарчимд нийцэх юм.

Дээрхи судалгаа, дүгнэлттэй холбогдуулан "Бүх насаар хорих ял"-ыг хаалттай буюу эрхийн хязгаарлалт, хяналт-хамгаалалтын хувьд чангаруулсан нөхцөлд эдлүүлэх чиглэлээр дараахи саналыг оруулж байна:

1.Хорих өрөөний стандарт, хамгаалалтын техник хэрэгслийн байгууламжийг тусгайлан тогтоож өгөх;

2. Хорих өрөөнд ганцаарчлан хорих ба тодорхой хугацааны ялыг эдлэсний дараа ял эдлэх нөхцлийг хөнгөрүүлэх;

3. Эмнэлгийн бүхий л төрлийн тусламж үйлчилгээ болон бусад сэтгэл зүй, зан үйлийн арга хэмжээ, хууль зүйн туслалцаа зэргийг зөвхөн хорих байранд үзүүлэхээр зохицуулах;

4. Бүх насаар хорих ял эдлүүлэх байрыг төвлөрсөн халаалт, дулааны шугамд холбогдсон байхаар буюу төв суурин газар байгуулж, тэнд ажиллах албан хаагчдын нийгмийн асуудлыг хамтад нь шийдвэрлэхээр тооцох;

5. Хорих байрны байгууламжид удирдлагын байр, техникийн хяналтын болон шуурхай бүлгийн байр, уулзалтын өрөө, эмнэлгийн тусламжийн болон урьдчилан сэргийлэх өрөө, сэтгэл зүй, нийгмийн ажлын нөлөөллийн өрөө, угаалга ариутгалын цэг, хямралт байдлын үед ашиглах байр зэргийг иж бүрнээр багтаан байгуулах;

6. Хорих өрөөнөөс гаргах, оруулах бусад хоригдогчтой харьцах ажиллагааг тусгай хэрэгсэл, нэмэлт хамгаалалттай зохион байгуулах;

7. Бүх насаар хорих ял шийтгэгдсэн этгээд нас барсан тохиолдолд ар гэр хүсэлт гаргасан бол цогцсыг ар гэрт шилжүүлэх ба ар гэрээс хүсэлт гаргаагүй бол 5 хоногийн дараа хорих байрны захиргаа зардлыг гаргаж оршуулахаар зохицуулах;

8. Эрхийн бусад хязгаарлалтын хувьд:

• Ар гэртэй утсаар ярих нь 3 сард нэг удаа байхаар;

• Удаан хугацааны уулзалт олгогдохгүй, түр хугацааны уулзалт жилд нэг удаа;

• Жилд 2 удаа захидал, илгээмж хүлээж авах, явуулах;

• Шашны болон уламжлалт зан үйл, сэтгэл зүйн засал үйлчилгээнд тодорхой хуваарьтай хамрагдах;

• Хорих байранд зориулалтын цэгт, аюулгүй байдлын шаардлагад нийцсэн хөдөлмөр эрхлүүлэх;

• Нэрийн дансанд мөнгө байршуулах, хорих өрөөнд хувийн эд зүйл хэрэглэхийг хориглох;

• Салхилуулах, биеийн хөдөлгөөнт дасгал 7 хоногт 4-өөс доошгүй удаа хийлгэх;

• Ялаас хугацааны өмнө тэнсэн суллах журамд хамрагдахгүй байх;

• Хоригдогчид зориулсан аудио болон видео мэдээлэл түгээх хэрэгслийг хязгаарлалттайгаар ашиглах;

• Ном, сонин, сэтгүүлийг тодорхой хязгаарлалттайгаар ашиглах;

• Эрүүл ахуй, ариун цэврийн үзлэг үйлчилгээнд 7 хоногт нэг удаа хамрагдах зэргээр зохицуулж өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

Дээрхи нөхцөл журам болон эрхийн хязгаарлалтыг зохицуулсан ерөнхий заалтыг эрүүгийн хуулинд "Бүх насаар хорих ял шийтгэгдсэн этгээдийг хаалттай дэглэмд ял эдлүүлэх ба эрхийн хязгаарлалтыг тусгайлан тогтооно" гэж тусгаж өгөх боломжтой. Түүнчлэн бүх насаар ял эдлүүлэх байранд мөрдөх журмыг дээрхи бодлого чиглэлд нийцүүлэн Хууль зүй, дотоод хэргийн сайд УЕП-той зөвшилцөн батлаж мөрдүүлэх нь одоогийн баримталж буй хууль, тогтоомжид нийцнэ.

ХОРИГДОГЧ БИЕ ХҮН БА ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН НИЙГЭМШҮҮЛЭХ АЖИЛ



ШШГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газрын Сургалт, хүмүүжлийн хэлтсийн мэргэжилтэн, дэслэгч Г.Галсанжамц

Аливаа улс орны хөгжлийн бодлогын үндсэн чиглэл нь нийгмийн гол үнэт зүйл болсон хүний хөгжлийг дэмжсэн нөхцөлд эрэг үр дүн гардаг гэдгийг угсаатны зүй, сэтгэл судлал, социологийн шинжлэх ухаан болон хүний хөгжлийн зүй тогтлыг судалдаг эрдэмтэн судлаачид нэгэнт тогтоосон байна.

Хүний хөгжил рүү чиглэсэн үйл ажиллагааны нэг хэсэг нь нийгмийнхээ эмзэг бүлэгт тусалж, тэдгээрийг нийгэмд тодорхой байр суурьтай, үүрэг хариуцлагатай болгон хөгжүүлэх буюу зарим тодорхой бүлгийн хүмүүсийг нийгэмшүүлэх асуудал бөгөөд энэ ажлын зөв, оновчтой арга хэлбэрийг тогтоох, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, бусад зорилтот бүлэгтэй хамтран ажиллах нь өнөөгийн шаардлагад нийцсэн чухал алхам болох юм.

Монгол Улсын хорих байгууллага түүхэн хөгжлийнхөө явцад гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргийн улмаас хорих ял эдлэгсдийг сурган хүмүүжлүүлэх талаар тодорхой бодлогыг барьж, эрх зүйн баримт бичгийг гаргаж байсан юм. Тухайлбал, 1924 оны 8 дугаар сард хуралдсан МАХН-ын 3 дугаар их хурлаас "Гяндангийн дотоод байдлыг сайжруулах, хэрэгтэн ардуудыг гэгээрүүлэх тухай", 1924 оны 11 дүгээр сард хуралдсан Улсын анхдугаар их хурлаас ялтан хэрэгтнийг хорихдоо сурган хүмүүжүүлэх ажлыг чухалчлах хэрэгтэйг онцлон тэмдэглэж байсан бөгөөд 1931 оны "Монгол Ард улсын дотор аливаа хэрэгтэн, ялтныг засан сайжруулах ажлын тухай хууль", 1966 оны "Засан хүмүүжүүлэх хөдөлмөр хууль"-уудад хоригдогсдыг хөдөлмөрт сургах, мэргэжил эзэмшүүлэх зэргээр тэднийг нийгэмшүүлэх, сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж байжээ.

Түүнчлэн 1997 он хүртэлх хугацаанд Хорих байгууллагуудын Удирдах төв байгууллагын бүтцэд "Улс төр, хүмүүжлийн хэлтэс"-ийн зохион байгуулалттайгаар хорих ангиудад "Сурган хүмүүжүүлэгч" хэмээх ажилтан ажиллаж байсан бол 1997-2003 онд хоригдолтой холбогдсон бүхий л эрх зүйн харилцааг зохицуулж, тэдний эрх ашгийг хамгаалах, амьдрах, ажиллах орчинг чөлөөт амьдралын хэв маягт аль болохоор ойртуулах, иргэншүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй "Ахуй дэглэмийн байцаагч" гэсэн нэршилтэй ажлыг байрыг бий болгон ажиллуулж байжээ.

Харин 2003 оноос эхлэн хоригдогсдыг нийгэмшүүлэх, тэдгээрт тулгарсан бэрхшээлийг даван туулахад туслах чиг үүрэг бүхий "Нийгмийн ажилтан"-ны орон тоог баталж байсан бол хорих ялын төрөл дэглэм, хоригдогсдын сэтгэл зүйн онцлогийг харгалзан төрөлжүүлэн судлах зорилгоор 2006 оноос эхлэн сэтгэл зүйчийн орон тоог бий болгон, анх Цагдан хорих 461, хорих 405, насанд хүрээгүйчүүдийн хорих 411 дүгээр ангиудад мэргэжлийн сэтгэл зүйч ажиллаж эхэлсэн юм.

Хоригдогсдын давуу тал буюу дотоод нөөц боломжийг илрүүлэх, бие даан амьдрах чадварт сургахад хорих байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн үүрэг ихээхэн чухал юм. Энэхүү хариуцлагатай үүргээ хэрэгжүүлэхийн тулд хүний хөгжилд нөлөөлөгч хүчин зүйлс, хөгжлийн шалгуур үзүүлэлт, хөгжил төлөвшилт, эвдэрч гажих шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх, хөгжлийн боломж зэргийг олон талаас нь нарийвчлан судлах шаардлага тавигдаж байна.

Өөрөөр хэлбэл цагдан хоригдож буй сэжигтэн яллагдагч болон хорих ял эдэлж буй хоригдогсдыг нийгэмшүүлэх асуудал нь шинжлэх ухааны үндэстэй, нийгэм-сэтгэл зүйн судалгаанд тулгуурласан, гэмт хэргийн шалтгаан нөхцөл болон бусад нөлөөлөгч хүчин зүйлсээс хамаарсан байдалтайгаар ялгамжтай хэлбэрээр зохион байгуулах нь зүйн хэрэг юм.

Нийгэм судлал болон сэтгэл судлалын ухаанд нийгмийн дотор оршин амьдарч, нийгмийн материаллаг үйлдвэрлэлийн харилцаанд идэвхтэй оролцогч хүнийг "бие хүн" гэж тодорхойлж байгаа бөгөөд бие хүний зан үйлийг урьдчилан тодорхойлохын тулд сэтгэл зүйчид бие хүний иж бүрэн, суурь онцлог шинжүүдийг судлан тодорхойлж хэмжихийг эрмэлзсээр ирсэн түүхтэй. Бие хүн нь нийгмийн харилцааны бүтээгдэхүүн болохын хирээр бие бялдар, оюун санааны хувьд хөгжиж, өөрийн гэсэн төлөвшил, үзэл бодол, зан төлөв, хувийн онцлогтой болж байдаг. Тиймээс "бие хүн" хэмээх ерөнхий ойлголтоос гэмт хэрэгтэн бие хүний онцлогийг тодорхойлох хэрэгтэй.

Гэмт хэрэгтэн бие хүн гэдэг нь нэг талаас "бие хүн" гэсэн социологийн, нөгөө талаас "гэмт хэрэгтэн" гэсэн хууль зүйн ойлголтын нэгдэл юм. Өөрөөр хэлбэл хүн гэмт хэрэг үйлдсэн ч бие хүний шинжээ алддаггүй, харин хэв шинж нь өөрчлөгдөх явдал анзаарагддаг байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Тогтоол гүйцэтгэх газрын Сургалт, хүмүүжлийн хэлтсээс 2011 онд явуулсан дараах судалгааг авч үзье.

2011 оны 11 дүгээр сарын байдлаар хорих ял эдэлж буй 6422 хоригдогч ял эдэлж байгаа бөгөөд давтан гэмт хэрэг үйлдсэн ялтнуудаас авсан судалгаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 22 хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийт 2443 ялтан хамрагдсан ба үүнийг нийт хорих ял эдэлж байгаа ялтны тоотой харьцуулахад 38 хувийг эзэлж байгаа бөгөөд үүнээс эрэгтэй 2376, эмэгтэй 67 нь ялтан байна.

График 1



График 2



Давтан гэмт хэрэг үйлдсэн шалтгааныг авч үзвэл:
График 3



Дээрх байдлаас дүгнэн үзэхэд давтан гэмт хэрэг үйлдэгсдийн тоо буурахгүй байгаа бөгөөд давтан гэмт хэрэг үйлдэх шалтгаан нь нийгэм, орчны нөлөөтэй холбоотой байгаа нь харагдаж байна.

Үүнээс үзэхэд гэмт хэрэг үйлдэхэд гадаад /нийгмийн орчин/, дотоод /генетикийн/ шинжтэй бие хүний сэтгэл зүйн өвөрмөц онцлог/ хүчин зүйл нөлөөлдөг нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл нийгмийн орчин ба сэтгэл зүйн нэгдэл, тэдгээрийн харилцан үйлчлэлд энэ асуудлыг авч үзэх хэрэгтэй юм.

Гэмт хэрэгтэн бие хүний хөгжил болон зан үйлийн хандлагыг тайлбарлах хэд хэдэн онолын жишээг авч үзье.

Гэмт хэрэгтнийг зан үйлийн хандлага буюу бихевиорист сэтгэл судлалын үүднээс судлан дараах тайлбарыг хийж болно. Энэ хандлага нь зан үйл болон түүний хариу үйлдлийн орчноос хамаарах хамаарлын судалгааг чухалчилдаг.

Гэмт зан үйлийг хүн нийгмээс буюу гадаад орчноос суралцдаг. Хүн өөрийн мөн чанарын хувьд сайн, муу байдаггүй бөгөөд гаднаас үзүүлж буй цочролд хариу үйлдэл үзүүлж байдаг. Өөрөөр хэлбэл хэнийг ч юунд ч орчны нөлөөллөөр сургаж болох ба гадны нөлөөллөөр удирдаж болно.

Ямар нэг гэмт үйлдэл хийснийхээ төлөө шийтгүүлээгүй бол, гэмт үйлдлээрээ өөрийн хэрэгцээг хангаж, түүнээсээ урам авбал түүнийг дахин давтан хийх магадлал өндөр байдаг бөгөөд энэ давталт нь хүнд гэмт зан үйлийг төлөвшүүлдэг. Хүмүүсийн сөрөг хандлага бодлоос үүдэлтэй зан үйл нь тэднийг нөхцөл байдлыг бодитойгоор харж ойлгоход саад болдог бөгөөд хүмүүсийн итгэл үнэмшил, бодол санаа, өөрийн тухай яриа нь бодит биш үймсэн, бодол санаа нь сөрөг, бие махбодь дахь физиологийн, мэдрэлийн өөрчлөлтөөс үүдэлтэй сэтгэл хөдлөлийн тогтворгүй байдал нь тэдний зан үйлийг хэвийн биш болгодог.

Мөн хэвийн биш үйлдлийг "хэвийн" гэж ойлгож үйлдэл хийдэг нь нийгмийн болон бусдын эсрэг зан үйл гаргахад нөлөөлдөг гэж үздэг.

Бихевиористуудын тайлбараар хүний зан үйл нь юуг урамшил, юуг шийтгэл гэдгийг ойлгож байгаагаас хамаардаг бөгөөд хүнийг туршлагажуулж, зан үйлийг төлөвшүүлж байдаг орчин нөхцлийг сайн судлах ёстой гэж тайлбарласан байдаг.

З.Фрейд, Э.Эриксон, А.Адлер нарын үзлээр бие хүний хөгжил насанд туршид нь явагддаг гэж үздэг бөгөөд бага насны хөгжил хүний зан үйлийн хожмын илрэлд шийдвэрлэх үүрэгтэй байдаг байна.

Сэтгэц задлалын буюу психоанализ хандлага нь хүний бага насан дахь амьдралынх нь онцлог, биологийн зөн билэг ба нийгмийн шаардлага хоорондын зөрчлийн улмаас

төрөл бүрийн эмгэг шинжүүд бий болдог гэж үздэг.

Хувь хүний сэтгэлийн шарх түүний бага насанд учирсан хямрал, зөрчлөөс эхлэлтэй. Багадаа үл хайхрал, гадуурхал, ахадсан шаардлага, хүсэлт зэргийг мэдэрдэг байсан бол түүний сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж невроз үүсгэх шалтгаан болдог.

Хүн орчинтойгоо харилцах явцад дутуугийн мэдрэмж болон давуу байдалд тэмүүлэх тэмүүлэл илэрдэг бөгөөд эдгээр нь нийгэмд ашигтай үйл ажиллагааны хөдөлгөгч хүч нь болдог. Нийгэмдээ дасан зохицож байгаа бодол нь дутуугийн болон давуугийн комплексоор илрэн гарч байдаг.

Психоанализ нь хүмүүсийн бодол санаа, мэдрэмж, үйлдэлд нөлөөлж байдаг биологийн зөн билгүүд, ялангуяа бэлгийн болон түрэмгийллийн зөн билэгт онцгой ач холбогдол өгдөг. Зөн билэг нь оюун ухааны ухамсаргүй гүнд дарагдсан байх бөгөөд нийгмийн шаардлагуудтай үргэлж зөрчилдөж байдаг. Өөрөөр хэлбэл З.Фрейдийн "Бие хүний бүтэц"-ийн онол дахь анхаарал татсан нэг санаа нь соёл, ухамсаргүй үйлдэл хоёрын харьцааны асуудал бөгөөд хүнийг чөлөөтэй, дурараа байлгахад чиглэгддэг. Гэтэл соёл нь /биеэ авч явах хэм хэмжээ/ хүнийг нийгэм, хамт олны дунд тогтчихсон зүйлийг харгалзах, түүний дагуу байхыг шаарддаг учраас энэ хоёр байнга зөрчилддөг төдийгүй үүний улмаас зарим төрлийн гэмт хэрэг үйлдэгддэг гэж тайлбарлаж болох юм.

Социобиологийн хандлага нь хүний нийгмийн зан үйлийг биологитой холбон тайлбарладаг. Хүний зан үйлийн нарийн нийлмэл хэлбэрүүд, тухайлбал, альтруизм, түрэмгийлэл, нийгэмшил нь бидний "ген"-д байгаа гэж үздэг.

Өөрөөр хэлбэл дээр дурьдсан зарим онолын тайлбарын дагуу болон шинжлэх ухааны судалгааны бусад аргачлалаар гэмт зан үйлийн дотоод мөн чанарыг судалснаар гэмт хэрэгтэн буюу гэмт хэрэг үйлдсэний улмаас ял эдэлж буй хоригдогсдын сэтгэл зүйн хувийн онцлог, өвөрмөц шинж чанарыг ойлгох мэдэх боломжтой юм.

Тиймээс хорих байгууллагын сэтгэл судлал нь хоригдогч бие хүнийг судлахдаа илүү өргөн хүрээг хамарч тухайн хоригдогчийн сэтгэц, ёс суртахууны төлөв байдал, шинж, сэтгэцийн тусгалын хэлбэр, темперамент, зан төлөвийн онцлогийг судлах төдийгүй сэтгэл гутрал, түгшүүр, дасан зохицох чадварын судалгааг цогц байдлаар явуулна.

Гэмт хэрэг бол нийгэмд дутуу боловсрогдсон зан үйлийн хэлбэр гэж зарим судлаачид тодорхойлдог бөгөөд хоригдогсдыг нийгэмшүүлэх ажил хорих ялын нэг зорилго төдийгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ юм. Өөрөөр хэлбэл хоригдогсдод нийгмийн эерэг агуулга бүхий бие хүний өөр шинжийг төлөвшүүлэх, тэдний зан үйлд нөлөөлөх, нийгмийн үүрэг хариуцлагыг ухамрсарлуулах явдал нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны томоохон чиглэл болон хэрэгжиж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар нь хорих байгууллагын нийгэм, сэтгэл зүйн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр олон арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа бөгөөд тухайлбал хоригдогсдыг нийгэмшүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэх, тэдэнд мэргэжлийн чиг баримжаа олгох, төрөлжүүлсэн сургалтанд хамруулах, суллагдсан иргэдийг ажлын байраар хангах, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, хоригдогсдыг нийгэмшүүлэх ажлын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хорих анги, шийдвэр гүйцэтгэх албанд ажиллах нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн орон тоог шинээр бий болгох, тэдгээрийг мэргэшүүлэх, чадваржуулах чиглэгдсэн арга хэмжээ зэрэг ажлуудыг дурьдаж болох юм.

Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажилд бодит ахиц, өөрчлөлт гарч байгаа нь нэг талаас одоо барьж буй бодлого, чиглэл зөв үр дүнтэй байгааг харуулсан, нөгөө талаас хийгдэж буй алхмууд нь хорих байгууллагын нийгмийн ажил, сэтгэл судлалын ухааныг

онолын болон хэрэглээний түвшинд хөгжүүлэхэд чухал нөлөөтэй болсон гэж дүгнэж болохоор байна.

Цаашид хорих байгууллагын нийгэм, сэтгэл зүйн мэргэжлийн үйл ажиллагааг тогтмолжуулах зорилгоор:

- Хоригдогсдод үзүүлэх нийгэм, сэтгэл зүйн мэргэжлийн үйл ажиллагаанд шаардагдах орчин бүрдүүлэх буюу үйлчилгээний өрөө, тасалгааг дэлхийн жишигт хүргэх,
- Хоригдогсдыг нийгэмшүүлэх, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны талаар дэлхийн бусад орны туршлагыг судлах, өөрсдийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, гадаад харилцааг хөгжүүлэх,
- Хорих байгууллага дахь нийгэм, сэтгэл зүйн мэргэжлийн үйл ажиллагааны явц, ололт, амжилтыг судлах судалгааны ажлын тогтолцоог бий болгох, /судалгааны бие даасан нэгж/
- Хорих байгууллагын нийгэмшүүлэх ажилд төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагыг татан оролцуулах механизм бий болгох зэрэг ажлуудыг өнөөгийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлан өргөн цар хүрээтэйгээр зохион байгуулах шаардлагатай байна.

Төгсгөлд нь нэгэн жишээ дурдья.

Германы судалдаг Японы эрдэмтэн Берлин хотод 20 жилийн өмнө зүүн Туркээс цагаачлан ирсэн нэгэн эмэгтэйгээс ярилцлага авчээ. Түүнтэй Туркээс багадаа ирсэн нийгмийн ажилтан эмэгтэйгээр зуучлуулан танилцсан байна. Ярилцлага авч дууссаны дараа яриа өгсөн эмэгтэй: "Чи нийгмийн ажил хийдэг үү?" хэмээн асуужээ. Энэ асуулт судлаачийн хувьд хариулахад эргэлзээтэй, төвөгтэй асуулт байсан байна. Энэ нь "Чи нийгмийн ажилтан уу?" гэсэн үг биш, харин "Чиний ажил нийгэмд хамаатай, нийгмийн ажил уу?" гэсэн агуулгатай гэдгийг тэрээр ойлгож байжээ. Тиймээс өөрийгөө эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийдэг гэж үзсэн тул "Үгүй" хэмээн хариулахад нөгөө эмэгтэй: "Тэгвэл яах гэж хийж байгаа юм бэ?" гэсэн байна. Энэ түүхийг дурдаад хорих байгууллагын нийгэмшүүлэх ажил нь нийгмийн хөгжлийг бодитоор дэмжих "нийгмийн ажил" гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлье.

Та бүхнийг хорих байгууллагын нийгэм, сэтгэл зүйн ажлын чиглэлээр хамтран ажиллахыг хүсвэл бидэнтэй холбоо барихыг урьж байна.

НЭЭЛТТЭЙ, ХААЛТТАЙ ТОГТОЛЦООНД ХОРИХ АНГИЙН ТӨРӨЛ, ДЭГЛЭМИЙГ ШИЛЖҮҮЛЭХ БУСАД УЛС ОРНЫ ТУРШЛАГА



ДХИС-ийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Оюунболд

Дэлхийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагын хувьд Монгол Улс хорих ялын эрх зүйн хөгжлийн хувьд харьцангуй бага түүхтэй бөгөөд Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн гарах үед үйлчилж байсан Хууль зүйлийн бичиг, Жинхэнэ дагаж явах дүрмийн дараагаар 1926 онд батлагдсан Эрүүгийн хуульд хорих ялын эрх зүйн үндсийг анх удаа дуусгаж өгснөөс хойш 90 гаран жил өнгөрч байна. Ардчилсан нийгмийн хөгжлийн чиг баримжаатай холбоотойгоор эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Монгол Улсын Их Хурал 2002 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн баталсан билээ. Энэ хуулийг хэрэгжээд 10 жил өнгөрч байгаа бөгөөд энэ хугацаанд зохицуулж байсан нийгмийн харилцаанд ихээхэн өөрчлөлт гарснаар хөгжлийн шаардлагад нийцүүлэн дээрх хуулиудад зарим өөрчлөлт хийх шаардлагатай болов.

Хорих ялын онцлог

Хорих ял гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдвол шүүх Эрүүгийн хуульд заасан хугацаанд эрх чөлөөг нь хязгаарлаж, олон нийтээс тусгаарлаж, тусгай дэглэм бүхий хорих анги, гянданд албадан байлгадаг төрийн албадлагын хатуу цээрлэл агуулсан арга хэмжээ юм. Хорих ялыг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхэд гэхчлэн нас, хүйсийн байдлыг харгалзан тус тусад нь эдлүүлэхээс гадна ялтанд үзүүлэх эрхийн хязгаарлалтын хэр хэмжээгээр өөр хоорондоо ялгарах дэглэмтэй хорих анги болон гянданд эдлүүлдэг. Энэ нь хүнд, онц хүнд гэмт хэрэгтнээс хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг, онц аюултай болон рецедив гэмт хэрэгтнүүдээс анх удаа гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг тусгаарлан ялыг эдлүүлэх зорилготой байдаг.

Эрх зүйн орчин

Монгол Улсад гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон хүнд хорих ял эдлүүлэхдээ Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.4-т "Хорих ялыг жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги болон гянданд эдлүүлнэ.", Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 107 дугаар зүйл "Баривчлах байр, жирийн дэглэмтэй хорих анги", 108 дугаар зүйл "Чанга, онцгой дэглэмтэй хорих анги", 109 дүгээр зүйл "Гяндан" гэсэн зүйл, хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу хорих ялыг эдлүүлж байна.

Монгол Улсад хорих ял эдлүүлж байгаа байдал

Монгол Улсад сүүлийн 10 жилийн дунджаар жилд 7272 хүн хорих ял эдэлдэг. Практик алба хаагчдийн хийсэн судалгааны дүнгээс үзэхэд жилдээ хорих байгууллагаар дамжиж байгаа хүмүүсийн тоо 8000 байдаг.

Баривчлах ял

Эрүүгийн хуулийн 51 дүгээр зүйлд баривчлах ялыг "гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлан тодорхой дэглэм бүхий байранд ганцаарчлан байлгах замаар сэтгэл зүйн нөлөөлөл үзүүлэх" хэлбэрээр эдлүүлэхээр заажээ. Гэвч баривчлах ял шийтгүүлсэн этгээдийг жирийн дэглэмтэй хорих ангид олноор нь хорих, эсхүл бусад хоригдлын нэгэн адил ажил хөдөлмөр эрхлүүлэх зэргээр хуульд заасан ял эдлүүлэх нөхцөл, журмыг зөрчиж, хүний эрхийг хохироох явдал маш түгээмэл байна. Ийнхүү хорих, баривчлах ялыг ялгамжгүйгээр эдлүүлснээр Эрүүгийн хуульд заасан ялын зорилго биелэгдэхгүйд хүрч байна.

Баривчлах ялыг хуульд заасан зорилго, шаардлагын дагуу эдлүүлэх нөхцөл, боломжийг төр бий болгох, ийнхүү бий болгож чадахгүй гэж үзвэл түүнийг ял шийтгэлийн төрлөөс бүрмөсөн хасахаас өөр аргагүй юм. Уг ялыг "ганцаарчлан" эдлүүлэх нөхцөл, шаардлагыг бий болгож чадвал уг ял нь хорих ялын альтернативд нилээд үр нөлөөтэй байх боломжтой юм.

Өнөөгийн байдлаар насанд хүрээгүй хүн нь Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар батлагдсан "Хорих ангийн дотоод журам"-аар заасан эрх зүйн орчинд насанд хүрэгчидтэй нэгэн адил нөхцөлд цагдан хоригдож, хорих ял эдэлж байна. Цаашид насанд хүрээгүй /хүүхдэд/ хүмүүсийн хорих ангийн дотоод журмыг тусгайлан гаргаж, мөрдөн ажиллах хэрэгтэй.

Гадаадын зарим орны хорих ангийн нээлттэй төрөл, дэглэм

Гадаадын эрдэмтэн, судлаачдын бичсэнийг үзвэл зарим орны хорих ангийн төрөл, дэглэм нь пенологийн хөгжлийн үе шатуудад тухай бүр зохицсон байдлаар хөгжиж, төлөвшиж ирсэн байна. Хуучин ЗСБНХУ задран бутрах үед "ГУЛАГ" -ийн тогтолцоог хуулбарлан хэрэглэж байсан "посткоммунист" гэсэн тодотголтой Эстони, Латви, Польш, Чех, Унгар гэх мэт орнууд Европын холбоонд нэгдэн орохын тулд эрүүгийн болон шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн системдээ цоо шинэ өөрчлөлт хийж, хүний эрхийг баталгаажуулсан стандартыг хүлээн зөвшөөрч, тодорхой үр дүнд хүрч байна.

Монгол Улс нийгэм эдийн засгийн салбарт хийж буй зарим шинэчлэл, өөрчлөлтийг Евростандартад нийцүүлэх зорилтын хүрээнд эдгээр улсын сайн туршлагыг зээлдэн авах, өөрийн хөрсөнд буулгах зэргээр бодитой ажлыг цаг алдалгүй хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Судалж үзсэн гадаадын улсуудад :

- Эрүүгийн хууль тогтоомжоо шинэчлэх
- Хорих ял эдлүүлэх байгууллагын тухай хууль тогтоомжид өөрчлөлт хийх
- Тусгайлсан хууль гаргах /Prison Act эсвэл Prison code/
- Эрүүгийн хууль тогтоомжийн хорих ялын хэсэгт нэмэлт, өөрчлөлт хийж хоригдлыг нээлттэй, хаалттай дэглэмд ял эдлүүлэх, ажил хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай бодлогын баримт бичиг гаргах
- Хүний нөөцийг шинэ нөхцөлд ажиллах бэлтгэлийг хангах зэрэг цогц арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

ХБНГУ

ХБНГУ-ын эрүүгийн хууль тогтоомж нь олон хууль /Эрүүгийн хууль, Ялын тухай хууль, Шоронгийн тухай хууль зэрэг/ -иас бүрддэг. Ялтныг нийгмийн өмнө хариуцлага хүлээхүйц, нийгэмшүүлэх, засан хүмүүжүүлэх, түүнийг нээлттэй, хаалттай төрөл дэглэмд ялгамжтай эдлүүлэх зорилгыг Ялын тухай хууль /1975 он/, 1977 онд батлагдсан "Шоронгийн тухай" /Prison Act/ хууль тус тус агуулсан байдаг. ХБНГУ-ын Шоронгийн тухай хуулийн зорилго нь хорих ялын нээлттэй хэлбэр ялтныг хэвийн амьдралд эргүүлэн оруулах, хуульд захирагдах, өөрийн үйлдлийн аливаа хариуцлагыг хүлээх, хэвийн ажиллаж амьдрахыг хангаж хариуцахад сургадаг. Энэ зорилгын үндсэн ачааллыг хорих байгууллагын нийгмийн алба үүрдэг.

Тус улсад харьцангуй хөнгөн гэмт хэрэг үйлдсэн цөөн жилийн хорих ялтай ялтнуудыг нийгэмд дасгах, хөндийрүүлэхгүй байх зорилгоор суллагдахаас нь өмнө "нээлттэй" ангид байлгадаг.

Хорих ангийн нээлттэй хэлбэр нь

- гэртээ харихад бэлтгэх /furlough und Hafturlaub/,
- богино хугацааны хорих хэлбэр /Ausgang/,

- ажил хөдөлмөр эрхлэх дэглэм /Freigang/ гэсэн гурван ялгаатай дэлгэмтэй. Гэртээ харихад бэлтгэх дэглэм нь хуанлийн 21 өдрийн өмнөөс, богино хугацааны хорих хэлбэр нь хорих байгууллагаас гадуур өдөрт хэдэн цаг ажил эрхлэх боломж олгодог, харин ажил хөдөлмөр эрхлэх дэглэм нь хорих ангийн хяналтаас гадуур хөдөлмөр эрхлүүлдэг /сард 500 дойч марк/. Энэ хэлбэр нилээд түгээмэл бөгөөд Германы нийт хорих ангийн 60 хувь нь ийм нөхцөлтэй байна.

1980-аад онд Германы Хууль зүйн яамны дэргэд "Нийгмийн туслалцааны хүрээлэн" байгуулагдсан ба тэнд хөдөлмөрийн зах зээлийг судалж, гол компани, бусад аж ахуйн нэгж болон шаардлагатай бусад байгууллагатай холбоотой ажиллаж, суллагдаж буй хүмүүст гэр бүлийн болон санхүүгийн бэрхшээлээ гэтлэхэд нь туслахуйц зөвлөгөө өгдөг байна..

Хорих байгууллагын захиргаа, нийгмийн ажилтнууд хөдөлмөрийн биржтэй нягт харилцан ажиллаж, аж ахуйн аль чиглэлийн байгууллага өргөжин тэлж байгааг харгалзан тэнд ажиллах мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр сургалтын материаллаг баазыг бүрдүүлж байдаг.

Ялтны хорих ял эдлүүлэх ажиллагааг хэд хэдэн үе шатанд хуваадаг,

- Хорих байгууллагын нөхцөлд дасах үе
- Засран хүмүүжих үе
- Суллагдахад бэлтгэх үе

Хорих ял эдлэх бүхий үе шатанд нийгмийн ажилтан тэднийг судалж, хувийн хэрэгт нь төлөвлөгөөний дагуу дүгнэлт бичиж байдаг. Энэхүү төлөвлөгөөнд:

1. Хаалттай болон нээлттэй хорихын аль нөхцөлд байх
2. Ижил харьцаа бүхий хэсэгт бусадтай хамт байж болох эсэх
3. Ажил хийх, мэргэжил эзэмших, мэргэших болон давтан сургалтад хамруулах
4. Мэдлэгээ дээшлүүлэх
5. Тусгайлсан тусламж үзүүлэх
6. Ял эдлэх нөхцөлийг хөнгөрүүлэх
7. Суллагдахын өмнө ажил гүйцэтгэх гэсэн хэлбэртэй байна.

Чөлөөт амьдралд оруулахын тулд хорих ялын дэглэмийг бууруулж болох ба суллагдахаас 3 сарын өмнө 7 хоногийн чөлөө олгох, мөн хорих байгууллагаас гадуур чөлөөтэй явах эрхтэй ялтанд сар бүр 6 хоногийн чөлөө олгодог. Энэ нь дээр дурдсан 3 төрөл дэглэмийн онцлогт тохирсон байна.

ХБНГУ-ын хорих ангийн нээлттэй төрөл, дэглэмийг үзвэл тус улсын Эрүүгийн хуулиас гадна "Ял шийтгэлийн тухай хууль" /Penal Code/, "Шоронгийн тухай хууль" / Prison Act/ гэх мэт салбар хуулиуд үйлчилдэг, хорих нээлттэй хэлбэрүүд болох Гэрт нь харихад бэлтгэх хэлбэр/furlough-Hafturlaub/, богино хугацааны хорих хэлбэр /Ausgang/ зэрэг нь Монгол Улсын Эрүүгийн баривчлах, албадан ажил хийлгэх ялтай хуульчилсан хэлбэрийн хувьд төстэй мэт боловч тухайн улсын ялын тогтолцооны онцлогтой бүрэн нийцсэн, зарчим, зорилгын хувьд эрс ялгаатай байна.

Эстони Улс:

Постсоциалист орон гэгдэх энэ улс Европын холбоонд амжилттай нэгдэн орохын тулд 1994 онд Эрүүгийн хууль /Criminal code/ болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх /Code of Enforcement procedure/ тухай хуульдаа зарчмын шинжтэй өөрчлөлт хийжээ. Ингэснээр өмнө байсан "ГУЛАГ"-ийн хорих лагераас бүрэн татгалзаж хорих ялын төрөл, дэглэмийг:

- Closed prison
- Semi- closed prison
- Open prison гэж ангилсан байна.

Тус улс хорих ангийн нээлттэй хэлбэрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай

хуулийн 98, 119-124 дүгээр зүйлд заахдаа ажил хөдөлмөр эрхлэх боломжтой байх, гэр бүлийнхэнтэйгээ уулзаж, өөрт тохирсон хөдөлмөр эрхлэх талаар оруулсан байна. Тус улс 1996-1997 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон хорих байгууллагадаа томоохон өөрчлөлт, шинэчлэл хийж улмаар 2000 онд Шоронгийн тухай хууль /Prison Code/ -ийг батлан гаргажээ. Энэ хуулийг батлан гаргахдаа Герман, Франц улсын холбогдох хуулиудын зарим хэсгийг судлаж үзсэний үндсэн дээр "зээлдэн" авч хэрэглэсэн байна.

Финланд Улс

Финландын хорих байгууллага онцгой, жирийн, нээлттэй гэсэн гурван төрлийн дэглэмд хуваагддаг. Онцгой дэглэмд ял эдэлж байгаа ялтныг нийгмээс тусгаарлаж манай улсын чанга дэглэмтэй төстэй нөхцөлд байлгадаг байна. Жирийн дэглэмд ял эдэлж байгаа хоригдлууд хоорондоо уулзаж болох ба хянагчийн харгалзаатайгаар гадуур явж болдог.

Нээлттэй хорих ангид оргох зугтахаас сэргийлсэн хашаа тор байхгүй бөгөөд ялтан өрөөнийхөө түлхүүрийг эзэмшиж дотор чөлөөтэй явах, мөн энгийн хувцас өмсдөг. Зарим тохиолдолд хорих ялыг 8 сар хүртэл албадан ажил хийлгэхээр сольж болдог. 20-200 цагийн албадан ажил хийхдээ 7 хоногт 2 удаа 3-4 цаг ажилладаг. Энэ ялаар сольсон нөхцөлд ажил сургуулиасаа хөндийрөлгүй, гэр бүлийнхэнтэйгээ амьдарч гүйцэтгэдэг байна.

Финландын Ялын тухай /Penal Code/ хуулиар ялтныг аль болох ердийн аж амьдралын нөхцөлд ойр байлгах, "хоригдоно" гэдэг нь мөн чанартаа хүнд шийтгэл тул түүнийг янз бүрийн нэмэлт арга, хэрэгслээр хүндрүүлэхгүй байх, улмаар ямар нэг анкет баримт бичигт ял эдэлж байсныг дурдахгүй байхаар тус тус заасан байдаг.

Их Британи

Хорих байгууллага нь Их Британийн Дотоод хэргийн яаманд байх бөгөөд дараах хэлбэртэй байна.

- 3-аас дээш жилтэй ялтнуудын нэгдсэн хорих анги
- 12 сараас дээш ял эдлэх анх удаа ял шийтгүүлсэн ялтнуудын хорих анги
- 21 -ээс дээш насны гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийн хорих анги
- Анх удаа гэмт хэрэг үйлдсэн ялтнуудын хорих анги
- 21 хүртэл насны хүмүүст зориулагдсан хорих анги
- Насанд хүрээгүйчүүдийн богино хугацаагаар засан хүмүүжүүлэх төвүүд байдаг

Ялтны ял эдлэх хугацааг дараах байдлаар ангилдаг. Үүнд

1. Туршилтын хугацаа /ганцааранг нь байлгах/
2. Засан хүмүүжүүлэх үе /хамтаар байлгаж, хөдөлмөрт татан оролцуулах/
3. Хугацаанаас өмнө тэнсэн суллах /ялын 4/3-ийг эдэлсэний дараа/

Засан хүмүүжүүлэх болон суллахын өмнө байршлын завсар шилжилтийн үе гэж болох "хагас чөлөөтэй үе" байдаг бөгөөд энэ үед хянагчгүйгээр ажилд гарч, гадна орчинтой чөлөөтэй харьцдаг энэ хэлбэр өөр олон улсад түгээмээл тархсан байдаг нь нийгмийн амьдралд амжилттай дасахад чухал ач холбогдолтой.

АНУ

АНУ-ын шийдвэр гүйцэтгэх байгууллага нэг талаас Хууль зүйн яам, нөгөө талаас оршин байгаа нутаг дэвсгэрийн засаг захиргаанд давхар харъяалагддаг. Хорих ялыг :

- Холбооны
- Мужийн
- Орон нутгийн ял эдлүүлэх байгууллагад эдлүүлдэг байна.

Орчин цагийн АНУ-ын ял эдлүүлэх байгуулагын бүтцэд "Оборн систем" голлох байр суурь эзэлдэг ажээ. АНУ-ын хорих ангиудад хатуу тогтоосон болон уян хатан тогтоосон дэглэм журам аль аль нь үйлчилдэг байна.

АНУ-д хорих ангийг дараах гурван төрөлд ангилдаг:

1. Дээд зэргийн хяналтын түвшинтэй хаалттай хорих

2. Хамгаалалтын дунд түвшний хорих, энэ нь ялтан номын санд очих, салхинд гарах боломжтой

3. Хялбаршуулсан түвшний хорих буюу "нээлттэй хорих"

Нээлттэй хорих анги нь зэвсэглэсэн хамгаалалтгүй, хөнгөн дэглэмтэй, хоригдогсод нь гадны байгууллагад хөдөлмөр эрхлэх эрх эдэлдэг байна. Нээлттэй дэглэмд хорих ял эдлэгсдийн эрхэлдэг хөдөлмөрийн гол чиглэл нь барилга байгууламж барих, зам засах, хөдөө аж ахуйн болон бусад ажил байдаг.

Түүнчлэн насанд хүрээгүйчүүдийн хорих ялыг хүмүүжлийн сургуульд эдлүүлдэг, дэглэм, харуул хамгаалалтын нөхцөл насанд хүрэгчдийнхтэй жишихэд харьцангуй зөөлөн байдаг. Насанд хүрээгүй хоригдлууд өдөрт нь хорих ангийн байрлалд байрлан ажиллаж, сурах бөгөөд шөнө нь гэртээ очиж хонож болдог. Энэ нь хоригдлуудын хүмүүжилд нааштай нөлөө үзүүлдэг ажээ.

АНУ-д сүүлийн үед эрх чөлөөг нь хэсэгчлэн хязгаарлах, тухайлбал хорих байгууллагаас гадуур байж сурч, ажиллахаа хэвийн үргэлжлүүлэх шийтгэлийн хэлбэр нилээд түгээмэл болж байна.

Япон Улс

Япон улс нь "Суллагдагсдад тусламж үзүүлэх тухай", "Насанд хүрээгүй ялтны ялыг эдлүүлэх байгууллагын тухай", "Шоронгийн тухай хууль" болон бусад эрх зүйн актуудаар энэхүү харилцааг зохицуулдаг байна.

Япон улсын эрүүгийн ял нь

1. Бага хэмжээний торгууль
2. Торгууль
3. Баривчлах
4. Албадан болон албадан хөдөлмөрлүүлэхгүйгээр хорих
5. Цаазаар авах гэсэн төрлүүдтэй.

Ял эдлүүлэх байгууллагын бүтцэд урьдчилан хорих байр, насанд хүрэгчдийн болон насанд хүрээгүйчүүдийн хорих байгууллага багтана. Японы ял эдлүүлэх байгууллага нь нилээд төвлөрсөн боловч нарийвчилсан ангилалтай байдаг

Хорих ял шийтгэгдсэн ялтныг :

- Хөнгөн гэмт хэрэг үйлдсэн
- Гадаадын иргэн
- 8 аас дээш жилийн хорих ялтай
- 20 хүртэлх насны залуучууд
- Эрүүл мэндийн байдал сул, өвчтэй хүмүүс гэдгээр тус тус ангилдаг.

Хорих ангийн нээлттэй системийг бага хэмжээгээр хэрэгжүүлж эхэлж байгаа боловч хоригдлыг хүмүүжүүлэх үндсэн арга хэрэгсэл нь биеийн хүчний хөдөлмөр гэж үздэг. Хоригдлууд нь өдөрт 8, долоо хоногт 44 цаг ажилладаг байна.

ОХУ

1996 онд батлагдан гарсан Эрүүгийн ял эдлүүлэх хууль нь 24 бүлэг, 190 зүйлээс бүрдэнэ. ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хууль нь Монгол Улсын ШШГТХ-тай зарчмын хувьд олон зүйлээр ялгаатай.

- Хоригдлын ялыг нийгмээс тусгаарлахгүйгээр эдлүүлэх байдал
- Баривчлах ял эдлүүлэх
- Хорих ял эдлүүлэх

Хоригдлыг хүмүүжүүлэх үндсэн хэрэгсэлд:

- Ял эдлүүлэхэд мөрдөх тогтоосон дэглэм, журам
- Нийгмийн ашиг тустай хөдөлмөр

• Ерөнхий боловсорлын болон мэргэжил эзэмшүүлэх сургалт, олон нийтийн нөлөөлөл

Хорих ял эдэлж байгаа болон суллагдсан хүмүүст чиглэсэн бодлого :

Дэлхий дахинд ял эдэлж байгаа болон шоронгоос суллагдсан хүмүүст чиглэсэн төрийн бодлого үндсэн хоёр хэлбэртэй байдаг. Үүнд :

- Social control of criminals буюу нийгмийн хяналтын хэлбэр
- Rehabilitation of criminals буюу нийгэмд амьдрахад нь дэмжлэг үзүүлэх хэлбэр

Энэ хоёр хэлбэр нь тухайн улсын нийгмийн хөгжлийн чиг баримжаатай холбоотойгоор тодорхойлогддог.

Нийгмийн хяналт нь шоронгоос суллагдсан хүмүүсийг "засрашгүй хүмүүс" гэж үзээд "давтан, рецедив гэмт хэрэгтэн" хэмээн нэрлэж, түүнтэй хийх тэмцлийг чангатгадаг. Хүмүүс дахин гэмт хэрэг үйлдэж байгаа нь хууль тогтоомжийг үл ойшоож, засарч хүмүүжихийг хүсэхгүй байгааг илтгэн харуулах шалгуур гэж үзэж шоронгоос суллагдсан хүмүүст нийгмийн зүгээс тавих хяналт илүү чанга байх ёстой бөгөөд ингэснээр тэднийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж чадна гэж үздэг.

Харин либерал чиг баримжаатай барууны гэгдэх орнуудад хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн сэтгэл зүйг эмчлэх, нийгмийн туслалцаа үзүүлэх ажлын онолын үндэслэл 1970-аад оноос эхлэн ул суурьтай хөгжиж эхэлжээ. Энэ нь гэмт хэрэгтнийг нийгэмд дахин засаж, хүмүүжүүлж болдог, ингэхийн тулд шоронгоос суллагдсан хүмүүст туслалцаа дэмжлэг хэрэгтэй гэсэн хүмүүнлэг үзэлд тулгуурладаг.

1960-аас 1980 онд БНМАУ-ын Засаг хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага тухайн үеийнхээ нийгмийн онцлогт тохирсон "тусгай комендатур" хэмээх алба, нэгж байсан бөгөөд эдгээр нь шоронгоос суллагдсан хүмүүсийг хүлээн авч, хуучин ажиллаж байсан газар нь эгүүлэн ажилд оруулах, нийгмийн ашиг тустай хөдөлмөр эрхлүүлэхэд туслах зэргээр идэвхитэй ажиллаж байсан нь төрийн эрүүгийн бодлогын хувьд маш зөв байсан бөгөөд хорих байгууллагаас суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэхэд ямар нэг хэмжээгээр сайн нөлөө үзүүлж байсан нь ойлгомжтой. Иймд энэ "өнгөрсөн туршлага"-ыг хэлбэр, хэрэгжүүлэх аргын хувьд өөрчилж буцаан нутагшуулах шаардлагатай байж болох юм.

Орчин үед Европын холбоо зэрэг Бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудаас ардчилсан хүмүүнлэг иргэний нийгмийг баримжаалан хөгжиж байгаа улс орнуудад шоронгоос суллагдсан хүмүүст дэмжлэг үзүүлэх төрийн бодлого илүү үр дүнтэйг зөвлөж, гишүүн улсууддаа энэхүү ажлын стандартыг тогтоох шаардлага тавьж байгааг анхаарах нь зүйтэй байна.

Олон улсын туршлага

ОХУ:

Ялтныг нийгэмшүүлэх ажил нь хэд хэдэн үе шатанд хуваагддаг. Энэ нь нийгэмэрүүл мэндийн, хөдөлмөр мэргэжлийн, эрх зүйн, сэтгэл заслын, ахуй-нийгмийн гэж хуваагддаг. Эдгээр нь тус бүртээ өөрийн гэсэн нийгэмшүүлэх тодорхой аргатай байдаг. Эдгээр нийгэмшүүлэх ажлыг амжилттай, үр дүнтэй болгохын тулд үе шаттай байх, бүрэн дүүрэн байх, залгамж холбоотой байх, үр дүнтэй байх зарчмыг хэрхэн баримтлахаас ихээхэн хамаардаг. Мөн нийгэмшүүлэх ажиллагааг явуулахдаа сайн дурын болон үүргийн, үнэ төлбөргүй болон хүртээмжтэй зарчмыг баримтлан энэ төрлийн үйлчилгээ зайлшгүй хэрэгцээтэй байгаа хэсэгт (тухайлбал, ганц бие эх, өндөр настан, тэтгэврийнхэн, хөгжлийн бэрхшээлтэй болон өвчтэй хүмүүс, ажилгүйчүүд, шилжин суурьшигсад, дүрвэгсэд) хүрч үйлчилдэг.

Энэхүү олон талт нийгэмшүүлэх ажил нь засан хүмүүжүүлэх газар эхэлдэг бөгөөд үүнд хамрагдагсдын хувийн чадавхи нь нийгэмд байр сууриа бүрэн дүүрэн олох

боломжтой болох хүртэл хугацаанд хэрэгждэг.

Тусгаар тогтносон улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудын хүрээнд "Криминон СНГ" гэсэн бие даасан ашгийн бус байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Уг байгууллагын бүтэн нэр нь Хууль зөрчигчдийг нийгэмшүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Криминон СНГ төв гэдэг бөгөөд 2010 оны 6 дугаар сарын 17-ны өдөр ОХУ-ын Хууль зүйн яаманд бүртгэгдсэн байна. Үүнээс өмнө "Эйбл СНГ" гэдэг буяны сангийн салбар байдлаар үйл ажиллагаагаа явуулж иржээ. Энэхүү байгууллага нь "Криминон" хөтөлбөрийн зорилгод хүрэхийг хүссэн байгууллага, аж ахуйн нэгж, сайн дурынхныг нэгтгэж байдаг. Уг хөтөлбөрийн зорилго нь гэмт хэргээс ангид аюулгүй нийгмийн бий болгох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ялтныг нийгэмшүүлэх юм. Хөтөлбөрийн хүрээнд "Криминон-Новосибирск", "Криминон-Надежда" (Украйн), "Криминон-Урал" (Екатеринбург), "Криминон-Уфа" гэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Мөн Санкт-Петербург, Москва, Самара, Барнаул зэрэг хотуудад зайны сургалтын сүлжээ ажилладаг байна.

ОХУ-д "Криминон" хөтөлбөр нь 1996 оноос хэрэгжиж байгаа бөгөөд "Аз жаргалд хүрэх зам" нэрийн дор явуулсан туршилт хөтөлбөрийг Шахов дахь засан хүмүүжүүлэх газар /1996-1997/, Оренбург муж дахь эрэгтэйчүүдийн чанга дэглэмтэй хорих ангид /1999-2000/ тус тус явуулсан байна. Туршилтын багийг 55 ялтнаас бүрдүүлж байсан бөгөөд сургагч нар шууд газар дээр нь ажиллажээ.

Хөтөлбөр болон нэмэлт сургалтыг амжилттай төгссөн ялтнууд хөтөлбөрийг бусаддаа зааж сургах туршлага өргөжиж байгаа бөгөөд Челябинск болон Омск дахь хорих ийм маягаар сургагч багш бий болсон байна.

2010 оны 2 дугаар сарын 17-ны өдөр ОХУ-ын Холбооны бүгд хурлаас "Ял эдлэгсдийг нийгэмшүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тухай" тогтоол гарсан байна. Үүнд ял эдлэж байгаа болон хорих ял эдлээд суллагдсан этгээдийг эргэж нийгмийн хэвийн амьдралд оруулах нь төрийн болон эрүүгийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, иргэний нийгмийн чухал асуудал гэдгийг онцлоод, сүүлийн жилүүдэд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудад ялын альтернатив бодлого болон аливаа шийтгэлийг энэрэнгүй ёсонд нийцүүлэх чиглэл баримтлах хэрэгтэйг дурджээ. Мөн сүүлийн 10 жилийн хугацаанд 3 сая хүн хорих ял эдлээд суллагдсан ба гэмт хэргийн 35 хувийг онц аюултай гэмт хэрэг эзэлж байгааг дурдсан байна.

ХБНГУ

Ял эдлээд дууссаны дараа эргээд нийгэмд ороход нь туслах зорилгоор болон нийгэмтэйгээ адил хөгжих хүний эрхийг хүндэтгэх үүргээ биелүүлэхийн тулд Герман улс нь ял эдэлж байгаа хүмүүст тусгай боловсрол эзэмших янз бүрийн арга хэмжээг зохион байгуулдаг бөгөөд өөрөө хөгжих, эргээд нийгэмд орох зэрэгт байнга бэлддэг. Ялаа эдэлж дууссаны дараа ялтан нь сурсан мэргэжлийн дагуу "Ажил олгох газар"-т бүртгүүлэх бөгөөд энэ байгууллага хорих ял эдлээд суллагдсан хэнд боловч үйлдчилдэг. Ажил эрхлэх чадвараас нь хамаараад тохирох ажлыг нь хайх бөгөөд боломжгүй бол нөхөн олговор олгодог. Ажилгүйдлийн мөнгө нь хамгийн багадаа 400 орчим еврогоос эхлэн олгодог. Мөн энэ хугацаандаа тухайн хүний ажил эрхлэхэд нь саад болж буй бэрхшээлийг алга болгохын тулд сургалт, арга хэмжээ зохион байгуулдаг ба үүнд оролцох эрхтэй байдаг. Хүүхэд боловсрол эзэмшиж амжаагүй байдаг учраас шүүхээс ял ногдуулахдаа боловсрол эзэмших боломжийг тасалдуулахгүй байх, нийгмээс хөндийрүүлэхгүй байхад зэрэгт хамгийн ихээр анхаардаг. Тиймээс "насанд хүрээгүйчүүдэд туслах төв" гэж төрийн байгууллага байдаг бөгөөд энэ нь гэмт хэрэгт холбогдсон цагаас эхлэн хүүхдийн эрх ашгийг хамгаалдаг бөгөөд хэрэг шийдвэрлэгж дууссан ч тухайн хүүхдийг нийгэмд байр суурьа олтол нь тусалж дэмждэг.

Германд ялтныг нийгэмшүүлэх чиглэлээр тусгайлан бэлтгэсэн мэргэжилтнүүд ажилладаг бөгөөд насанд хүрсэн хүн, хүүхдэд хүртэл ялгаатай сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйч, мэргэжилтнүүд үйлчилдэг. Өөр нэг чухал зүйл нь Ausbildung /мэргэжил олгох сургалт-их дээд сургуулиар олгох шаардлагагүй, сургалт үйлдвэрлэлийн төв/ тогооч жолооч, даатгалын ажилтан, мужаан, слесарь гэх мэт мэргэжил олгодог байна. Эдгээрийг санал болгосон байгууллагуудад хүргүүлдэг бөгөөд үүнийг хорих анги болон өөр төрлийн ял эдэлж байгаа хүмүүсийн дунд зохиодог төдийгүй суллагдсан хүнд ч хамааралтай байдаг байна. Энэ нь дараа нь энгийн амьдралаа цааш нь хэвийн үргэлжүүлэхэд нилээд чухал үүрэгтэй байдаг бас баталгаа болдог байна.

Энэ бүгдээс үзвэл Герман улсад хүний эрхийг өндөрт тавьж, ял эдлэх нь тухайн гэм буруутай үйлдэлд нь ногдуулах хангалттай арга / залхаалт/ бөгөөд үүнийг цааш нь хэтрүүлж хэрэглэж болохгүй гэж үздэг. Жишээ нь: хорих ял эдэлж байгаа хүн тусгай газар нийгмээс тусгаарлагдаж байгаа ч бусад бүх эрхээ эдлэх боломжтой. Герман иргэний нийгмийн баталгаа гэх зүйл нь ял эдэлсэн хүнд ч үйлчилдэг. НҮБ-ын Хүний эрхийн дүрмүүд ялтантай харьцах наад захын жишиг дүрмийн заалтуудыг хуулиндаа хэрэгжүүлж чадсан байна.

	Хэрэгжүүлсэн арга зам	Орнууд
1	Эрүүгийн хууль тогтоомжоо шинэчлэх	- Япон
2	Хорих ял эдлүүлэх байгууллагын тухай хууль тогтоомжид өөрчлөлт хийх	- Финланд
3	Тусгайлсан хууль гаргах /Prison Act or Penal Code/	- Эстони - ХБНГУ - АНУ - Их Британи
4	Эрүүгийн хууль тогтоомжийн хорих ялын хэсэгт нэмэлт, өөрчлөлт хийж хоригдлыг нээлттэй, хаалттай дэглэмд ял эдлүүлэх, ажил хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай бодлогын баримт бичиг гаргах	- ОХУ

Хоёр. Судласан орнуудад хорих ял эдлүүлэх хорих ангийн нээлттэй хаалттай төрөл, дэглэмийг хуульчлахдаа дараахь хууль тогтоомжийг батлан гаргах, эсвэл өөрчлөх, шинэчлэх байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Эрүүгийн хууль /Criminal code/
2. Хорих байгууллагын /шүүхийн шийдвэр биелүүлэх/ тухай хууль
3. Ялын тухай хууль /Penal code/
4. Шоронгийн тухай хууль /Prison Code, Imprisonment code, Prison Act/

Эрх зүйн тогтолцооны онцлогоос шалтгаалан хорих ялыг эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт адилгүй боловч бүхэлдээ хорих ялыг эдлүүлэхдээ хорих байгууллагад ажиллах хүний нөөц, боловсон хүчний чадавхижуулалт, ялтныг нийгэмшүүлэх тодорхой төрлийн ажлууд, эргэлт уулзалт, хөдөлмөр эрхлэх боломж, хоригдлын ял эдлэх орчин зэргээрээ ялгагдаж байна. Тухайлбал ХБНГУ-д хэрэглэж байгаа хорих ангийн нээлттэй хэлбэрийн зарим нь баривчлах ялтай төстэй боловч түүнийг хэрэгжүүлэх алба нэгж, хэлтсийн зохион байгуулалт тус тусдаа байдаг.

Гурав. Ялтныг нийгэмшүүлэх ажлыг нийгмийн ажил төрөл хэлбэр хэмээн үзэж тусгайлсан хуулиар зохицуулж байгаа улс байхад хөтөлбөр гарган хэрэгжүүлж байгаа жишиг ч байна. Ял эдлэж байгаа хүмүүсийг нийгэмд дасан зохицоход нь туслалцаа дэмжлэг үзүүлэх ажил нь нийгмийн үйлчилгээний нэг төрөл бөгөөд үүнийг зарим орны

туршлагаас үзэхэд төрийн аль нэг институтаар гүйцэтгүүлдэг байна.
Ялтныг нийгэмшүүлэх талаар судлагдсан улс орнуудад тогтсон хэд хэдэн хандлага байна. Үүнд

1. Social control буюу нийгэм-захиргааны хяналт тогтоох гэсэн манай улсад байгаа загвар нь постсоциалист зарим оронд байдаг. Казакстан, Киргизстан гэх мэт.

2. Probation, Parol буюу тусгайлсан алба, ажилтан хяналт тавьж, дэмжлэг үзүүлэн ажиллах. Энэ нь зарим тохиолдолд "bootcamp, "halfway house" гэсэн хэлбэр буюу түр амьдрах, туслалцаа авах, орогнох зэрэг орон байр хэлбэртэй байна. Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудад түгээмэл байдаг хэлбэр.

3. Хорих ялын нээлттэй хаалттай дэглэмийг нийгмийн ажлын үр дүнтэй хэлбэртэй хослуулан хэрэгжүүлэх систем буюу Ром-Германы эрх зүйн тогтолцоотой зарим улс оронд бий. Тухайлбал Герман, Эстони, Европын холбооны зарим улсууд багтаж байна.

4. Тусгайлсан хөтөлбөр гарган ажиллах буюу хорих анги ял эдэлж байгаа болон суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх хөтөлбөр нь хорих ял эдлүүлэх эрх зүйн орчин харьцангуй сайн хөгжөөгүй улс орнуудад хэрэглэдэг бөгөөд үүний нэг тод жишээ нь: Өмнөд Африкийн Бүгд Найрамдах улс юм. Энэ улс нь ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөрийг 2002 оноос олон улсын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үүндээ хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудыг өргөнөөр татан оролцуулж, төрийн зарим чиг үүрийг гүйцэтгүүлж байгаа туршлагыг нэвтрүүлжээ.

Дөрөв. Хорих ангийн нээлттэй төрөл, дэглэмтэй дээрхи орнуудын хувьд ялтныг хөдөлмөр эрхлүүлэх эрх зүйн зохицуулалтыг дэлгэрэнгүй болон тодорхой зааж өгсөн байна. Энэ нь :

- Хорих байгууллагаас гадуур хөдөлмөр эрхлэх, /Эстони/
- Хорих байгууллага дотор буюу сулагдахаас өмнө хөдөлмөр эрхлэх /ХБНГУ/
- Гэрээгээр хөдөлмөр эрхлэх, АНУ, ОХУ, Япон
- Шүүхээс ногдуулсан хорих ялыг хөдөлмөр эрхлэх хэлбэрээр солих /Финлянд/

гэх мэтчилэн ялгавартай тусгаж өгсөн ч хорих ангийн хаалттай дэглэмээс ялгагдах гол шинж нь ажил хийлгэх, хөдөлмөр эрхлэх эрх зүйн орчинг бүрдүүлсэнд байна.

Дурдсан орнуудад ялтны хөдөлмөр эрхлэлтийг явуулахдаа энэ талаар бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төлөвлөгөө, журам, заавар гаргахдаа юуны өмнө хорих ангид хөдөлмөр эрхлэх сургалт, дадлагажуулалтын асуудлыг шийдвэрлэсний дараагаар эрхлэх хоригдлын хөдөлмөр эрхлэлтийн талаар тусгажээ. Зарим оронд тухайлбал Эстони Улсын Хорих ял эдлүүлэх тухай хуулийн зүйл, хэсгийг үзэхэд хорих ангийн гадна хөдөлмөр эрхлэх хугацаа, хорих ангид байх хугацаа, ажлын хөлс, сургалт, хөдөлмөр эрхэлж болохгүй байдал, насны хязгаар гэсэн байдлаар нэг бүрчлэн тодорхой хуульчилжээ.

Судалгааны хүрээнд гаргах санал, зөвлөмж

Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэхэд анхаарах дараах бүлэг асуудлыг анхаарах. Үүнд:

Нэг. Эрүүгийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө зардлыг төсөвт хүрэлцээтэй суулгаж өгөх. Баривчлах ял зэрэг хорих ялын альтернативыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу эдлүүлэх шаардлагатай нөхцлийг бүрдүүлэх, хорих ангийн нээлттэй байх хувилбарыг хэрэгжүүлэхдээ иргэнд дөхөмтэй хувилбарыг сонгож авах. Тухайлахад хорих ялын нээлттэй, хаалттай дэглэмийг тусгахдаа Эрүүгийн хуулийн Есдүгээр бүлэг. Эрүүгийн хариуцлагын зорилго, төрөл, Аравдугаар бүлэг. Ял ногдуулах гэсэн бүлгүүд,Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулснаар шийднэ гэж үзэх нь учир дутагдалтай юм. Үүн дээр нэмж баривчлах ялын эрх зүйн зохицуулалт, эдлүүлэх хэлбэрийг илүү тодорхой болгож, ялтныг нийгэмшүүлэх

талаар хуулийн заалтыг тодотгох хэрэгтэй.

Одоо нээлттэй дэглэмийг туршилтаар хэрэгжүүлж байгаа Дархан Уул аймаг дах хорих ангиас гадна жирийн дэглэмтэй хорих анги болон эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүмүүсийн хорих ангийг нээлттэй дэглэмд шилжүүлэхдээ "Хорих ангийн дотоод журам", "Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр"-ын уялдааг хангах.

Хоёр. Гадаадын зарим орны сайн хувилбарыг өөрийн хөрсөнд буулгаж "нутагшуулах"-даа зөвхөн нээлттэй гэсэн нэр томъёонд анхаарахаас илүүтэй ялтныг хөдөлмөрлөх, нийгэмд ажиллаж, гэр бүлийнхэнтэйгээ холбоотой байх боломж олгосон, олон улсын стандартад нийцсэн байх шинжийг энэ тэргүүнд харгалзах. Монгол Улсад ялтан ял эдэлж байх хугацаандаа хөдөлмөр эрхэлж хохирлоо барагдуулах талаар ямар нэгэн санаачлагагүй, хорих ангийн зүгээс хөдөлмөр эрхлүүлдэг боловч хөдөлмөрийн хөлс нь ялтны өдөр тутмын хэрэгцээ бусад зүйлд зориулагддаг, хөдөлмөрийн хөлсний үнэлгээ /ШШГЕГын даргын 1/53 тоот тушаалаар батлагдсан/ бага, эрэгтэй ялтнууд болон насанд хүрээгүй ялтнууд хөдөлмөр эрхлэх боломж багатай, энэ талын мэдлэггүй байдаг. Эстони Улсын Хорих ял эдлүүлэх тухай хуульд тусгасан хөдөлмөр эрхлүүлэх нөхцөл, хязгаар, хорих ангийн дотор болон гадна хөдөлмөр эрхлэх зэрэг боломжийг тусгах.

Хоригдлын хөдөлмөрлөж хохирлоо нөхөн төлөх бололцоог хангах ажлыг зохион байгуулж, үүнд аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах, тэдгээрийг урамшуулах санхүүгийн болон бусад арга хөшүүргийг олох. Тухайлбал Финланд Улс хорих ангид нээлттэй хөдөлмөр эрхлүүлэхдээ хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулан ажилладаг туршлагыг харгалзах.

Анх удаа хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих ялаар шийтгүүлсэн ялтнуудын хорих ял эдлэх хугацаандаа эрхэлсэн ажил хөдөлмөрийг ажилласан жилд оруулан тооцох асуудлыг судлах. Тухайлбал 1996 онд батлагдсан ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуульд хоригдлын засан хүмүүжүүлэх колонийн үйлдвэрлэлд ажилласан хугацааг улсад ажилласан хугацаанд оруулан тооцох, хөдөлмөрт хамрагдаж байгаа хоригдолд жилд ажлын 12-18 хоногийн амралт олгох, 30 хүртэл насны хоригдол ерөнхий боловсролын сургалтад заавал хамруулж байхаар хуульчилсан байна. /ОХУ-ын туршлага/

Гурав. Хорих ангийн нээлттэй, хаалттай төрөл, дэглэмд шилжихдээ ял эдэлж байгаа болон суллагдаж гарсан хүмүүст чиглэсэн төрийн дэмжлэг туслалцааны бодлогыг хэрэгжүүлэх хөтөлбөрийг боловсруулах нь зайлшгүй чухал гэж үзнэ. Ийм хөтөлбөрийн зэрэгцээ ялтан хорих ангид байхдаа болон суллагдсанаас хойш гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх бодлогыг мөн хэрэгжүүлж байж нээлттэй дэглэмийн зорилго биелэдэг гэж гадны судлаачид бичсэн байна.

Хорих ялын нээлттэй, хаалттай дэглэмийг нийгмийн ажлын хэлбэртэй хослуулан хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх. /ХБНГУ-ын туршлага/

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь дараах шинжийг агуулсан байвал зохино. Үүнд:

• Хорих ангид ял эдэлж, суллагдах гэж байгаа болон суллагдсан хүмүүст чиглэсэн байх. Эдгээр хүмүүст чиглэсэн ажил нь хоорондоо уялдаа холбоо бүхий бодит үр дүн гарахад үндэслэсэн байх ёстой.

• Хуулийн байгуулагуудын үйл ажиллагаанд хүндрэл учрахааргүй байх. Хууль, журам, зааврыг өөрчлөлгүйгээр хэрэгжих боломжтой, өдөр тутмын үйл ажиллагаа тухайлбал өөр хооронд уялдаа холбоо бүхий процессыг тусгасан байх.

• Төрийн чиг үүргэгт заасан зарим ажлыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, тухайлбал ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөрийн зарим хэсгийг гүйцэтгүүлж буй ОХУ-ын жишгийг /Криминон хөтөлбөр/ хэрэгжүүлэх

ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ПРАКТИК



Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны мэргэжилтэн, ахмад Л.Эрдэнэцагаан

Аливаа улс орны хүмүүний ухамсар, сэтгэхүйн төлөвшил нь нийгэм эдийн засгийнхаа хөгжилтэй салшгүй холбоотой бөгөөд.хөгжиж буй Монгол Улсын хувьд эрх зүйн систем, тогтолцоогоо олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж шинэчилж, боловсронгуй болгон хөгжүүлж байгаа билээ.

Өнөөдөр Монгол Улс Олон улсын гэрээ болон Хүний эрхийн тунхаглалд заасан хүний эрх, эрх чөлөө, жам ёсны эрхийн үндсэн зарчмуудыг хүлээн зөвшөөрч, улмаар хүний эрхийг хангах, халдашгүй байдлыг баталгаажуулах үүргийг Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоороо хүлээж, эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх ашгийг төрийн зүгээс хамгаалах, тэдний эрхээ эдлэх нөхцөл боломжийг олгох асуудалд эрх зүйн шинэтгэлийн хүрээнд ихээхэн анхаарал хандуулж байна.

Шүүх эрх мэдлийн стратеги төлөвлөгөөнд шүүхийн шийдвэрийг хуулийн хүрээнд биелүүлдэг нөхцлийг бүрдүүлэх, шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагааг боловсронгуй болгох, зах зээлийн нөхцөлд нийцсэн оновчтой хувилбар бий болгох, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд прокурорын байгууллага хяналт тавихаар холбогдох хуулиудад тусгах, шүүхийн шийдвэрийг биелүүлэх байгууллагын ажилтныг шаардлагатай техник хэрэгсэл, эдийн засгийн баталгаагаар хангах нөхцлийг тогтоох, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааг хэрэгсэхгүй болгуулдаг тогтолцоо бий болгох асуудлыг судалж шийдвэрлэхээр тусган, дээрх заалтуудыг хэрэгжүүлэхээр тодорхой арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Үүний илрэл нь 2002 оны "Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаа, зохион байгуулалтын үндсийг тодорхойлон тогтоосон Эрүүгийн, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний, Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол улсын хуулиудыг шинэчлэн баталсан билээ.

Эдгээр хуулиудад нийгмийн хөгжилтэйгээ уялдуулан тухай бүрт нь нэмэлт өөрчлөлтийг хийж ирсэн бөгөөд зарим нэг заалт, хуулийн нэр томъёог гадаад орнуудын хуулиас шууд авч хэрэглэсэн, өөрийн орны ахуй, амьдралын хэвшилд тохируулан хийгээгүйгээс хуулийн алдаатай, хоорондын уялдаа холбоогүй байх нь ажиглагддаг.

Нийгмийн төдийгүй хувь хүний эрэлт хэрэгцээг бүрэн хангасан байдлаар хууль тогтоомжийг гаргахад алдаа байхыг үгүйсгэх аргагүй юм. Хуулийг хүн л зохиож, зохиосон хуулиа өөрсдөө дагаж мөрддөг шүүдээ.

Шүүхийн шийдвэр гүйцтгэх ажиллагааг явуулж байгаа практик, хуулийг хэрэглэж буй байдлаас ажиглахад дараах тулгамдсан асуудлууд байсаар байна. Тухайлбал: Эрүүгийн ялын төрөл, ялангуяа хорихоос өөр төрлийн ялын гүйцэтгэлийн талаархи иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дутмаг байгааг дурьдах нь зүйтэй.

Эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааны нилээн онцлог томхон бүрдэл хэсэг бол хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолийг гүйцэтгэх ажиллагаа юм.

Энэ төрлийн ялыг хэрэгжүүлснээр нэг талаас нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, ял шийтгүүлэгчийн ёс зүйн төлөвшил, гэм буруугаа хүлээх ухамсар, хохирол

арилгахад давуу байдал олгож болох боловч нөгөө талаас гэмт хэргийн зүйлчлэл, ялын хэрэгжилтэнд тавих хяналт, үр нөлөөг сулруулах, оногдуулсан ялын хэмжээнээс хамааруулах зарим тохиолдолд ял шийтгүүлэгч засарч хүмүүжихгүй байх зэрэг хандлагын улмаас эрүүгийн хариушлагын гарцаагүй байх, заавал биелэгдэх зарчим алдагдаж, дахин гэмт хэрэгт холбогдох сөрөг үр дагавар гарч болзошгүй байгааг анхаарах шаардлагатай байна.

Иймээс хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, тухайн ялын хэрэгжилтийг хангах эрх зүйн зохицуулалт, түүний онцлог шинж чанар, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад баримтлах хууль, журмыг онолын болон практикийн хүрээнд тусгайлан судалж дүгнэх, улам бүр хөгжүүлэх шаардлага урган гарч байна.

Иргэдийн олонхи шүүхээс зөвхөн хорих ял л оноодог гэдэг өрөөсгөл ойлголттой явдаг. Тиймдээ ч хорихоос өөр төрлийн ял болох торгох, эд хөрөнгө хураах, тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, албадан ажил хийлгэхийг ял гэж үздэггүй байна. Энэ төрлийн ял авсан бол юман чинээ тоодоггүй сэтгэхүй давамгайлдаг бөгөөд шүүгчид, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаныхан нь ч ийм шийдвэрт хайнга ханддаг нь ажиглагдаж байна.

Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, түүний эрх зүйн зохицуулалт, шүүхийн шийтгэх тогтоолоор тухайн гэм буруутай этгээдэд оногдуулсан ялыг эдлүүлэх, мөнгөн дүнгээр биелүүлэх ажиллагааны өнөөгийн байдал, энэ төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй зарим бэрхшээлтэй асуудал, түүнийг үр дүнтэй шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхэд энэхүү нийтлэлийн зорилго оршиж байгаа юм.

Тиймдээ ч хорихоос өөр төрлийн ял, шийтгэл практик дээр хэрхэн хэрэгжиж буйг тодорхой бодит тоо баримт, судалгаа, ялын хэрэгжилтийг хангуулж буй байгууллагуудын мэдээ, тайланг үндэслэн энэхүү нийтлэлд уг ялын талаар авч үзэж ялын төрлөөр нь нэг бүрчлэн авч үзье.

1. Торгох ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны өнөөгийн эрх зүйн зохицуулалт.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэдэг нь иргэний болон захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр болон шүүхээс баталгаажуулж өгсөн бусад байгууллагын хуульд заасан шийдвэр, хорих ял оногдуулахаар заасан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол, хорихоос өөр төрлийн ял оногдуулахаар заасан шүүхийн шийтгэх тогтоолийг үндэслэн хуулиар эрх олгогдсон байгууллага, албан тушаалтнаас хууль журамд заасны дагуу гүйцэтгэж байгаа төрийн албадлагын арга хэмжээний нэг төрөл юм.

Торгох ял гэдэг нь: Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд шүүхээс мөнгөн төлөөс оногдуулахыг торгох ял гэнэ. Торгох ялын хэмжээг гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтооно. Торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл уг ялын хэмжээнээс хамааруулан шүүх торгох ялыг Эрүүгийн хуульд заасны дагуу гурван жил хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болно. Харин торгох ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх нь торгох, эд хөрөнгө хураах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааг ШШГТХуулийн 10-14, 18-20 дугаар зүйлд тус тус заасны дагуу гүйцэтгэх бөгөөд Торгох ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол гарснаас хойш ялтан 7 хоногийн дотор шийдвэрийг сайн дураар биелүүлэх үүрэгтэй.

Ялтан ШШГТХуулийн 91.2-д заасан хугацаанд торгуулийн мөнгийг төлөөгүй тохиолдолд шүүгч шийтгэх тогтоолыг ялтны оршин суугаа буюу ажиллаж байгаа, эсхүл эд хөрөнгө нь байгаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд 3 хоногийн дотор хүргүүлэх ба Шийдвэр гүйцэтгэх албаны ахлах шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 12.1-т заасны дагуу

тогтоосон тойргийн шийдвэр гүйцэтгэгчид шүүхийн шийдвэрийг хуваарилна.

Шийдвэр гүйцэтгэгч нь шүүхийн шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор торгуулийн мөнгийг шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд тушаах, уг хугацаанд торгуулийн мөнгийг төлөөгүй бол ялыг албадан биелүүлэх тухай ялтанд мэдэгдэх хуудас явуулна.

Ялтан торгуулийн мөнгийг бүрэн тушааснаар торгох ялыг бодитой биелүүлсэнд тооцож, шийдвэр гүйцэтгэгч энэ тухай шийдвэр гаргасан шүүхэд мэдэгдэнэ.

Хэрэв ялтан торгуулийн мөнгийг ШШГТХуулийн 91.2-т заасан хугацаанд төлөх бололцоогүй байвал түүний өргөдлийг үндэслэн шийдвэр гүйцэтгэгч торгууль төлөх хугацааг 6 сар хүртэл хугацаагаар хойшлуулах болон мөн хугацааны дотор хэсэгчлэн төлүүлэх тухай санал прокурорт гаргах ба прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

Ялтан нь шийдвэр гүйцэтгэгчийн тогтоосон хугацаанд торгуулийн мөнгийг төлөөгүй бол шийдвэр гүйцэтгэгч торгуулийн мөнгийг ялтны эд хөрөнгөөс албадан гаргуулна.

Тухайн ялтан эд хөрөнгө, хөдөлмөрийн хөлс, цалин орлогоо нуух, бусдад хууль бусаар шилжүүлэх, үрэгдүүлэх, шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэлгүйгээр байнга оршин суугаа газраа өөрчлөх зэргээр ял эдлэхээс санаатайгаар зайлсхийвэл шийдвэр гүйцэтгэгч зохих шалгалт явуулж, торгох ялыг баривчлах, хорих ялаар солих тухай саналыг прокурорт гарган, прокурор дүгнэлт гарган шүүхэд хүргүүлэх ба шийдвэр гүйцэтгэгчийн санал, прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх Эрүүгийн хуульд заасны дагуу торгох ялыг баривчлах, хорих ялаар сольж болдог.

Дээрхээс үзэхэд торгуулийн ял шийтгэлийг хэрэгжүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэг талаас тодорхой хуульчилсан ч уг хуулийн бодит хэрэгжилт хөрсөн дээр төдийлөн бүрэн цэцэглэхгүй байсаар байна. Үүний нэг жишээ бол торгох ял хэт өндөр, торгуулийн ялаар шийтгэгдсэн этгээд төлбөрийн чадваргүй байх явдал байсаар байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд /91-р зүйлд/ торгох ялыг гүйцэтгэх ажиллагаа нь энэ хуулийн II хэсэгт зааснаар буюу иргэний хэргийн талаарх шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны дагуу явуулахаар заасан байна. Гэтэл торгох ялаар шийтгэгдсэн этгээд маань төлбөрийн чадваргүй байх, торгуулийн ял хэт өндөр байх гэсэн 2 үндэслэлээр торгох ялыг биелүүлэхэд ихээхэн хүндрэл учирч байна. Жишээлбэл: Хан-Уул дүүргийн шүүхийн 2009 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 263 дугаар шийтгэх тогтоолоор иргэн Э овогтой Х-г 16.308.000 төгрөгөөр торгож шийтгэжээ. Хэргийн байдлаас үзэхэд ялтан Х нь 2009 оны 7 дугаар сарын 10-ны орой найз Б-гын гуйлтаар суудлын автомашиныг жолоодож явахад хажууд сууж явсан Д согтуу байсан бөгөөд Х-ийн жолоодож явсан автомашины өрүүлийг хажуунаас эргүүлж автомашин онхолдож Д нас барсан байна. Гэтэл шүүхээс түүнд 16.308.000 төгрөгөөр торгож шийтгэсэн нь биелэгдэх боломжийн хувьд туйлын хангалтгүй юм. Учир нь ялтан Х нь ам бүл-2, эрхэлсэн тодорхой ажилгүй, хараагүй эхийгээ асран хардаг нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явцад тогтоогдсон байна.

Дээрх жишээнээс үзэхэд торгуулийн ялын бодлогыг зөв баримтлах нь шүүхийн асуудал боловч цаашид гарах үр дагаврыг анхаарах нь чухал байна.

Хорихоос өөр төрлийн ял нь хөнгөн ял гэдэг үндэслэлээр оногддог боловч хэт өндөр торгуулийн ял нь биелэгдэх боломж нөхцлөөр муу байх, биелэгдсэн ч муу үр дагавар ихтэй байх практикт ихээхэн харагдаж байна. Жишээ нь: торгох ялаар шийтгэгдсэн этгээдийн ар гэр, үр хүүхэд, амьдрал ахуй нь давхар хохирох явдал амьдралд ихээхэн тохиолдож байна.

"Эрүүгийн ял шийтгэл гарцаагүй биелдэг байх" зарчим, эрүүгийн бодлого алдагдаж

байгаа нэг жишээ бол Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны хэмжээнд өнгөрсөн 2011 онд торгох ялын 247160.1 мянган төгрөгийн үнийн дүнтэй 28 гүйцэтгэх хуудас баримт бичгийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д зааснаар торгох ялын шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэсэн үндэслэлээр ялыг хэрэгсэхгүй буюу хүчингүй болгох саналыг прокурорын байгууллагад хүргүүлэн шүүхээр шийдвэрлүүлсэн байна.

Яагаад дээрх 247160.1 мянган төгрөгийн үнийн дүнтэй 28 гүйцэтгэх хуудас 2009 оноос хойш 3 жилийн хугацаанд биелэгдэхгүй байсаар хэрэгсэхгүй болж байна вэ. Энэ нь нэг талаас төлбөрийн чадваргүй, торгох ялыг биелүүлэх боломжгүй этгээдэд шүүх торгох ял оноосон, нөгөө талаас хуульд заасан шийдвэр гүйцэтгэх ажиллагаагаар тухайн ялтан төлбөрийн чадваргүй, эд хөрөнгөгүй болох нь тогтоогдож байгаа явдал юм.

Түүнчлэн торгох ялын эрх зүйн хэрэгжилтийг бодит байдал дээр хуульчид өөрсдөө дордуулах явдал цөөнгүй байсаар байна. Тухайлбал: Шүүхээс хорихоос өөр төрлийн ял болох торгох ял оногдуулсан тухайн ялтны зүгээс өөрт оноосон ялыг биелүүлэх талаар хуулиар хүлээсэн үүрэг, иргэний эрх зүйн ухамсарт нь өмгөөлөгч нар нөлөөлөх явдал цөөнгүй байна. Жишээлбэл: Баянзүрх дүүргийн шүүхийн 2009 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 100 дугаар шийтгэх тогтоолоор иргэн А овогтой "Б"-г 21.300.000 төгрөгөөр торгож шийтгэжээ.Өмгөөлөгч хууль зүйн зөвлөгөөг тухайн ялтан "Б"-д өгөхдөө: - Торгох ялын мөнгөн дүнг шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад 3 жилийн хугацаанд сар, сараар бага хэмжээгээр хэсэгчлэн төлсөөр дуусгаж болдог гэсэн ойлголтыг төрүүлсэн байна.

Шүүхээс торгох ял авсан "Б" Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээр ирээд шийдвэр гүйцэтгэгчээс торгох ялыг биелүүлэх талаар холбогдох хууль тогтоомж, ... шүүхийн шийдвэр гарснаас хойш торгуулийн мөнгийг 7 хоногийн дотор төлж барагдуулах үүрэгтэй, мөн ... шийдвэр гүйцэтгэгч шүүхийн шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор торгуулийн мөнгийг шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд тушаах, уг хугацаанд торгуулийн мөнгийг төлөөгүй бол ялыг албадан биелүүлэх тухай ялтанд мэдэгдэх хуудас явуулах ... хуулийн заалтыг тайлбарлахад торгох ял авсан этгээд гайхах, манай өмгөөлөгч хэлэхдээ бага багаар төлсөөр 3 жил өнгөрөхөд ял чинь хэрэгсэхгүй болдог гэж хэлсэн шүү дээ гэж хэлсэн байна. Энэ бол нэг хүний жишээ биш нийтлэг явдал юм.

Түүнчлэн шүүхийн өмнөх шат хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд эд хөрөнгө хураах, битүүмжлэх, хамгаалах ажиллагаа хангалтгүй байдаг. Энэ нь шүүхийн шийдвэр биелүүлэх, торгох ялтны эд хөрөнгөнөөс ялыг албадан биелүүлэх шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад ялтан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд эд хөрөнгөө хууль бусаар бусдад шилжүүлэх, шүүхээс өөрт оногдуулах ялыг урьдчилан таамаглаж энэ талаар арга тактик боловсруулж эртнээс төлөвлөж өв хөрөнгө, хадгаламж, данс, мөнгөн хуримтлалаа өөр хүний нэр дээр шилжүүлж байгаагаар илэрч байгаа явдал юм.

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны торгох ялын бодит биелэлтийн сүүлийн 3 жилийн байдлаар гүйцэтгэх хуудас, мөнгөн дүнг харьцуулсан судалгаа:

Торгох ялын судалгаа гүйцэтгэх хуудсаар Хүснэгт 1.1

Он	2009	2010	2011
шүүхээс хүлээн авсан гүйцэтгэх хуудас	163	126	181
бодиттой биелүүлсэн гүйцэтгэх хуудас	59	59	126
үлдэгдэл гүйцэтгэх хуудас	104	67	55

Торгох ялын судалгаа мөнгөн дүнгээр Хүснэгт 1.2

Он	2009	2010	2011
шүүхээс хүлээн авсан мөнгөн дүн	941,252.9	686,561.0	1131711.8
бодитой биелүүлсэн мөнгөн дүн	163,486.8	272441.7	709460,9
үлдэгдэл мөнгөн дүн	777,766.1	674,276.0	422250.9

Прокурорын байгууллагаас нийслэлийн хэмжээнд торгох ялын бодит биелэлтийг сүүлийн 3 жилийн байдлаар 2009-2011 онд иж бүрэн шалгасан дүн шинжилгээнд торгох ялыг шүүхээс төлбөрийн төлбөрийн чадваргүй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, өөрийн гэсэн өмч хөрөнгөгүй, оршин суух хаяггүй хүнд ногдуулж буй талаар дурьджээ.

2. Албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааны өнөөгийн байдал, хэрэгжилт, бодит бэрхшээл.

Эрүүгийн хуульд заасан хугацаагаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлсон газарт нийгэмд ашигтай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг албадан ажил хийлгэх ял гэж ойлгодог.

Албадан ажил хийх ялыг Монгол улсын Шүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.1-ээс 98 дугаар зүйлийн 98.3 дахь заалт, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан 2002 оны 256 тоот тушаал "Албадан ажил хийлгэх ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэхэд хяналт тавих журам"-аар зохицуулжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.4-д ... Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга албадан ажил хийлгэх ажил олох, ажлын байраар хангах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэгтэй, ... үүргээ хэрэгжүүлэхдээ албадан ажил хийх тухай нийтэд мэдээлэх, орон нутаг дахь аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах хэлбэрээр ажиллах .. талаар хуульчилсан билээ.

Хууль хэрэгжүүлэх хүрээнд албадан ажил хийлгэх ялыг нийгэмд ашигтай ажил хийлгэх замаар эдлүүлж, нэг өдөрт 3-12 цагаар албадан хөдөлмөр эрхлүүлж хариуцсан шийдвэр гүйцэтгэгч тогтмол хяналт тавьдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь шүүхээс албадан ажил хийх ял оногдуулсан ялтнуудыг аймаг, нийслэл, орон нутгийн тохижилт үйлчилгээний компаниудад нийгэмд тустай ажил хийлгүүлэх замаар ялыг эдлүүлж байна.

Сүүлийн 5 жил буюу 2006-2011 онд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны хэмжээнд дүүргүүдийн Тохижилт, үйлчилгээний компаниудад нийт албадан ажил хийх ялтай 150.524.0 /Нэг зуун тавин мянга таван зуун хорин дөрвөн/ цагтай 656 ялтны ялыг биечлэн эдлүүлсэн байна.

Бодит байдал дээр албадан ажил хийлгэх ялтай этгээдийг ажлын байраар хангах асуудал аймаг, нийслэл, орон нутгийн төрийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллагын идэвхи сул, тэдний цаг ашиглалтанд тавих хяналт тогтмол бус бөгөөд ажлын ачааллаас шалтгаалан, шийдвэр гүйцэтгэгчээс түүнд өдөр тутмын хяналт тэр болгон тавьж ажиллаж чаддаггүй байна. Жишээлбэл: Шийдвэр гүйцэтгэгч албадан ажил хийх 350 цагийн ялтай ялтан "А"-г Хандгайтын, Шарга морьт, Салхитийн зуслангийн айл өрхүүдийн хог хаягдал цэвэрлэж байгааг газар дээр нь тэр болгон шалгаад явах боломжгүй юм.

Шүүхээс албадан ажил хийлгэх ялыг оноодог ч хаана, ямар төрлийн ажил хийлгэх нь тодорхой бус, хэрэгжүүлэх боломж, нөхцөл тааруу, ийм ялтай хүмүүс нь дийлэнхдээ

хот тохижуулах, гудамж талбайн хог цэвэрлэх, мод услах, байгууллагын цонх хаалга угаах зэрэг саархан ажил хийлгэхээс хэтэрдэггүй байгаагаас энэ төрлийн ял тодийлөн нэг мөр хэрэгжихгүй байгаа нь шалгалтаар нотлогдож хүлээн зөвшөөрөгдсөн бодит байдал болоод байна.

3. Эд хөрөнгө хураах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа өнөөгийн байдал, хэрэгжилт

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувьд ногдох эд хөрөнгийг бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж, төрийн өмчлөлд шилжүүлэхийг эд хөрөнгө хураах ял гэнэ.

Эд хөрөнгө хураах ял эдлүүлэх эрх зүйн зохицуулалтыг Шүүхийн шийдвэр гүйцтгэх тухай хуулийн 94 дугаар зүйлийн 94.1-ээс 95 дугаар зүйлийн 95.2 дах заалт хүртлэх зүйл хэсгүүдээр зохицуулсан байдаг.

Шүүх эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулахдаа хураах эд зүйл, эд хөрөнгийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заана. Эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг, эд хөрөнгө дансалсан буюу битүүмжилсэн актын хамтаар ялтны эд хөрөнгө байгаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд шүүх 3 хоногийн дотор хүргүүлнэ. Тухайн хураах эд хөрөнгө нь дундаа хэсгээр буюу хамтран өмчлөх эд хөрөнгөнөөс тодорхой эд хөрөнгийг хураахаар шүүхийн шийтгэх тогтоолд нэрлэн заасан бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу хураана.

Шүүхийн шийтгэх тогтоолд заасан эд хөрөнгийг бүрэн хурааж, улсын орлогод оруулснаар эд хөрөнгө хураах ялыг бодитой биелүүлсэнд тооцож, шийдвэр гүйцэтгэгч гүйцэтгэх баримт бичгийг хааж, тогтоол гаргасан шүүхэд мэдэгдэнэ. Шүүхийн шийтгэх тогтоолд хураахаар заасан эд хөрөнгийг үрэгдүүлсэн, нуусан, бусдад шилжүүлсэн, завшсан гэм буруутай этгээдэд хуульд заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг.

Шүүхийн шийтгэх тогтоолд хураахаар заасан эд хөрөнгийг үрэгдүүлсэн, нуусан, бусдад шилжүүлсэн, завшсан үйлдлийн улмаас тухайн эд хөрөнгийг хураах боломжгүй болсон бол түүний үнийг хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлдэг.

Эд хөрөнгө хураах ялын бодит биелэлтэнд нөлөөлж буй бэрхшээл бол шүүх эд хөрөнгө хураах нэмэгдэл ял оногдуулахдаа хураах эд зүйл, эд хөрөнгийг шийтгэх тогтоолдоо нэг бүрчлэн заалгүй мөнгөн хэлбэрээр оноож буй шийдвэрүүд юм. Үүний нэг тод жишээ бол Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны эд хөрөнгө хураах ялын 2011 оны жилийн эцсийн тус ялын судалгаа юм.

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны эд хөрөнгө хураах ялын хэрэгжилтийг өнгөрсөн 2011 оны байдлаар авч үзэхэд: Шүүхээс биелүүлбэл зохих 144 гүйцэтгэх хуудасны 47862.6 мянган төгрөгийн үнийн дүнтэй гүйцэтгэх баримт бичгээс 12186.7 мянган төгрөгийн үнийн дүнтэй 51 гүйцэтгэх хуудсыг бодитой биелүүлж 35675.9 мянган төгрөгийн үнийн дүнтэй 93 гүйцэтгэх хуудасны үлдэгдэлтэй байна.

Эд хөрөнгө хураах ялын бодит биелэлтэнд нөлөөлж буй бас нэгэн хүчин зүйл нь эд хөрөнгө хураах нэмэгдэл ялтай ялтнуудын дийлэнх хэсэг нь хорих ангиудад ял эдэлж байгаа бөгөөд ялын төрөл дэглэмээс хамаарч тухайн ялтныг хөдөлмөрийн бүтээмжтэй ажлын байраар хангаж цалин хөлснөөс нь суутгал хийх замаар эд хөрөнгө хураах ялыг биелүүлэх боломж тодий л хангалттай биш байгаа юм.

4.Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагаа, бодит бэрхшээл.

Тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолд заагдсан ялыг биелүүлэх ажиллагаанд Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх тухай хуулийн 99.1-д заасан шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсноос хойш 7 хоногийн дотор уг шийдвэрийн хувийг Шүүх тухайн этгээдийг ажил албан тушаалд томилсон, сонгосон эсхүл тодорхой үйл ажиллагаа явуулах эрх олгосон байгууллагад хүргүүлж, ялтны оршин суугаа газрын шийдвэр гүйцэтгэх албанд бичгээр мэдэгдэнэ гэсэн заалтыг зөрчиж, шүүх гүйцэтгэх хуудсыг бичиж, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд шууд ирүүлж байна.

Мөн дээрх ялыг нэмэгдэл ялын чанартай оногдуулахдаа гүйцэтгэх хуудсыг бичихгүй орхигдуулах явдал гарч байна. Түүнчлэн уг ялыг нэмэгдэл ялын чанартай оногдуулахдаа гүйцэтгэх хуудсыг бичихгүй орхигдуулах явдал нь тодорхой албан тушаал үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялын талаар улсын хэмжээнд нэгдсэн тоо бүртгэл хөтлөгдөхөд хүндрэл учруулж байгаа юм. Жишээлбэл: Шүүхээс жолооны эрх хасах ял дээр гүйцэтгэх хуудсыг харилцан адилгүй бичиж байна. Тухайлбал: Замын цагдаагийн газрын Мэргэжлий хяналтын хэлтэс дээр 2011 онд нэмэгдэл ялаар жолооны эрх хассан шүүхийн шийтгэх тогтоол 305 ирсэн байхад Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шүүхээр нэмэгдэл ял эрх хасах ялын гүйцэтгэх 55 ирсэн байх жишээтэй.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад тухай ялтныг ажилд авсан, томилсон, сонгосон аж ахуйн нэгж, байгууллага ажлаас чөлөөлөх, эрх олгосон шийдвэрээ өөрчлөхгүй байх зэрэг нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 252 дугаар тушаалаар батлагдсан журмын заалтууд зөрчигдөх явдал нэлээд гарч байна. Тухайлбал: Жолооны эрх хасах ялаар шийтгэгдсэн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавихад цагдаагийн байгууллагад албан бичиг тоот явуулахаас өөр эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Шийдвэр гүйцэтгэгч тодорхой албан тушаал эрхлэх үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг хуульд зааснаар хэрэгжүүлж, хяналт тавих боломж муутай. Жишээлбэл: Жолооны эрх хасах ял дээр тухайн эрх хасагдсан жолоочийг шийдвэр гүйцэтгэгч дуудан ирүүлж тайлбар авч, тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх талаар холбогдох хууль, журмыг тайлбарлан сануулж, энэ талаар баталгаа гаргуулах боловч тухайн иргэнийг хөдөө, орон нутагт тээврийн хэрэгсэл жолоодон явж байгаа эсэхийг хянах боломж байхгүй, тэр ч байтугай хулгайн аргаар тээврийн хэрэгсэл жолоодон ямар нэгэн осол, зөрчил гарган цагдаагийн байгууллагад шалгагдаж байгааг ч хянах боломжгүй юм.

Гэтэл жолооны эрхийг Цагдаагийн байгууллага олгодог боловч эргээд эрх нь хасагдсан тохиолдолд олгосон эрхээ түдгэлзүүлэх, сэргээх, хойшлуулах ямар нэгэн зохицуулалт байхгүй байгаа нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүндрэл гарч байна.

Өөрөөр хэлбэл Цагдаагийн байгууллагын замын цагдаагийн газар, тасагт хяналт тавьж, хамтран ажиллах тухай албан бичгийг хүргүүлэн ажилладаг ба хэрхэн яаж хяналт тавьсан талаар хариу ирдэггүй байна.

Цаашид хорихоос өөр төрлийн ялын үр нөлөөг дээшлүүлэх талаар доорхи арга хэмжээг авч хэрэгжүүлэх саналтай байна.Үүнд:

1.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог өөрчлөх, ялын төрөл, хэмжээ, оногдуулж буй байдлыг өөрчлөн шинэчлэх, тухайлбал эд хөрөнгө хураах ялын хэмжээ, биелүүлэх хугацааг тодорхой болгох

2.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, түүний дотор өнөөгийн мөрдөгдөж буй хууль, журмыг шинэчлэх, торгох ял оногдуулах шүүхийн практикийг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулах.

3.Албадан ажил хийлгэх ялыг хэрэгжүүлэхэд ялтныг харъяа аймаг нийслэл, сум дүүргийн засаг дарга ажлын байраар хангах, жагсаалт гаргах, нийтэд мэдээлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхээр байгаа нь нийгэмд тустай ажил хөдөлмөр хийлгэх ялын үндсэн шинж чанар хэрхэн нийцэж байгаа эсэхийг эргэн харах цаг болсон байна.

4. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд гадаад улсын туршлагыг судалж нэвтрүүлэх.

Эцэст нь хэлэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Иргэний болон эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр, шийтгэх тогтоолыг биелүүлэх, түүний дотор зөрчигдсөн эрхийг сэргээх, учирсан хохирлыг арилгах, баривчлах, хорих ял эдлүүлэх, хорихоос өөр төрлийн ялыг гүйцэтгэх үндсэн чиг үүргийг хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд нэр төртэй гүйцэтгэж байна.

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ НӨХӨН БАРАГДУУЛАХ ШААРДЛАГА, ХОХИРОГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ



ДХИС-ийн ШШГС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн тэнхимийн эрхлэгч, магистр, хошууч П.Гантөмөр

Хүн болоод хүний нийгмийн туйлын хүсэл мөрөөдөл нь хүн хэмээх дээд зэрэгт заяагдмал эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, хамгаалах явдал болно.

Монгол Улсад гэмт хэргийн гаралт жил бүр өссөөр түүний улмаас хохирогчдийн тоо олон мянгаараа нэмэгдэж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шүүхийн шийдвэрийн дагуу гүйцэтгэгдэж буй хэрэг материалаас гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг авч үзэхэд 70 тэрбумаар хэмжигдэж буй нь сэтгэл эмзэглүүлэх хэмжээнд хүрсэн нь харагдаж байна. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 10 гаруй хувь нь л эцсийн дүндээ бодит байдлаар биелдэг тухай, нийгмийн бухимдлын тодорхой хэсгийг хохирогчдын гомдол эзэлдэг тухай бид байнга ярьдаг билээ. Өнөөг хүртэл гэмт хэрэгтэн бие хүн, түүний зан төлөв төлөвшин тогтох механизмыг судлаачид түлхүү судалсаар ирсэн боловч хохирогчийн тухай асуудлыг тэр бүр судлалгүй орхигдуулж иржээ.

Хохирогчийн талаар Италийн хуульч эрдэмтэн Чезаре Беккарриа /1738-1794/ анх хөндсөн бөгөөд түүний дараа Иеремия Бентам, Раффаэль Гарафало, Чезаре Ломброзо, Ганс фон Гентиг, Бенджамин Мендельсон зэрэг судлаачид өөрсдийн санал бодлыг дэвшүүлж хохирогч судлалыг үргэлжлүүлэн хөгжүүлсний үр дүнд Виктимологи /хохирогч судлал/ нь Криминологийн шинжлэх ухааны бие даасан нэгэн шинэ салбар болтлоо хөгжсөн байна. Виктимологи нь явцуу утгаараа гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн этгээдийг судалдаг боловч хохирогч болох магадлалтай хүний шинж буюу Криминологийн шинж талаас нь судалдаг нь харагддаг. Харин судлаач миний бие нь энэхүү судалгааны ажилд нэгэнт гэмт хэргийн хохирогч болсон этгээдийн тухайд, түүний зөрчигдсөн эрх ашгийг хэрхэн хангах, эрх зүйн байдлыг хэрхэн тогтоож болох талаас нь судалсан болно.

Хохирогчийн тухай ойлголт: Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлд "Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ" гэж заасан бөгөөд мөн хуулийн 43 дугаар зүйл /иргэний нэхэмжлэгчийг тогтоох/, 44 дугаар зүйл /иргэний хариуцагчаар татах/-үүдэд гэмт хэргийн уршгаар зөвхөн эд материалын хохирол хүлээсэн бөгөөд түүнийгээ нөхөн төлүүлэхээр шаардлага тавьсан, эсхүл гэмт хэргийн уршгаар учирсан эд материалын хохирлыг хууль ёсоор хариуцвал зохих" этгээдүүдийг хамааруулсан байна.

Гэмт хэрэг, эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлээс хохирогсдын эрх зүйн үндсэн зарчмын тухай тунхаглалын 1 дүгээр заалтын дагуу "хохирогч" гэх нэр томъёо нь: "Гишүүн улс орнуудын хүчин төгөлдөр үйлчилж байгаа эрүүгийн болон эрх мэдлээ эрүүгийн шинж чанартай урвуулан ашигласныг хориглох хуулиудыг зөрчсөн үйлдэл эсвэл алдаа гаргах замаар бие махбодийн буюу сэтгэл санааны гэмтэл, сэтгэлийн шаналал, эдийн засгийн хохирол буюу үндсэн эрхийг нь ноцтой зөрчсөнөөс дангаараа буюу хамтдаа хохирсон хүмүүсийг хэлнэ" гэж тодорхойлжээ.

Тунхаглалын 2 дугаар заалтын дагуу "гэмт хэрэгтнийг тогтоосон, баривчилсан, ялласан буюу шийтгэсэн эсэхээс үл хамааран, мөн түүнчлэн гэмт хэрэгтэн болон хохирогч хооронд ураг төрлийн холбоо байгаа эсэхээс үл хамааран" аливаа хүнийг

хохирогчоор тогтоож болно гэж заасан нь ихээхэн ач холбогдолтой юм. Мөн зүйлийн дагуу "хохирогч" гэдэг нэр томъёонд хохирогчийн гэр бүл буюу асрамжинд байгаа хүмүүс болон аюулд орсон хохирогчдод туслах буюу тэдэнд хохирол учрахаас сэргийлэх зорилгоор хөндлөнгөөс оролцож хохирсон хүмүүсийг мөн хамруулан ойлгоно" гэжээ.

Гэмт хэргийн хохирогсдод нөхөн төлбөр олгох тухай Европын конвенцид "хохирогч" гэсний нарийн тодорхойлолт байхгүй бөгөөд түүний хүрээ нь "нөхөн төлбөрийг бусад эх үүсвэрээс бүрэн хэмжээгээр олгох боломжгүй" байвал гэмт хэргээс хохирогсдод нөхөн төлбөр олгохыг улсад үүрэг болгосон нь хязгаарлагдмал юм. Үүнээс гадна гагцхүү дараах 2 төрлийн хохирогсод нөхөн төлбөр олгохоор тогтоож болно гэжээ.

Үүнд:

• Санаатайгаар хүчирхийлэн гэмт хэрэг үйлдсэнээс бие махбодид ноцтой гэмтэл учирсан буюу эрүүл мэнд нь муудсан хүмүүс

• Ийм гэмт хэргийн уршгаар нас барсан хүмүүсийн асрамжинд байсан хүмүүс

Тэгэхдээ Конвенцид зааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх оролдлого хийх буюу гэмт хэргийг урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтнийг баривчлахад нь цагдаагийн байгууллагад туслах буюу хохирогчид туслах явцад бэртсэн буюу нас барсан хүнийг мөн хохирогч гэж үзнэ.

2-р зүйлд заасан ёсоор Конвенц нь эрүүгийн ерөнхий үйлдэл бус гагцхүү хүч хэрэглэсэн гэмт хэрэгт өртсөнд л нөхөн төлбөр олгох, харин хохирсон хүмүүст бусад төрлийн тусламж, туслалцаа үзүүлэх асуудлыг тусгаагүй байна. Иймхүү конвенцийн хүрээг зарим талаар хязгаарласан нь эрүүгийн шүүн таслах ажиллагааны тогтолцооны хүрээнд гэмт хэргээс хохирогсодод үзүүлэхэд бэлэн байх шаардлагатай бүтээлч туслалцаанд түүний үзүүлж болох байсан үр нөлөөг хязгаарлаж байх мэт харагддаг.

Гэмт хэргээс хохирогсдод учирч буй хохирол бие махбод, өмч хөрөнгийн хохирлоор хязгаарлагдахгүй харин, "санхүүгийн хохирлоо арилгуулах, гэмтээж сүйдсэн хөрөнгөө сэргээлгэж төлүүлэхийн тулд алдагдсан цаг хугацаа"-г ч хамардаг гэдгийг хуульч мэргэжлийн хүмүүс ойлгож байх нь чухал юм. Хүмүүс гэмт хэргийг харилцан адилгүй хүлээн авдаг учир хүн болгон ноцтой болон удаан үргэлжлэх үр нөлөөнд өртөхгүй боловч сэтгэл санааны ул мөр ямар ч хүнд сөрөг нөлөө үзүүлж болно, иймд асуудал хариуцах байгууллагууд ийнхүү гарч болох сэтгэл санааны өөрчлөлтийг авч хэлэлцэхгүй эсвэл хангалтгүй байдлаар авч үздэг нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн явцад харагддаг юм.

Хохирлыг арилгах

Хохирлыг арилгах тухай уламжлалт асуудал нь гэмт хэргийн хохирогчийн эд хөрөнгийн эрхийг хамгаалахаас эх сурвалжтай. Хүний нийгэм нь хохирол учрахаас өөрийн гишүүдээ хамгаалахыг ямагт эрмэлзэж ирсэн түүхтэй. Хүн төрөлхтний түүхэн хөгжлийн үе шат бүхэнд энэхүү хамгаалалт нь олон янзын хэлбэрээр хэрэгжиж байсан боловч тэр бүр хүмүүнлэг байсангүй. Төр, хууль цаазын уламжлалаас үзэхэд нийгмийн хөгжлийн эхний үе шатанд деликтийн эрх зүй нь талионы зарчимд үндэслэгдэж байжээ. Ийм ч учраас И.Кант: "ял шийтгэлийн тухай цорын ганц, ухаалаг боломжийн онол бол өр төлбөрийн эн тэнцүү байдалд үндэслэсэн талионы зарчим" гэсэн байдаг.

Эртний боол эзэмшигчдийн хууль цаазын дурсгал бичгүүдэд (Хаммурапийн хууль, Манугийн хууль, XII самбарын хууль гэх зэрэг) гэмт хэргийн төлөө ял шийтгэл нь нь эн тэнцүү байх, өөрөөр хэлбэл, "нүд бол нүд, шүд бол шүд" гэсэн талионы зарчмаар ногдуулж байсан зан заншлын эрх зүйн ул мөр гүн гүнзгий хадгалагдаж байжээ. "Talio" гэсэн латин үг нь адил, тэнцүү гэсэн утгатай үг юм. Монголын эртний зарим хууль цаазын эх сурвалжид мөн талионы зарчмын ул мөр хадгалагдаж байсан баримт бий.

Эртний Римийн XII самбарын хуульд эдийн хохирол болон бие махбодид учирсан хохирлын төлөөх мөнгөн төлбөрийг заажээ. Римийн эрх зүй болон эрх зүйн бусад

тогтолцоо, түүний дотор Германы эрх зүйд тодорхой хохирол учруулсан буюу гэмтэл учруулсан бол нөхөн төлөх ёстой (жишээлбэл, хохирогчид мөнгө төлөх буюу мал, бэлэн бүтээгдэхүүн өгөх зэрэг) гэсэн зарчмыг бэхжүүлсэн байдаг. Энэ тохиолдолд нөхөн төлбөрийг хохирогч болон түүний отог, төрөл төрөгсдөөс зөвшөөрөх ёстой байв.

Учирсан хохирлыг арилгах зарчим нь эртний уламжлалтай. Эхний үед энэхүү зарчим нь иргэний болон эрүүгийн эрх зүйд нэгэн зэрэг үйлчилж байсан учраас эрүүгийн процесс нь нэхэмжлэх ажиллагааны хэлбэрээр хөгжиж эхэлсэн байна. Хэрэг шийдвэрлэх ажиллагаа нь эхлээд хохирогч талын гомдол, нэхэмжлэлийн дагуу үүсчээ. Сүүлд эрүүгийн хэрэг үүсгэх санаачлага төрийн гарт шилжиж эхэлсэн тэр үеэс шүүн таслах ажиллагаанд мөрдөн мөшгих, эрэн сурвалжлах зэрэг процессын бусад хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрчээ.

Учирсан хохирлын төлөө нөхөн төлбөр гаргуулах эртний онол, практик нь мөн ял шийтгэл, харин өр төлөөс гэсэн үзэл санааг баримжаалж, "композици" тогтолцоо гэсэн ойлголттой нягт уялдаж байв. Композици тогтолцоо нь бие махбодид учирсан хохирлын төлөө хохирогчид мөнгөн төлбөр өгөх гэсэн эртний эрх зүйн ойлголт юм. Эрүүгийн эрх зүйн XX зууны дунд үе хүртэлх хөгжилт нь "painliches Recht" бүрэлдэн тогтох чиглэлээр хөгжсөн юм. Дундад зууны үеийн хууль цаазад хэрэглэж байсан энэхүү ойлголт нь төрийн зүгээс залхаан цээрлүүлэх ажиллагаанд оролцох оролцоо улам бүр өсөн нэмэгдэх үзэл санаатай холбоотой юм. Мөн үүнтэй уялдан хохирогчийн асуудал, эрүүгийн процесс дахь түүний эрх, эрх зүйн байдалд анхаарал тавьж ирсэнгүй.

Дэлхийн ихэнх улс орнууд гэмт хэрэг болон эрх зүйн зөрчлийн улмаас учирсан хохирлыг арилгах, хохирогчийг сэтгэл зүйн хувьд нь нөхөн сэргээх асуудалд ихээхэн анхаарал тавьж байна. Улс гүрнүүдээс энэ асуудлыг шийдвэрлэх нь "эрх зүйн аль нэгэн тогтолцооны хөгжлийн түвшингээр тодорхойлогдож байгаа юм". Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж заасан нь төрийн эрүүгийн бодлогын үндсэн зарчим юм.

Орчин үед хохирогчийн эрхийг хамгаалах хангах талаар олон улсын эрх зүйн хэд хэдэн актуудыг батлан гаргасан юм.

НҮБ-ын 1948 оны арван хоёрдугаар сарын 10-ны "Хүний эрхийн түгээмэл тунхаглал" /8§/; 1966 оны арван хоёрдугаар сарын 16-ны "Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пакт" /9§/; 1950 оны арван нэгдүгээр сарын 3-ны "Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенци" болон олон улсын эрх зүйн бусад чухал баримт бичгүүдэд хүн бүр "эрхээ бүрэн сэргээн тогтоолгох" эрхийн тухай тус тус заасан байдаг.

Гэхдээ энэ асуудлыг цогцоор нь авч үзсэн гол баримт бичиг нь 1985 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейн шийдвэрээр баталсан "Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай Тунхаглал" мөн. Энэхүү баримт бичигт гэмт хэргийн хохирогч этгээдэд учирсан хор хохирлыг арилгах асуудлыг шийдвэрлэхэд зарчмын ач холбогдолтой дараах заалтуудыг тусгасан юм:

- Зохих нөхцөл байдал бүрдсэн үед эрх зүйн зөрчигч өөрөө буюу эсхүл түүний үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээгч гуравдагч этгээд нь хохирогч, түүний гэр бүл, тэжээн тэтгүүлэгчдэд нөхөн төлбөрийг шударгаар олгоно. Хор хохирлыг ийнхүү арилгах нь эд хөрөнгө буцаан олгох, гэм хор, хохирлыг нөхөн төлөх, хохирлыг арилгахад гарсан зардлыг төлүүлэх, үйлчилгээ үзүүлэх, эрхийг нь сэргээх явдал хамаарна /8§/;

- Засгийн газар нь хохирол арилгах явдлыг эрүүгийн ял шийтгэлийн нэгэн төрөл

болгон хуульчлах талаар авч үзвэл зохино /9§/;

- Нөхөн төлбөрийг эрх зүйн зөрчил гаргагчаас болон бусад эх үүсвэрээс бүрэн хэмжээгээр гаргуулан авах боломжгүй бол төр нь дараах этгээдэд санхүүгийн нөхөн олговор олгох арга хэмжээ авна. Үүнд: хүнд гэмт хэргийн улмаас бие махбодид нь ихээхэн гэмтэл учирсан, эсхүл бие, сэтгэл санааны эрүүл мэндийн байдлыг алдагдуулсан хохирогчид; гэмт явдлын улмаас нас барсан, бие, оюун санааны хувьд үйл ажиллагааны чадамжгүй болсон хохирогчийн гэр бүлийн гишүүд, тэжээлгэн тэтгүүлэгчид зэрэг /12§/; Хохирол нөхөн төлбөр, олговрын үндэсний фонд байгуулах, бэхжүүлэх, өргөжүүлэхэд нөлөө үзүүлэх. Шаардлагатай үед, тухайлбал, төрөөс хохирсон иргэндээ нөхөн төлбөр, олговрыг хариуцан олгох чадваргүй зэрэг тохиолдолд бусад фонд байгуулж болно.

Хууль зүйн Үндсэн зарчмын тухай Тунхаглалын зүйлд 8-д заасан ёсоор: "Гэмт хэрэгтнүүд буюу тэдний үйлдлийн төлөө хариуцлага хүлээх гуравдагч этгээдүүд хохирогчид, тэдний гэр бүл буюу асрамжинд байгаа хүмүүст учирсан хохирлыг зохих ёсоор арилгах ёстой. Хохирлыг арилгах асуудал нь өмч хөрөнгийг эргүүлэн олгох буюу учирсан хохирлыг зохих ёсоор арилгах ёстой. Хохирлыг арилгах асуудал нь өмч хөрөнгийг эргүүлэн олгох буюу учирсан хохирлын төлбөр, гэмт хэрэгт өртсөний улмаас гарсан зардлыг төлөх, үйлчилгээ үзүүлэх болон бүрэн эрхийг нь сэргээх зэргийг хамарна. Заалт 9-д "эрүүгийн бусад шийтгэлээс гадна хохирол арилгахыг эрүүгийн хэрэгт шийтгэлийн хэлбэр болгон хэрэглэхийг мөрдөж байгаа практик, зохицуулалт, хуулиа хянаж тусгах асуудлыг Засгийн газрууд авч үзэх шаардлагатай" гэжээ.

"Хохирлыг арилгах" гэдэг нэр томъёо нь гэмт хэргийн улмаас хохирогчийн зөрчигдсөн эрхийг гэмт хэрэгтэн сэргээж өгнө гэсэн утгатай. Хулгайлсан өмч хөрөнгө буюу мөнгө нь хэвээр байгаа бол хохирлыг арилгах боломжтой нь тодорхой. Иймд эрхийг нь сэргээх бололцоо байхгүй хүн амины зэрэг хүч хэрэглэсэн гэмт хэрэгт бол хохирлыг арилгуулах нь шийдвэрлэх арга биш юм.

Эрүүгийн гэмт хэрэгт хариуцлага хүлээж буй хүмүүс учруулсан хохирлын төлөө хохирогсдод аль болох шударгаар хохирлыг арилгаж өгөх ёстой.

Нөхөн төлбөр.

Нөхөн төлбөрийг төрөөс олгож байгаа эсвэл санхүүгийн нөхөн төлбөрийг гэмт хэргийн улмаас бие махбодын, сэтгэл санааны буюу бусад гэм учруулсны төлөө гэмт хэрэгтэн хийж байгаагаас үл хамааран уг нөхөн төлбөрийг "гэмт хэрэгтэн хохирогчийг хохироосон болохыг хүлээн зөвшөөрч байгаагийн илэрхийлэл" гэж үзэх тул хохирогчийн хувьд их чухал байдаг. Хэрэв шүүх нөхөн төлбөр гаргуулах шийдвэр гаргавал энэ нь төр хохирогчийн төлөө санаа тавьж байгаагийн нэгэн илэрхийлэл мөн юм. Үндсэн зарчмын тухай тунхаглалын заалт 12-т нөхөн төлбөрийг гэмт хэрэгтнээс буюу бусад эх үүсвэрээс бүрэн хэмжээгээр гаргах боломжгүй бол:

1. Хүнд гэмт хэргийн улмаас бие махбодид нь их хэмжээний хохирол буюу бие махбодын буюу сэтгэцийн эрүүл мэндэд согог учирсан хохирогчдод,

2. Ийм гэмт хэргийн улмаас нас барсан буюу бие махбодын болон сэтгэцийн хувьд тахир дутуу болсон хүмүүсийн гэр бүл, нэн ялангуяа асрамжинд байгаа хүмүүст төрөөс санхүүгийн нөхөн төлбөр олгох талаар хүчин чармайлт гаргах ёстой.

Гэмт хэргээс хохирогсдод нөхөн олговор олгох тухай 1983 оны Европын конвенцийн зүйл 1-ийн дагуу гишүүн улс орнууд "энэ конвенцийн хэсэг 1-д заасан зарчмуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай алхмуудыг хийх үүрэг хүлээнэ" гэжээ. Үүний дагуу "нөхөн төлбөр бусад эх үүсвэрээс олдохгүй байгаа тохиолдолд төр дараах нөхөн төлбөр хийхэд оролцоно. Үүнд:

• Хүч хэрэглэн санаатай үйлдсэн гэмт хэргээс шууд шалтгаалж биед нь хүнд хохирол буюу согог учирсан хүмүүст,

• Энэ гэмт хэргийн улмаас нас барсан хүмүүсийн асрамжинд байгаа хүмүүст,
Уг гэмт хэргийг үйлдсэн нь

• Санаатай

• Хүч хэрэглэсэн

• Бие махбодид хүнд гэмтэл буюу эрүүл мэндэд ноцтой хохирол учруулсан бол энэ заалтын дагуу хохирогч төрөөс нөхөн төлбөр авах болзол хангана.

Конвенцид санаатай үйлдсэн гэмт хэргээр хязгаарласан шалтгаан нь "тэдгээр нь онцгой хүнд бөгөөд" хувийн даатгал болон нийгмийн даатгал зэрэг "бусад төрлийн зохицуулалтад тусгасан замын хөдөлгөөний холбогдолтой олон төрлийн гэмт хэргийг хамарсан санаатай бус гэмт хэргүүдтэй харьцуулбал нөхөн төлбөр барагдуулалт муутай байдагт оршино.

Хохирол нь заавал бие махбодийнх байх шаардлагагүй бөгөөд "бие махбодид гэмтэл учруулах буюу амь нас алдахад хүргэх сэтгэл санааны хүчирхийлэл /жишээлбэл: ноцтойгоор айлган сүрдүүлэх/ гарсан тохиолдолд нөхөн төлбөрийг арилгаж болно.

Тэгэхдээ хохирол нь ямар ч тохиолдолд "ноцтой бөгөөд тухайн гэмт хэргээс шууд хамааралтай" байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл тухайн гэмт хэрэг болон түүний үр дагавар хоорондын холбоог нотолсон байх ёстой.

Конвенцийн зүйлийн 2-т заасан ёсоор нөхөн төлбөрийг "дээрх хэргүүдийн гэмт хэрэгтнийг яллах буюу шийтгэх боломжгүй тохиолдолд ч олгоно" гэжээ. Жишээлбэл: насанд хүрээгүй буюу сэтгэцийн өвчтэй хүмүүсийг яллахгүй бөгөөд тэд өөрсдийн үйлдлийн төлөө хариуцлага хүлээхгүй, мөн түүнчлэн гэмт хэрэгтэн өөрийгөө хамгаалах үүднээс зайлшгүй үйлдэл хийсэн учир яллуулахгүй байж болно. Эдгээр хэргүүдэд хохирогч нөхөн төлбөрөө бусад эх үүсвэрээс авч чадахгүй бол төрөөс авах боломжтой байх нь асар их ач холбогдолтой. Шийтгэл болгож тогтоосон нөхөн төлбөрийг торгуультай адил аргаар төлүүлэх бөгөөд гэмт хэрэгтэнд ногдуулсан бусад санхүүгийн шийтгэлээс тэргүүн ээлжинд гүйцэтгүүлнэ. Шүүн таслах ажиллагааны явцад хохирогсодтой харьцах

Шүүн таслах ажиллагаанд хохирогсдын эрхийг бататгах талаар олон улсын түвшинд хийсэн ажил нь улс орнуудын шүүн таслах ажиллагаанд гэмт хэрэгтэн төр засагтайгаа харьцах асуудлыг голлон анхаарч, хохирогсдын эрх, хэрэгцээ, ашиг сонирхлыг орхигдуулж ирснийг хүлээн зөвшөөрснөөр хязгаарлагдаж байна. Хэдий олон улсын эрх зүйд уг асуудлыг сайн боловсруулаагүй боловч зарим удирдамж зааврыг боловсруулсан.

Эрх нь зөрчигдсөн хүний асуудлыг шудрагаар шийдвэрлэсэн гэдэг сэтгэгдэл төрүүлэх явдал гол зорилт байх ёстой гэдгийг тэмдэглэх шаардлагатай. Иймд гэмт хэргээс хохирогсдын итгэлийг нь улам алдагдуулахгүйн тулд эрүүгийн шүүн таслах тогтолцоонд ажиллаж байгаа хүн болгон хохирогсдын сэтгэл санааг зовоосон зүйл, хэрэгцээ, ашиг сонирхлыг хүндэтгэж, ойлгож байгаагаа харуулж байх ёстойг тогтмол санаж явах нь туйлын чухал. Бодолгүй хандах, анхаарал тавихгүй байх нь хохирогсдын зовиур, гомдлыг улам бүр нэмэгдүүлнэ.

Гэмт хэрэгт өртсөн хүмүүсийн асуудлыг шудрагаар шийдвэрлэхийн тулд шүүх, захиргааны механизмыг бий болгож бэхжүүлэх нь туйлын ач холбогдолтой. Үндсэн зарчмын тухай Тунхаглалын заалт 5-д заасан ёсоор гэмт хэргээс хохирогсод "хурдан шуурхай, шударга, зардал багатай, нийтэд хүртээмжтэй албан болон албан бус журмаар хохирлоо арилгуулах" боломжтой байх ёстой. Мөн заалтын дагуу хохирогсод "эдгээр механизмаар дамжуулан хохирлоо арилгуулах эрхтэй гэдэг тухай тэдэнд мэдэгдэх ёстой". Гэмт хэргээс хохирогсдод ийнхүү мэдэгдэх үүрэг бол хууль сахиулах төрөл бүрийн байгууллагуудын үүргийн чухал хэсэг болно.

Цагдаагийн байгууллагаас хохирогсодтой харьцах нь.

Эрүүгийн гэмт хэрэг гарахад хохирогч шүүхийн тогтолцооны эхний шат болох цагдаатай харьцдаг. Иймхүү анх харьцаж байгаа цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанаас шалтгаалан эрүүгийн шүүн таслах тогтолцоонд хохирогч хэрхэн хандахад шийдвэрлэх нөлөө үзүүлнэ. Иймд эрүүгийн шүүн таслах ажиллагааны эхний шатанд цагдаагийн байгууллагын үүрэг туйлын чухал юм. Үндсэн зарчмын тухай тунхаглалд цагдаагийн ажлын арга барилын талаар бараг заагаагүй боловч заалтын 4-т хохирогсдод "энэрэнгүй хандаж, нэр төрийг нь хүндэтгэн харьцах ёстой" гэсэн ерөнхий заалт цагдаагийн байгууллагад ч мөн хамаарна.

Гэмт хэргийн улмаас бусдад учирсан эд материалын хохирлыг, хэрэг бүртгэх мөрдөн байцаах болон шүүн таслах ажиллагааны явцад шуурхай шалган бодитойгоор тогтоож нөхөн төлүүлэх нь төр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эд хөрөнгийн болон өмчлөх эрх, бусад ашиг сонирхлыг хамгаалах хууль ёсны арга хэрэгсэл юм.

Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг эрүүгийн шүүн таслах ажиллагааны явцад зөв тогтоон шийдвэрлэх хуулийн этгээд, хувь хүний эд хөрөнгийн болон өмчлөх эрхийг хамгаалан хангах талаар хууль, тогтоомжийн заалтыг нэг мөр зөв хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Дээд Шүүхийн 2000 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн "Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тухай" тогтоолд дараах байдлаар тусгажээ.

Мөрдөн байцаах байгууллага болон шүүх нь гэмт хэргийн уршгаар хуулийн этгээд, хувь хүнд учирсан эд хөрөнгийн хохирлыг мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааны явцад бүрэн шалгаж, бодит хохирлын хэмжээг үнэн зөв тогтоож, хэргийг шүүн таслах хуралдаанаар нөхөн төлүүлэх асуудлыг нэг мөр шийдвэрлэх тухай хууль, тогтоомжийн заалтыг биелүүлж байхын тулд гэмт хэрэгт холбогдсон /үйлдсэн/ этгээдийн эд хөрөнгийг илрүүлэн тогтоож битүүмжлэн хамгаалах арга хэмжээг заавал авч байх ёстой гэжээ. Мөн энэхүү үйл ажиллагаанд тавих прокурор, шүүхийн хяналт нь чухал ач холбогдолтой юм.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт шүүхийн шатанд хохирогчийн эрх ашгийг хамгаалах ажиллагааг нэн даруй авч эд хөрөнгийг хамгаалалтад аваагүйгээс энэ хугацааг ашиглан эд хөрөнгийг нуун далдлах бүх ажиллагааг гүйцэтгэдэг нь практикт элбэг тохиолддог бөгөөд энэ нь шүүхийн шийдвэрийн хүчин чадал нэр хүндийг унагах, шийдвэрийн хэрэгжилт бодит бус байх нөхцлийг бүрдүүлдэг.

Монгол Улсад хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж буй албан хаагч, хуульчдын хувьд гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хохирогчийн эрхийг хангах талаар нэгдсэн ойлголттой байх, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг шуурхай ханган барагдуулах арга механизмыг тодорхойлох зайлшгүй шаардлага байгааг дурьдаад гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн барагдуулах ажиллагааг Олон улсын жишигт нийцүүлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаархи санаа бодлоо энэхүү сэтгүүлээр дамжуулан эрхэм уншигч танд цуврал болгон хүргүүлэх болно.

ИПОТЕКИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХЦУУЛАЛТЫН АСУУДАЛ



ДХИС-ийн ШШГС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн тэнхимийн багш, магистр, ахмад Ш.Энхжаргал

Ипотек гэдэг нэр томъёо анх МЭӨ 6-р зуунд Афинд үүссэн гэдэг. Эртний Грекийн долоон суут ухаантны нэг Солон Архонт МЭӨ 594 онд алдарт шинэчлэлээ хийх явцдаа гэрээслэл үлдээх эрх чөлөөг бий болгож, газрын өрийг өөрчилсон байна. Тэр үед зээлийн барьцаа нь зээлдэгч өөрөө байдаг байсан бөгөөд өрөө төлж чадахгүй бол боол болох нь энүүхэнд байсан байна. Чухам энэ үед Солон өрөө төлж чадахгүй хариуцлагаа биеэрээ төлдөг байсныг эд хөрөнгөөрөө төлдөг болгох зорилгоор барьцааны өөр хувилбарыг бий болгосон нь орчин үеийн Ипотекийн эхлэл болжээ. Зээл авсан хүний газрын захад шон босгож дээр нь тухайн газар нь тийм хугацаатай тийм хэмжээний зээлийн барьцаа болсон бөгөөд зээлээ төлж чадахгүй бол энэ газар зээлдүүлэгчийн өмч болно гэх зэргээр зээлдэгч, зээлдүүлэгчийн нэр устай хамт бичдэг байж. Чухам энэ холбоосыг ипотек гэж нэрлэдэг байсан байна. Ийм тэмдэг тавиулсан газрын эзэн тухайн газар дээр байгаа эд хөрөнгийг зөөж авч явах эрхгүй байжээ. Гэсэн ч энэ ойлголт цаг хугацааны явцад хувьсан өөрчлөгдөж ипотек гэдэг үгээр зээлийн барьцаа болон дурын үл хөдлөх хөрөнгийг нэрлэдэг болжээ. Түүнчлэн шон босгохоо больж, ипотекийн дэвтэр бий болсон байна.

Мөн эртний Вавилоны хаан Хаммурапын (МЭӨ 1793-1750) хуульд барьцааны тухай заасан байдаг бол Энэтхэгийн Манугийн хуульд (МЭӨ II зуун) шүүхээр хэлэлцэх 18 үндэслэлийн нэг нь барьцаа болох тухай дурдсан байдаг байна.

Ипотек нь Ромын эзэнт гүрний үед улам илүү хөгжжээ. Манай эриний I зуунд хувь хүмүүст зээл олгодог ипотекийн байгууллагууд бий болж, Антонин Пий хааны (МЭ 86-161) үед ипотекийн банкны тухай хуультай болжээ. Төрийн зүгээс ипотекийн зээлд үргэлж том дэмжлэг үзүүлдэг байж. Жишээ нь: Траян хааны (МЭ 53-117) үед өнчин хүүхдүүд, бэлбэсэн эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлэх зорилготой тусгай фонд байгуулж, жилийн 5 хувийн хүүтэй ипотекийн зээл олгодог байжээ.

Ипотек нь харьцангуй богино хугацаанд фидуци (латин хэлний fidusia- итгэл дээр тулгуурласан хэлцэл), арай боловсронгуй үе шат болох пигнус (латин хэлний pignus- албан бус барьцаа), цаашлаад ипотек гэсэн хөгжлийн замыг туулжээ.

Фидуцийн үед барьцаа нь шууд зээлдүүлэгчийн өмчлөлд шилждэг байсан бөгөөд зээлдүүлэгч нь барьцааг зээлдэгч авсан зээлээ төлсний дараа эргүүлж өгөх, эсвэл мөнгө авалгүйгээр зарах эрхтэй байжээ. Пигнусын гэрээнд барьцааны үл хөдлөх хөрөнгө нь зээлдүүлэгчийн өмчлөлд биш, харин зээлээ төлөх баталгаа болгож эзэмшилд нь шилжүүлэх тухай заадаг байж. Зээлдүүлэгч барьцааны хөрөнгийг өөртөө үлдээх эрхгүй байсан ба зөвхөн зээлдэгч авсан зээлээ төлөөгүй тохиолдолд зарж, өрийн үлдэгдлийг суутган, илүү мөнгийг нь эргүүлж өгдөг байжээ.

Ипотекийн хэлцлийн харьцангуй хүнд тогтолцоо нь боловсронгуй бүртгэлийн систем, зохицуулалт шаардаж байсан тул хэлцэлд оролцогчдыг хууль сахиулахад төрийн үүрэг их байсан байна. Эртний хүчирхэг улсуудын эрин үе дуусгавар болж, төрийн эдгээр үүрэг суларснаар ипотек хэдэн зууны туршид алга болсон юм. Дундад зууны үеийн ипотек нь Ромын эрх зүйн уламжлалыг даган баруун Европын орнуудын хууль тогтоомжинд, тэр дундаа Германы эрх зүйд XIV зуунд орж иржээ.

Германы эрх зүй ипотекийг олон нийтийн болгож хэлбэржүүлсэн байна. Тэр үеэс ипотек нь тусгай дэвтэрт бичилт хийсний дараа найдвартай өмчийн эрх зүй болдог

болжээ.

XIX зуунд ипотек орчин үеийн хэлбэрийг олжээ. Ипотекээр дамжуулан төр болон банкууд газрыг хянадаг болсон байна. XIX зууны 2-р хагаст үйлдвэржилт идэвхтэй явагдаж эхлэх үед үйлдвэрийн барилгыг санхүүжүүлэх зорилгоор ипотекийн зээлийг ашиглаж эхэлсэн нь шинэ эрин үе эхэлсний дохио байлаа. АНУ-д ипотек 1930-аад оны их уналтын (great depression) үед орон сууцны зээл хэлбэрээр анх бий болсон түүхтэй. Тэр үеийн АНУ-н Засгийн газар ипотекийг эрсдэл багатай хөрөнгө оруулалт гэж үзжээ. Америкийн ипотек иргэдийн үл хөдлөх хөрөнгөө чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, шилжүүлэх эрхийг хангахад голлон чиглэсэн байна. Ипотекийн зээлийн системд төрийн зүгээс үзүүлэх дэмжлэг маш өндөр байсан ба хувийн хэвшлийнхэн, гадаадын хөрөнгө оруулагчид энэ салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг болсон байна.

2007 онд эхэлсэн АНУ-ын ипотекийн хямрал удалгүй дэлхийн санхүүгийн хямралын гол шалтгаан гэж эрдэмтэн судлаачид үзсэн байдаг. Учир нь хууль батлагдсан нь эрх зүйн боломжийг тодорхой хэмжээгээр нээж өгсөн хэдий ч, аливаа хуулийг хэрэгжүүлэхэд түүнийг хэрэгжүүлэх механизм хамгийн чухал байдаг. Тухайлбал, Хоршооны тухай хууль байна. Механизмыг нь сайтар бүрдүүлээгүй учраас дампуурахад хүрч хичнээн олон зуун хохирогчтой, хэдэн тэрбумын хохирол иргэд, байгууллагад учирч, төрөөс хадгаламж зээлийн хоршоодын эздийн бусдад учруулсан хохирлын 50 хувийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр барагдуулах "Хохирлыг эргэн төлөгдөх нөхцлөөр барагдуулах тухай" хууль хүртэл батлагдан гарахад хүрч байлаа. Үүнтэй адил Америкаас эхлэлтэй моргейжийн хямрал нь зээллэгтээ урьдчилгаа аваагүйтэй холбоотой бөгөөд урьдчилгаагүй зээл өгөхөөр иргэдийн хариуцлага хүлээх байдал суларч, зээлийн эргэн төлөлт буурсантай холбоотойгоор хямрал үүссэн гэж эдийн засагчид, судлаачид тайлбарлаж байна.

Ипотек, Моргейж гэсэн нэр томъёо нь үндсэндээ адилхан. Ипотек нь эх газрын эрх зүйн тогтолцоотой хууль үйлчилдэг улс орнуудад, моргейж нь Англи, Саксоны эрх зүйн тогтолцоотой хууль үйлчилдэг улсуудад түгээмэл мөрдөгддөг. Хоёулаа үл хөдлөх хөрөнгийг барьцаалж, урт хугацааны зээл олгох тухай асуудал юм. Ипотек нь грекээр hypoteke, англиар hypothec-эдэлбэр газар, үйлдвэр, барилга байгууламж, байр ба бусад үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа гэсэн утгатай/.

Монголын түүхэн зарим эх сурвалжийг судлан үзэхэд Чингис хааны Их засаг хуулинд иргэний эрх зүйн холбогдолтой заалтуудад үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэрэгсэл нь тодорхой бус байжээ. 1640 оны Монгол-Ойрдын хуулинд зээлдүүлэгч нь зээлдэгчээс өрөө нэхээд өгөхгүй бол отгийн даргад мэдэгдэж барьцаа авч болохоор заажээ. БНМАУ-ын 1926 оны анхны Иргэний хуулинд "Аливаа эд юмсыг бусад дор барьцаалах тухай" хэсэгт заахдаа "Аливаа юмыг барьцаалуулан өгөх ба авахдаа тусгай бичиг байгуулваас зохихоос гадна, хашаа байшингийн зэрэг үл хөдлөх хөрөнгийг барьцаалсан гэрээ бичгийг зохих албаны газраар газраа мэдүүлэн зохих данснаа тэмдэглэвээс зохимой" гэж заажээ. Ингээд үе үеийн Иргэний хуулинд барьцааны гэрээний зүйл нь үл хөдлөх эд хөрөнгө байж болох тухай заалт орж явсаар 1994 оны Монгол Улсын Иргэний хуулинд ипотекийн зохицуулалтыг анх удаа тусгай зүйл болгон заажээ.

Ипотек нь газарт олгогдож буй эд юмсын хязгаарлагдмал эрх юм. Агуулгын хувьд энэ нь газар дээр олгогдож буй барьцааны эрх мөн . Газар нь аль ч улс оронд тогтвортой найдвартай зээлийн баталгаа болж байсан бөгөөд хэзээд үнэ цэнэтэй байсаар ирсэн зүйл юм. Ийм ч учраас газар, түүнтэй салшгүй холбоотой үл хөдлөх хөрөнгө нь зээлийн баталгааны найдвартай хэрэгсэл болдог.

Үүнийг Монгол Улсын Иргэний хуульд "Бусад үүрэг гүйцэтгүүлэгчдээс тэргүүн ээлжинд өөрийн шаардлагаа хангуулахаар үүрэг гүйцэтгүүлэгч тодорхой үл хөдлөх хөрөнгө барьцаалахыг ипотек гэнэ" гэж тодорхойлжээ. Ипотекийн зүйл нь газар буюу

үл хөдлөх хөрөнгө байдаг учраас Иргэний хуулийн 150.1 дэх хэсэгт заасан барилга байгууламж барих эрхэд ч бас ипотек ногдуулах боломжтой байдаг. Мөн Иргэний хуулийн 108 дугаар зүйлд заасан дундаа хэсгээр өмчлөгчийн ногдох хэсэгт нь ипотекийн үүрэг ногдуулж болно.

Ипотекээр баталгаажсан үүрэг нь дуусгавар болсон бол ипотекийн үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх ч дуусгавар болно. Үүргийн гүйцэтгэлийг хангуулах шаардлагын хүрээнд олон ипотекийн эрх олгож болно. Тэгсэн тохиолдолд өөрийн шаардлагыг хэрэгжүүлэхийн тулд аль газрыг борлуулахаа үүрэг гүйцэтгүүлэгч нь сонгох боломжтой. Эдгээрийн газар буюу үл хөдлөх хөрөнгийн аль нь ч зээлийг бүрэн хариуцна. Мөн газар болон үл хөдлөх эд хөрөнгийн үр шим болон дагалдах хэсгүүдэд ч ипотек нэгэн адил хамаарах талаар хуулинд тусгасан байна.

Ипотекээр баталгаажсан шаардлагын хүү, анз болон шүүхийн зардлыг ипотекийн зүйл нэгэн адил хариуцдаг. ОХУ-ын Иргэний хуулинд Үл хөдлөх эд хөрөнгөд газар, газрын хэвлий, усан обьектууд газартай холбоотой бусад эд хөрөнгө, зориулалтыг нь алдагдуулалгүйгээр шилжүүлэх боломжгүй эд хөрөнгө тухайлбал ой мод, олон наст тарьц, суулгац, байгууламж, түүнчлэн улсын бүртгэлтэй агаарын болон бусад онгоцууд, дотоодод аялах хөлгүүд, сансрын обьектууд зэргийг хамааруулан ойлгодог байна.

Барууны зарим улс оронд хувьцааг үл хөдлөх эд хөрөнгө гэж үздэг түгээмэл хандлага байдаг байна. Учир нь хувьцаа нь өндөр өртгөөр хэмжигддэг, эдийн засагт үзүүлэх ач холбогдлоороо, зээлийн барьцаа болдгоороо, ашиглагдах хугацаа зэргээрээ үл хөдлөх эд хөрөнгө болдог байна. Манай улсын хувьд үнэт цаас нь барьцааны зүйл болох үнэ цэнэтэй, ач холбогдолтой болох хууль эрх зүйн орчин дутмаг байна.

Ипотекийг төлбөр болох байдлаас нь хамаараад эргэлтийн ипотек, хангалтын ипотек гэж ангилдаг байна. Эргэлтийн ипотекийг гэрчилгээтэй шилжүүлэх, гэрчилгээгүй шилжүүлэх гэж ангилдаг бөгөөд гэрчилгээтэй шилжүүлэх ипотек нь баталгаат ипотек болдог байна.

Иргэний хуулийн 167 дугаар зүйлийн 167.1-д Үүрэг гүйцэтгүүлэгч ипотекийн эрхийн бүртгэлийг нотолгоо болгохгүйгээр зөвхөн өөрийн шаардлагыг нотлох замаар ипотекийн эрхээ хангуулахаар хэлэлцэн тохиролцож болох бөгөөд уг ипотекийг улсын бүртгэлд баталгаат ипотек гэж бүртгэнэ гэж заажээ. Тухайлбал: Үүрэг гүйцэтгүүлэгч нь үүрэг гүйцэтгэгчийн өмчлөлд байгаа үл хөдлөх эд хөрөнгийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1.1-д зааснаар хариуцагчийн үл хөдлөх эд хөрөнгийг тухайн нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр битүүмжилсэн тохиолдолд үүнийг улсын бүртгэлд баталгаат ипотек гэж бүртгүүлж болно.

Мөн ипотекийн дараагийн нэг онцлог бол зээлийн баталгаа болгон үүрэг гүйцэтгэгч нь өөрийн газартаа ипотекийн үүрэг ногдуулсан бол тэр үүрэг гүйцэтгэгч газраа гуравдагч этгээдэд шилжүүлсэн байсан ч ипотек үгүй болдоггүй. Газрын шинэ өмчлөгч нь ипотекийг заавал хамтад нь шилжүүлэн авдаг байна. Газар нь шинэ өмчлөгчийн гарт очсон хэдий ч зээлийн баталгааныхаа хувьд үүрэг хүлээнэ.

Үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангах хугацаа болсон, эсхүл үүрэг гүйцэтгэгч үүргийг гүйцэтгэх эрхтэй болсон үеэс буюу хуульд заасан бусад тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөгч үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангах үүрэгтэй. Үүрэг ногдуулсан газрын өмчлөгч буюу ипотекийн үүрэг гүйцэтгэгч нь ипотекийн үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг ипотекийн хэмжээгээр хангах үүрэгтэй. Хэрэв биечлэн үүрэг гүйцэтгэгч болох зээлийн гэрээний үүрэг гүйцэтгэгч нь Иргэний хуулийн 208.5-д заасны дагуу тохирсон хугацаанаас өмнө мөнгөө буцаан төлөх эрхтэй бол газар өмчлөгч ч түүнтэй нэгэн адил эрхтэй байна. Хэрэв биечлэн үүрэг гүйцэтгэгч нь Иргэний хуулийн 213 дугаар зүйлд заасны дагуу төлбөрийг хэсэгчлэн төлөх эрхтэй бол газрын өмчлөгч ч түүнтэй нэгэн адил эрхтэй байна.

Хэрэв газар өмчлөгч нь ипотекоор баталгаажсан төлбөрийг ипотекийн үүрэг гүйцэтгүүлэгчид хийсэн бол Иргэний хуулийн 168.1-д зааснаар өмчлөгчийн ипотек үүсэх бөгөөд үүнийг өмчлөгч үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлээс хасуулах боломжтой юм. Үүний тулд хэрэв түүнд баримт бичиг шаардлагатай бол энэ заалтын дагуу үүрэг гүйцэтгүүлэгчээс шаардлагатай баримт бичиг гаргаж өгөхийг шаардах эрхтэй.

Өмчлөгч нь өөрийн биеэр үүрэг хүлээгээгүй бол барьцаалагчийн зөвшөөрснөөр тухайн үүргийг гүйцэтгэхээр үүрэг хүлээсэн этгээдээс үүргийг өөртөө шилжүүлэн авч болно. Үүрэг хүлээсэн газрын өмчлөгч болон биечлэн үүрэг гүйцэтгэгч нь өөр өөр этгээд байх бөгөөд газар өмчлөгч нь баталгаажсан шаардлагыг ипотекийн үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө биелүүлэх тохиолдол юм.

Иргэний хуулийн 171 дүгээр зүйлд Ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг ашиглахгүй, бусдын өмчлөлд шилжүүлэхгүй, өөр байдлаар гуравдагч этгээдэд эрх олгохгүй байх үүргийг өмчлөгчид хүлээлгэсэн хэлцэл хүчин төгөлдөр бус байна. Ипотекийн зүйлийг өмчлөгчийн гуравдагч этгээдтэй байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрлөөс хамаарна. Үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг бүрэн буюу хэсэгчлэн хангаагүй бол үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх түүнд шилжинэ гэж тохиролцсон хэлцэл хуульд өөрөөр заагаагүй бол хүчин төгөлдөр бус байна гэж заажээ.

Иргэний хуулийн 175-181 дүгээр зүйлүүдэд албадан дуудлага худалдаа болон бусдын удирдлагад шилжүүлэх замаар ипотекийн эрхийг хэрэгжүүлж, үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангах асуудлыг зохицуулсан байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн дуудлага худалдааг зохицуулсан иргэний болон шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн зарим зүйл заалтыг шүүхийн практикт зөв хэрэглэх тухай зөвлөмжид "Шүүхэд шийдвэрлэгдэж буй иргэний эрх зүйн маргаантай хэрэгт үүргийн харилцааны талууд үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ байгуулж, энэхүү гэрээ нь хуульд заагдсан бүхий л шаардлагыг хангасан, хүчин төгөлдөр гэрээ бол нэхэмжлэлийн шаардлагыг барьцааны эд хөрөнгөнөөс гаргуулах тухай заалтыг шүүхийн шийдвэрт заавал тусгаж байхыг шүүхүүдэд зөвлөжээ. Ингэхдээ Иргэний хуулийн 174 дүгээр зүйлд заасан шаардлагыг үүрэг гүйцэтгүүлэгч үүрэг гүйцэтгэгчид тавьсан боловч үүрэг гүйцэтгэгч үүргээ гүйцэтгээгүй, үүрэг гүйцэтгүүлэгч шүүхэд ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн албадан худалдаж, шаардлагаа хангуулах хүсэлт гаргасан байхаар Иргэний хуулийн 175 дугаар зүйлийн 175.1-д заасныг анхаарах нь зүйтэй гэжээ. Улсын Дээд Шүүхийн зөвлөмжид Үл хөдлөх эд хөрөнгийг үүргийн шаардлагыг хангуулахаар барьцаалсан тохиолдолд тухайн үл хөдлөх эд хөрөнгөнөөс шаардлага хангах үндсэн гурван хэлбэрийг хуульд тусгасныг анхаарч тухайн тохиолдол бүр тохируулан зөв хэрэглэж байхыг зөвлөжээ. Ингэхдээ

а) Үл хөдлөх эд хөрөнгийн албадан дуудлага худалдаанд оруулах тухай шүүхийн шийдвэрт тусгахдаа ипотекийн зүйлийг албадан дуудлага худалдаанд оруулах тухай үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлт байхыг шаардсан,

б) Талуудын тохиролцсон өөр хэлбэрийн худалдаа хийхээр шүүхийн шийдвэрт тусгахдаа үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч, үүрэг гүйцэтгүүлэгч харилцан тохирч, шүүхэд хамтран хүсэлт гаргасан байхыг шаардсан,

в) Үл хөдлөх эд хөрөнгийг бусдын удирдлагад шилжүүлэх тухай шүүхийн шийдвэрт тусгахдаа үүрэг гүйцэтгүүлэгч хүсэлт гаргасан байхыг тус тус шаардсан байна.

Иргэний хуулийн 175 дугаар зүйлийн 175.6-д "Дуудлага худалдаа явуулахаар шүүхээс томилогдсон этгээд ....дуудлага худалдааг.....явуулна" гэж заасан тул шүүхийн шийдвэрт энэ талаар заавал дурьдах шаардлагатай юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-д "Үл хөдлөх эд хөрөнгийн дуудлага худалдааг шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн үл хөдлөх эд хөрөнгө байгаа аймаг, нийслэлийн

шийдвэр гүйцэтгэх алба зохион байгуулна" гэж заасны дагуу шийдвэр гүйцэтгэх албыг дуудлага худалдаа явуулах этгээдээр томилон шүүхийн шийдвэрт тусгах нь зүйтэй. Харин дуудлага худалдааг хэнээр эрхлэн хөтлүүлэх нь шийдвэр гүйцэтгэх албаны бүрэн эрх юм.

Иргэний хуулийн 175 дугаар зүйлийн 175.6-д "Дуудлага худалдаа явуулахаар шүүхээс томилогдсон этгээд дуудлага худалдааг шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор явуулна" гэж заасныг ИХШХШТХ-ийн 185 дугаар зүйлд заасан шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх тухай шүүгчийн захирамж гарсан өдрөөс хойш гэж ойлгоно.

Иргэний хуулийн 176 дугаар зүйлийн 176.1-д үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг ипотекийн зүйлийн өмчлөгч эсвэл гуравдагч этгээд хангавал дуудлага худалдаа явуулахыг зогсооно гэж заасан. Үүнийг ШШГА хэрэгжүүлнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2.2-т Үл хөдлөх эд хөрөнгийг шинжээчээр үнэлүүлэхээр заасныг үүрэг гүйцэтгэгч, үүрэг гүйцэтгүүлэгч, өмчлөгч нар үнийн талаар харилцан тохиролцоогүй тохиолдолд буюу Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.1-д заасан нөхцөл бүрдсэн үед хэрэглэнэ.

Шинжээчээс тогтоосон үнэлгээний талаарх гомдлыг төлбөр төлөгч, төлбөр авагч нар үнэлгээ тогтоосноос хойш 7 хоногийн дотор шүүхэд гаргаж болно.

Анхны дуудлага худалдааны үнийг үүрэг гүйцэтгүүлэгч, үүрэг гүйцэтгэгч, өмчлөгч нар харилцан тохиролцсон, эсвэл шинжээчээр тогтоолгосон байдаг бол хоёрдахь дуудлага худалдааны үнэ нь Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.4-т зааснаар дуудлага худалдаа явуулахтай холбогдсон зардал болон үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлагыг хангахад хүрэлцэхүйц байна. Хоёрдахь дуудлага худалдааг явуулаагүй гэж үзэх үндэслэл хуульд зааснаар бүрдвэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.7-д зааснаар албадан дуудлага худалдаагаар борлогдоогүй үл хөдлөх эд хөрөнгийг шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулахад гарсан зардлыг хасч, төлбөртөө тооцон авахыг шийдвэр гүйцэтгэгч үүрэг гүйцэтгүүлэгч буюу төлбөр авагчид санал болгоно.

"Дуудлага худалдаагаар худалдсан үл хөдлөх эд хөрөнгийн үнийг бүрэн төлсөн үеэс эхлэн худалдан авагч тухайн эд хөрөнгийн өмчлөгч болно" гэж заасан байгаа. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх нь хэлцлийн үндсэн дээр нэг этгээдээс нөгөө этгээдэд шилжиж байгаа тохиолдолд өмчлөх эрх хэлцлийг бүртгэлийн газар бүртгүүлснээр үүсдэг бол дуудлага худалдаагаар худалдагдаж байгаа үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авагч тухайн эд хөрөнгийн үнийг төлснөөр өмчлөх эрх үүсдэг.

Иргэний хуулийн 178 дугаар зүйлийн 178.3, 178.4-т газрыг худалдснаар тухайн газарт ногдуулсан байсан ипотекийн эрх бүх эрх дуусгавар болох бөгөөд тэмдэглэгдсэн байгаа бусад бүх эрх хадгалагдаж үлдэнэ. Өөрөөр хэлбэл дуудлага худалдаагаар газар худалдан авч байгаа этгээд ипотекоос бусад бүх үүргийг хамтад нь шилжүүлэн авна гэсэн үг. Хэрэв энэ заалтаар тухайн дуудлага худалдааг санаачилсан үүрэг гүйцэтгүүлэгчээс дараллын хувьд өмнө нь тэмдэглэгдсэн байсан ипотекийн эрх нэгэн адил дуусгавар болно гэж заасан байна гэж үзвэл маш утгагүй юм. Энэ зохицуулалтаар тухайн дуудлага худалдааг санаачилсан үүрэг гүйцэтгүүлэгчээс илүү байдалтай байгаа бусад үүрэг гүйцэтгүүлэгчийн эдийн засгийн ашигтай байдлыг ихээхэн зөрчиж байгаа юм.

Харин энэ тухай Монгол Улсын Дээд Шүүхийн зөвлөмжид дурьдахдаа Үл хөдлөх эд хөрөнгийг хэд хэдэн этгээдэд, хэд хэдэн үүргийн шаардлагыг хангуулахаар барьцаалсан ба энэхүү ипотекийн зүйл нь дуудлага худалдаагаар борлогдон шинэ өмчлөгчид шилжсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийн албан гүйцэтгүүлж байгаа ипотекоос хойш бүртгүүлсэн бусад ипотек болон эд хөрөнгийн хувьд хязгаарласан бүх эрх тухайлбал сервитут дуусгавар болно гэжээ.

Дуудлага худалдааны олсон орлогыг Иргэний хуулийн 179 дүгээр зүйлийн 179.1, 179.2-т зааснаар

• Эхлээд дуудлага худалдааг зохион байгуулахтай холбогдон гарсан зардлыг

• Үүрэг гүйцэтгүүлэгч нарт олгогдвол зохих төлбөрийг бүртгэлийн дараалалаар

• Үлдсэн хэсгийг үл хөдлөх эд хөрөнгө нь дуудлага худалдаанд орсон өмнөх өмчлөгчид хуваарилана.

Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3-т дээрх орлогыг дараах дарааллаар хуваарилахаар заажээ.

- Албадан дуудлага худалдаа явуулсан зардал

- Өмчлөх эрх шилжих хүртэл эрхлэн хамгаалагч үл хөдлөх эд хөрөнгийг хамгаалсан, засварласан зардал

- Тухайн үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдох тогтмол төлөгдөх төлбөр

- Ипотекийн эрхтэй этгээдэд төлөгдөх төлбөр гэж заасан байгаа

Үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа /ипотек/-тай холбогдсон харилцааг Иргэний хуулийн арван гуравдугаар бүлгийн гуравдугаар дэд бүлгээр зохицуулсан боловч энэ нь хэт ерөнхий байгаагаас эрх зүйн зохицуулалтын тодорхой бус байдлыг бий болгож банк, санхүүгийн үйл ажиллагааны эрсдлийг нэмэгдүүлж байна. Иймд үл хөдлөх эд хөрөнгө барьцаалах харилцаанд оролцогч /барьцаалагч, барьцаалуулагч, бүртгэлийн байгууллага, хөрөнгийн үнэлгээчин гэх мэт/-дын хүлээх үүрэг, эдлэх эрхийг нарийвчлан хуульчилж үүргийн гүйцэтгэлийг барьцаагаар хангах зохицуулалтын үр дүнг сайжруулах шаардлагатай байна.

Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалах үр нөлөө бүхий эрх зүйн орчин бүрдээгүй нөхцөлд тус улсад ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг хөрөнгийн зах зээлд татан оролцуулах боломж хязгаарлагдмал байгаа, мөн иргэд өмчийнхөө газрыг барьцаалахтай холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулж өөрийн өмчлөлийн газрыг барьцаалах замаар эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг хуульчлах зэрэг хэрэгцээ шаардлагыг харгалзан үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбогдон үүсэх харилцааг тусгайлсан хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай гэж үзсэнээр Монгол Улсын Их Хурлаас 2009 оны 3 дугаар сарын 3-ны өдөр "Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах арга хэмжээний тухай" тогтоолыг, түүний 2 дугаар хавсралтаар "Нэн тэргүүнд боловсруулж, батлуулах шаардлагатай хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн жагсаалт"-ыг баталсан. Энэхүү жагсаалтын 4-т Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн төслийг боловсруулж, хуулийг батлан гаргаад байна.

Энэ хууль батлагдан гарснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн дараахь үр дагавар гарна хэмээн хуулийн төсөл боловсруулагчид үзэж байна.

1. Үл хөдлөх хөрөнгийн барьцаатай холбогдсон харилцааны эрх зүйн зохицуулалт тодорхой болно;

2. Банк, санхүүгийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үл хөдлөх хөрөнгө барьцаалан зээл олгох сонирхол нэмэгдэнэ;

3. Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээлийн нийлүүлэлт нэмэгдэж хүү буурна;

4. Зээлийн хүү буурснаар иргэд урт хугацаатай орон сууцны зээл авах боломж нэмэгдэнэ;

5. Ипотекийн анхдагч зах зээл төлөвшиж, ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлэх урьдач нөхцөл бүрдэнэ;

6. Ипотекийн хоёрдогч зах зээлээс хөрөнгийн нэмэлт эх үүсвэр олох замаар банк, санхүүгийн байгууллага үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлж, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх боломжтой болно гэжээ.

Уг хуультай бусад хууль тогтоомжийг уялдуулан нэмэлт, өөрчлөлтийг оруулж, Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах заалтыг хүчингүй болгосноор аймаг, нийслэлийн Шийдвэр гүйцэтгэх албадын ажлын ачаалал нэмэгдэх